

**АРИЛЖАА (ХУДАЛДАА)-НЫ ХУУЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДЛАХ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2019 он

Гарчиг

НЭГ. Арилжаа(худалдаа)-ны асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал	5
ХОЁР. Арилжаа(худалдаа)-ны асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал	50
ГУРАВ. Арилжаа(худалдаа)-ны асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал	51
ДӨРӨВ. Арилжаа(худалдаа)-ны хуулийн зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал	60
ТАВ. Арилжаа(худалдаа)-ны хуулийн зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт	61
ЗУРГАА.Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал.....	63
ДОЛОО. Дүгнэлт, зөвлөмж.....	96
Хавсралт 1.....	98

Судалгааны багийн ахлагч

Б.Амарсанаа	МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, проф
-------------	--

Зөвлөх:

Д.Наранчимэг	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан, Отгонтэнгэр Их сургуулийн дэд профессор, доктор
--------------	---

Л.Бямбаа	Монгол Улсын Дээд Шүүхийн шүүгч асан, доктор, өмгөөлөгч
----------	---

Багийн гишүүд:

С.Батбаяр	МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш /LL.M/
-----------	--

Н.Норовсамбуу	МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш /LL.M/
---------------	--

Р.Пүрэвбаатар	МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш /LL.M/
---------------	--

Харьцуулсан судалгаа гүйцэтгэсэн:

ХБНГУ-ын Арилжааны эрх зүй

Д.Энхзул МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн
тэнхимийн ахлах багш /LL.M/

Б.Буянхишиг МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн
тэнхимийн багш /Ass.Juri, LL.M/

ОХУ-ын Арилжааны эрх зүй

Д.Наранчимэг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн
гишүүн асан, Отгонтэнгэр Их сургуулийн
дэд профессор, доктор

Н.Баярмаа Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч /LL.M/

Япон Улсын Арилжааны эрх зүй

Б.Амарсанаа МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, доктор, проф

С.Батбаяр МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн
тэнхимийн багш /LL.M/

Н.Норовсамбуу МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн
тэнхимийн багш /LL.M/

Франц Улсын Арилжааны эрх зүй

Б.Буянхишиг МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн
тэнхимийн багш /Ass.Juri, LL.M/

С.Баяржаргал МУИС-ийн ХЗС-ийн магистрант

Д.Булган МУИС-ийн ХЗС-ийн магистрант /LL.M/

НЭГ. АРИЛЖАА (ХУДАЛДАА)- НЫ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах, зах зээлийн эдийн засаг бүхий дийлэнх улсуудад иргэд хоорондын болон аж ахуй эрхлэгчтэй холбоотой харилцааг ялгамжтайгаар зохицуулсан байдаг. Тиймээс энэхүү судалгааны хүрээнд Арилжаа (Худалдаа)-ны эрх зүйн болон Иргэний эрх зүйн зарчмын ялгааг судалж, манай улсын хууль тогтоомжийн хүрээнд тус зарчмууд хангагдаж байгаа эсэх, арилжааны хуулийн хэрэгцээ шаардлагыг судлан үзнэ.

Арилжааны эрх зүйн онолын хувьд Иргэний хууль ба Арилжааны хууль нь дараах үндсэн зарчмын ялгаатай байна.

Иргэний хууль тогтоомжийн үндсэн зарчим нь эрх тэгш байх, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх, үүргийг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах байдаг.

Арилжааны эрх зүйн үндсэн зарчим нь харилцаанд оролцогч талуудын ашгийн төлөөх зорилгыг хамгаалах, гэрээний эрх чөлөө, хэлцэл хийхэд хялбар зардал багатай бөгөөд түргэн шуурхай байх, хэлцлийн хэлбэрийг тохирох боломжтой уян хатан байх, хэлцлийн найдвартай баталгаат байдлыг хангах, гадаад илэрхийлэлд итгэх буюу хэлцэлд итгэх итгэлийг хамгаалах, хариуцлагатай байх зэрэг зарчмуудыг гол болгодог. Эдгээр зарчмууд нь аж ахуйн үйл ажиллагааны чиглэл зорилгод үйлчилдэг. Жишээлбэл, аж ахуй эрхлэгч аль болох бага зардал үнээр авч, мөн аль болох түргэн, өндөр үнээр буцааж худалдах хүсэлтэй. Энэ нь аж ахуй эрхлэгч бүрийн нийтлэг хэрэгцээг харуулдаг. Энэхүү зарчмуудыг дэлгэрүүлэн Арилжааны эрх зүйд дараах онцлогуудыг харгалзан зохицуулалтын объектийг ялгамжтай тогтоодог.

А. Аж ахуйн үйл ажиллагаа гэдэг нь аль болох боломжит дээд хэмжээний ашиг олох зорилготой тул аж ахуй эрхэлж буй арилжаа эрхлэгч /худалдаачин/-ийн үйл ажиллагаа нь зарчмын хувьд нэмэлт орлого олоход чиглэдэг. Гадаад улсын Арилжааны хууль (эсхүл Арилжааны шинжтэй эрх зүйн хэм хэмжээ)-д заасан хүүгийн хэмжээ Иргэний хуульд заасан хүүгээс илүү байдаг зэрэг нь аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөө гэсэн зарчимд үндэслэгддэг.

Б. Аж ахуйн үйл ажиллагааг явуулахад арилжааг түргэн шуурхай явуулах шаардлага тавигддаг ба Арилжааны хуулиар гэрээ байгуулах санал, түүнийг хүлээн зөвшөөрөх саналыг илүү хялбар, түргэн шуурхай зохицуулах, хөөн хэлэлцэх хугацааг Иргэний хуульд зааснаас Арилжааны хуульд илүү бага байхаар тогтоох зэрэг аж ахуй эрхлэгчдийн харилцааг хялбар бөгөөд түргэн шуурхай байлгах тусгай зохицуулалтыг тусгадаг.

В. Олон тоогоор дахин давтагдан хийгддэг арилжааны үйл ажиллагаа буюу хэлцлийг үр дүнтэй удирдан явуулахын тулд аж ахуйн холбоотой харилцааг хэлбэршүүлэх нь оновчтой байдаг. Тухайлбал хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн нэрсийг бүртгэдэг, жагсаалт хөтөлдөг зэрэг хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн тогтолцоо зэрэг нь үүний илрэл юм.

Г. Арилжааны хуулиар аж ахуйтай холбоотой тодорхой мэдээлэл бүртгэх, түүний зарим хэсгийг нийтэд нээлттэй мэдээлэх зэргээр арилжааны нөгөө талд хохирол учрахаас сэргийлдэг (Нээлттэй байх зарчим). Түүнчлэн гадаад ирэлхийлэл, хэлбэр нь бодит агуулгатай нийцэхгүй тохиолдолд гадаад хэлбэрт итгэсэн этгээдийг хамгаалах зохицуулалтыг тусгадаг. Өөрөөр хэлбэл төлөөлөх бүрэн эрхгүй байсныг мэдээгүй болон мэдэх боломжгүй байсны улмаас хэлцэл хийсэн нөгөө талыг хамгаалах зарчим юм.

Д. Аж ахуйн үйл ажиллагаа нь санхүүгийн тооцоонд үндэслэж явагдах учраас талууд өөрсдийн чөлөөт хүсэл зоригт үндэслэж гэрээ байгуулах боловч талуудын хоорондын ашиг алдагдлын харьцаа зохистой байх ёстой. Тиймээс арилжаатай холбоотой Арилжааны эрх зүйн зохицуулалт нь талуудын хүсэл зориг тодорхойгүй байх тохиолдолд түүнийг нөхөж зохицуулах замаар үйлчилдэг ба өөрөөр хэлбэл сайн дурын зохицуулалт буюу диспозитив зарчим давуу үйлчилдэг.

Е. Арилжаа эрхэлж буй аль нэг тал нь өөрсдийн олохоор тооцсон эдийн засгийн үр өгөөжийг эрсдэлээс хамгаалахын тулд Арилжааны хуулиар аж ахуй эрхлэгчийн хариуцлагыг чангатгах зохицуулалтыг тусгадаг байна.

Иймд дээрх Арилжаа (Худалдаа)-ны эрх зүйн зарчмуудад хамаарах асуудал манай улсын хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан талаар дэлгэрүүлэн авч үзье.

1. АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОДОРХОЙЛОХ АСУУДАЛ

Монгол Улсын Иргэний хуульд “аж ахуйн үйл ажиллагаа” гэх нэр томъёо 8 удаа, “аж ахуйн зориулалт” гэх нэр томъёо 15 удаа удаа, “аж ахуйн” гэх нэр томъёо 33 удаа давтагдан хэрэглэгджээ. Энэ нь одоо хэрэгжиж буй Иргэний хуулийн хүрээнд аж ахуйн үйл ажиллагааны онцлогт нийцсэн зарим хэм хэмжээг бий болгосныг харуулдаг. Өөрөөр хэлбэл хувийн эрх зүйн ердийн харилцааг зохицуулах нийтлэг зохицуулалт болон аж ахуйн харилцааг зохицуулах тусгай зохицуулалт Иргэний хуульд зэрэгцэн оршиж байна. Хэдийгээр Иргэний хуульд аж ахуйн харилцааны онцлогт нийцсэн тусгай зохицуулалт байгаа хэдий ч хангалтай тодорхой, ойлгомжтой, системчлэлтэй эсэх, түүнчлэн өнөөгийн бизнесийн харилцааны онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэх нь анхаарал татсан асуудал юм. Цаашлаад ер нь аж ахуйн үйл ажиллагааг ердийн хувийн эрх зүйн харилцаанаас хэрхэн ялгах вэ гэдэг нь суурь асуудал болж байна. Энэ тухай дэлгэрүүлэн авч үзье.

Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны 1 сарын 15-ны өдөр өөрийн цахим хуудсанд дараах мэдээллийг гаргасан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6-р зүйлийн 6.1.1-д “Хороо нь **санхүүгийн үйлчилгээ**тэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих”, 6.1.3-д “**санхүүгийн үйлчилгээ эрхлэх** тусгай зөвшөөрөл олгох, ...тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих “ бүрэн эрхтэй гэж хуульчилсан. Түүнчлэн Хороонд санхүүгийн зах зээлийн хөгжил, тогтвортой байдлыг хангах чиг үүргийг оноосон бөгөөд холбогдох хууль, тогтоомжийн дагуу Хороо үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн болон хадгаламж, зээлийн хоршооны зах зээл, эдгээр салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн хэрэгслүүдийг бүртгэн баталгаажуулж, хянан зохицуулж ажилладаг.

Хурдацтай хөгжиж буй мэдээллийн технологи, интернэт, олон нийтийн сүлжээ ашиглан өндөр хүү амлаж, иргэдээс хөрөнгө, мөнгө татах явдал цөөнгүй гарсаар байна. Тухайлбал, 2018 оноос “Н” ХХК, “Но” ХХК зэрэг байгууллага зохицуулалтгүй, хууль бус үйл ажиллагааг “эрсдэлгүй хөрөнгө оруулалт”, “даатгагдсан хөрөнгө оруулалт” гэх мэтээр сурталчлан явуулах боллоо. Холбогдох хууль тогтоомжоор “хөрөнгө оруулалтын хэрэгсэл”-ийг Хороо тогтоох төдийгүй үнэт цаас, нэгж эрх зэрэг санхүүгийн аливаа хэрэгслийг Хороо бүртгэж, зөвшөөрөл олгохоор хуульчилсан байдаг. Иймд Хорооны зохицуулалтад хамаараагүй, холбогдох зөвшөөрөл, эрх аваагүй хууль бус үйл ажиллагаагаа таслан зогсоохыг дээрх байгууллагуудад хариуцлагатайгаар мэдэгдэж байна.

Дээрх тохиолдолд “санхүүгийн үйлчилгээ эрхлэх” гэдгийг хэрхэн тодорхойлох нь асуудал юм. Энэ талаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.1-д “банк бус санхүүгийн байгууллагын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа” санхүүгийн үйлчилгээнд хамаарна гэсэн ба Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7-р зүйлийн 7.1.1-д “зээл”-ийг банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж ойлгохоор хуульчилсан байна. Энд зээлийн гэрээ байгуулж буй үйлдэл болгоныг санхүүгийн үйлчилгээ эрхлэх гэж хэлэх үү, ямар шалгуураар санхүүгийн үйлчилгээ эрхлэх буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулж байна гэж тогтоох вэ гэсэн асуулттай тулгарна.

Иргэний хуулиар аливаа этгээд бусдаас зээл авах, бусдын мөнгийг хадгалж болох тул зээл авах, мөнгө хадгалж хүү амлах хэлцлийг аж ахуйн үйл ажиллагаа болгож хийж буй байдлыг ердийн тохиолдлоос ялгах нийтлэг зохицуулалт Иргэний хуульд байхгүй байгаа нь юуг аж ахуйн үйл ажиллагаа гэж үзэх талаар тодорхойгүй, ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

ХБНГУ-д Аж ахуйн үйл ажиллагаа (Gewerbebetrieb) гэдгийг дараах агуулгаар тодорхойлдог байна.

№	Gewerbebetrieb – Аж ахуйн үйл ажиллагаа	Тайлбар
1	Offene Tätigkeit -Нээлттэй үйл ажиллагаа	Гадагш чиглэсэн буюу зах зээлд аж ахуйн үйл ажиллагаагаа санал болгох
2	Planmäßige Tätigkeit –Төлөвлөгөөтэй үйл ажиллагаа	Үйл ажиллагаа нь төлөвлөгөөтэй үргэлжилсэн шинжтэй байх
3	Erlaubte Tätigkeit–Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа	Үйл ажиллагаа нь хуулиар хориглосон, нийтийн зан суртахуунд харш байж болохгүй
4	Auf Gewinnerzielung gerichtet (h.M.)–Ашиг олоход чиглэсэн	Ашиг олох зорилготой байх нь чухал бөгөөд бодитоор ашиг олох эсэх нь

		хамааралгүй
5	Selbstständige Tätigkeit – Бие даасан үйл ажиллагаа	Үйл ажиллагаагаа хэзээ явуулах, хаана явуулах, ямар агуулгаар явуулахаа бие даан шийдэж байх

Гэхдээ аж ахуйн үйл ажиллагаа гэдэгт чөлөөт мэргэжлийн үйл ажиллагаа хамаардаггүй. Тухайлбал өмгөөлөгч, эмч, архитектерын үйл ажиллагааг хамааруулдаггүй байна.

Аж ахуйн үйл ажиллагаа гэх ойлголт нь худалдааны хэлцэл гэх ойлголтоос өргөн хүрээтэй ойлголт юм. 1998 оны ХБНГУ-ын Худалдааны хуулийн нэмэлт өөрчлөлтөөр худалдааны хэлцэл гэх ойлголтыг өргөтгөн аж ахуйн үйл ажиллагаа (Gewerbebetrieb) явуулж буй бүхий л этгээдийг худалдаачин гэж үзэхээр болсон байдаг¹.

Английн нэрт эдийн засагч Колин Кларк/Colin Clark/-ийн эдийн засгийн ангиллын дагуу авч үзвэл худалдааны эрх зүй анх үүсэж хөгжихдөө аж үйлдвэрийн хоёрдогч (secondary sector of industry), гуравдагч (tertiary sector of industry) хэв шинжийг сууриа болгож хөгжсөн².

Хэдийгээр уламжлалт худалдааны эрх зүйн зохицуулалтын хүрээнд хөдөө аж ахуй, уул уурхай гэх мэт аж үйлдвэрийн анхдагч хэв шинжийг агуулсан аж ахуйг хамааруулдаггүй байсан боловч энэ чиг хандлага өөрчлөгдөн хамааруулж авч үзэх явдал гарч байна. Тухайлбал ХБНГУ-ын Худалдааны хуулийн 3-р зүйлд зааснаар хөдөө аж ахуйн салбарт аж ахуй эрхэлдэг этгээд аж ахуй эрхлэгчээр бүртгэгдэх боломжийг нээж өгсөн байна.

Түүнчлэн аж ахуйн үйл ажиллагаанд үндсэн үйл ажиллагаанаас гадна аж ахуйн үйл ажиллагааг санхүүжүүлэх, ажиллах хүч авах зэрэг тухайн үйл ажиллагаанд туслах шинжтэй үйл ажиллагаа мөн хамаардаг.

2. АЖ АХУЙ ЭРХЛЭГЧИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ АСУУДАЛ

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” хэмээн хуульчилснаар бизнесийн байгууллагын хэлбэр харгалзахгүйгээр чөлөөтэй аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжтой болсон. Үндэсний Статистикийн хорооноос гаргасан 2018 оны 1-р улирлын Ажиллах хүчний судалгаагаар Монгол Улсад нийт 1,142,900 хүн ажил эрхэлж байгаагаас 269,500 хүн буюу нийт ажил эрхэлж буй хүн амын 23.5 хувь нь хувиараа аж ахуй эрхлэгч байна.³

¹ (1) Kaufmann im Sinne dieses Gesetzbuchs ist, wer ein Handelsgewerbe betreibt.

(2) Handelsgewerbe ist jeder **Gewerbebetrieb**, es sei denn, daß das Unternehmen nach Art oder Umfang einen in kaufmännischer Weise eingerichteten Geschäftsbetrieb nicht erfordert. (<http://www.gesetze-im-internet.de/hgb/BJNR002190897.html#BJNR002190897BJNG000300300>)

² Харин аж үйлдвэрийн анхдагч хэв шинж (primary sector of industry)²-д хамаарах газар тариалан, мал аж ахуй, уул уурхай эрхлэх нь худалдааны үйл ажиллагаанд хамаардаггүй. Учир нь байгалиас шууд түүхий эд материалыг хураан авч худалдан борлуулж, хэрэглэж байдаг тул худалдааны үйл ажиллагаанд байдаг бусдаас төлбөртэйгээр бараа материалыг олж аван цааш дамжуулан худалдах гэсэн шинж байдаггүй болохоор юм.

³ УСХ, “Ажиллах хүчний судалгаа 2018, 1-р улирал” 2018, 10 тал.

Гэтэл манай орны хувьд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх нэгдсэн тогтолцоо байхгүй бөгөөд зөвхөн хуулийн этгээдийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн хэлбэрийг бүртгэснээр хязгаарлагдаж байна. Өөрөөр хэлбэл Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасан ашгийн төлөө хуулийн этгээд болох компани, нөхөрлөлийн хэлбэрээр бизнесийн буюу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэдэг байна. Тухайлбал Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо нь иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээс бүрдэнэ” гэж заасан.

Үүнээс үзэхэд Иргэний бүртгэл нь иргэний төрсөн, нас барсан, шилжсэн, үрчилсэн, гэрлэсэн зэрэг хувь иргэнд чиглэсэн бол хуулийн этгээдийн бүртгэл нь зөвхөн хуулийн этгээд хэлбэрээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой бүртгэл хийдэг. Харин эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл нь иргэн, хуулийн этгээд харгалзахгүйгээр хуулиар бүртгүүлэх шаардлага тавигдсан эд хөрөнгийг бүртгэж, өмчлөх эрхийг баталгаажуулдаг бүртгэл байна.

Манай орны хувьд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай анхны хууль 2003 онд батлагдсанаас хойш нийт 9 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, 2018 онд шинэчилсэн найруулгыг баталсан юм. Уг хууль нь 8 бүлэг, 28 зүйлтэй бөгөөд Монгол Улсад хуулийн этгээд шинээр үүсэн байгуулагдсан, өөрчлөн байгуулагдсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бичгээр болон цахим хэлбэрээр бүртгэх, иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгох, улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл нь хязгаарлагдмал хүрээнд хийгддэг байна. Манай улсын хувьд хуулийн этгээд болон аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хэд хэдэн бүртгэл байх боловч хоорондоо харилцан хамааралгүй, сайн дурын шинж бүхий зөвхөн тухайлсан нэг харилцааг зохицуулахад чиглэгдсэн бүртгэл байдаг. Тухайлбал, хуулийн этгээдийн хэлбэрээр байгуулагдаж бүртгэгдсэн хуулийн этгээд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн нь Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлэх боловч тус бүртгэл нь сайн дурын бүртгэл юм. Түүнчлэн, Инновацийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу “Эрдэм шинжилгээний байгууллага дэргэдээгарааны компани байгуулж болно”, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны №174 дүгээр тогтоол “Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам”-д заасны дагуу гарааны компани байгуулахдаа Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулах боловч тус журмын 3.2-т зааснаар гарааны компанийн мэдээллийг инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээдэг. Иймд дээрх хуулиудад заасан бүртгэл нь улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамаарахгүй бүртгэл юм.

Түүнчлэн, зөвхөн хуулийн этгээдийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан аж ахуй эрхлэгчийг бүртгэснээр дээр дурдсан нийт ажиллах хүчний 23.5 хувийг эзэлж буй хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэдэггүйгээс гэрээ хэлцлийн баталгаат байдал, гэрээний нөгөө талын хаяг, эд хөрөнгийн байдал, үйл ажиллагаа явуулдаг эсэх, жижиг дунд хэмжээний бизнес эрхлэгчийг дэмжих хөнгөлөлттэй зээл тусламжид хэрхэн хамруулах, ямар журмаар орлого, зарлагын тайланг хүлээн авах, татвар ногдуулах зэрэг олон асуудал шийдвэрлэгдээгүй өдийг хүрч байна.

Өөрөөр хэлбэл Арилжааны хуулийн зарчим болох хэлцлийн найдвартай, баталгаат байдлын зарчим нь бүртгэлийн тогтолцоогоор дамжин хэрэгжих замаар нөгөө талын эрх ашгийг хамгаалдагт оршдог бол хувиараа аж ахуй эрхлэгчийн бүртгэлийн тогтолцоо байхгүй нь тус зарчим бүрэн хангагдах боломжгүй болгодог. Түүнчлэн аж ахуй эрхлэгчийн бүртгэл нь аж ахуй эрхлэгчийн бизнесийн баталгаат байдал, тэдгээрийн хэлцлийн хурдан шуурхай, найдвартай байдлыг хангахад чиглэгддэг боловч одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд зөвхөн хуулийн этгээдийн хувьд дээрх зорилго хангагдах боломжтой байна.

Нөгөө талаар манай улсад компани, нөхөрлөл байгуулахгүйгээр хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн тоо жил бүр нэмэгдэж, үүнийг дагалдан далд эдийн засаг үүсгэх сөрөг нөхцөлийг үүсгэж байна. 2015 онд Монголбанкны Валют, эдийн засгийн газраас явуулсан судалгаагаар нэр бүхий томоохон худалдааны төвүүд болон Нарантуул, Барс, Дүнжингарав, Бөмбөгөр захуудад 8423 лангуу түрээслэн худалдаа эрхлэгч байгаа нь тогтоогдсон. Үүнээс гадна жижиг, дунд хэмжээний худалдааны төв, валют арилжааны зах, түүхий эд бэлтгэл, худалдан борлуулах захууд зэрэг судалгаанд ороогүй олон тооны хувиараа аж ахуй эрхлэгчид байгаа.

Тухайлбал дээрх судалгаагаар Монгол Улсын хэмжээнд сард дунджаар 27.5 сая ам.долларын валют урд болон хойд хөршүүдээс импортын бараанд төлөгддөгөөс 19.2 сая ам.долларын импортын дүн нь гаалийн байгууллагад мэдүүлдэггүй⁴ гэсэн байна. Үүнээс үзэхэд бага бус хэмжээний бэлэн валют урд болон хойд хөршүүдээс импортын бараа бүтээгдэхүүн худалдан авахад зарцуулагддаг боловч хэдий хэмжээний бараа орж ирсэн, ямар хэмжээний борлуулалт хийгдсэн талаар мэдэх боломжгүй байна.

Түүнээс гадна одоо хүчин төгөлдөр үйлчилж буй бүртгэлийн хууль тогтоомж болох Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хуулийн этгээдийн зарим төрлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосноор аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа бусад аж ахуй эрхлэгчийн хувьд хэлцлийн найдвартай, баталгаат байдал, хэлцлийн мөнгөн болон мөнгөн бус зардлыг бууруулах зэрэгт томоохон ач холбогдолтой өөрчлөлт болсон ч аж ахуй эрхлэгч хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой асуудлууд бүрэн шийдэгдээгүй байна.

Тухайлбал, хуулийн этгээдийн мэдээлэл буруу бүртгэгдсэнээс үүдэн бүртгэлд итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдийг хэрхэн хамгаалах, бүртгэл хүчингүй болсноос өмнөх хэлцлийн үр дагаврыг хэрхэн шийдвэрлэх, бүртгэлийн талаар мэдээгүй буюу мэдэх боломжгүй нөхцөлд гэрээ хэлцэл хийсэн зэрэг асуудлыг зөвхөн Иргэний хуульд нийцүүлэн шийдвэрлэх нь аж ахуйн үйл ажиллагааг түргэн шуурхай явагдахгүй байх, маргаан үүсгэх, гэрээ хэлцлийн тогтворгүй байдлыг бий болгож зардлыг нэмэгдүүлэх үр дагаварт хүргэж байна. Одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд компанийн хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хувь бүртгэлийн байгууллагад буруу бүртгэгдсэний улмаас тухайн хувьцаа эзэмшигч нь гуравдагч этгээдийн хувьд шийдвэр гаргах эрхтэй гэж ойлгогдсон тохиолдолд тус бүртгэлд итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн хэлцэл хүчинтэй эсэх маргаан үүсдэг. Энэ тохиолдолд бүртгэл буруу хийгдсэн үндэслэлээр бүртгэлийг хүчингүйд тооцох нь түүнд үндэслэсэн хэлцэл хүчингүй болох нөхцөл болдог.

⁴ Монголбанкны Валют, Эдийн засгийн газар “Үүргийн худалдаа” /Түүвэр судалгаа/ 2015, 11 тал.

Түүнчлэн, Компанийн тухай хуулийн 70 дугаар зүйлд “хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах”-аар зохицуулсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсөн шийдвэр гаргаж, гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн тохиолдолд өөр нэг хувьцаа эзэмшигч тухайн хурлын зар хүргэхдээ хууль зөрчсөн гэж үзээд хурлыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргадаг. Гэтэл шүүхээд тухайн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчингүйд тооцвол тухайн хурлаас гарсан шийдвэр нь хүчингүйд тооцогдоно. Гэтэл өмнөх шийдвэр хүчинтэй гэж итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдтэй хийсэн хэлцэл Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан хууль зөрчсөн хэлцэл, 56.1.10-т заасан “хүчин төгөлдөр бус хэлцлийг үндэслэж хийсэн бусад хэлцэл хүчин төгөлдөр бус байх” нөхцөлийн дагуу хүчин төгөлдөр бус болдог.

Эдгээр асуудал нь зөвхөн бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналтын чиг үүргээс илүүтэй Арилжааны эрх зүй дэх хэлцлийн баталгаатай байдал, шударга гуравдагч этгээдийн хэлцэлд итгэх итгэлийг хамгаалах зарчимд харшлах үндэслэл болдог. Иймд аж ахуй эрхлэгчийн бүртгэлээр дамжин бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгосноор аж ахуй эрхлэгчдийн хэлцэл баталгаат, түргэн шуурхай, найдвартай хийгдэх боломжийг олгодог ач холбогдолтой.

3. АРИЛЖААНЫ НЭРТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Арилжааны нэр нь аж ахуй эрхлэгч арилжааны үйл ажиллагаандаа ашиглаж өөрийгөө илэрхийлж буй нэр юм. Түүнчлэн худалдааны хамтрагч болох нөгөө талын хувьд арилжааны нэрэнд төөрөгдөхгүй, түүнээс ямар нэгэн хохирол хүлээхгүй байх зэрэг шаардлагын үүднээс эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах хэрэгцээг бий болдог. Өөрөөр хэлбэл арилжааны нэр нь нийгэм болон эдийн засгийн харилцаанд оролцогчдын итгэлийг хадгалах арга хэрэгсэл бөгөөд арилжаа эрхлэгчийн хувьд ч эдийн засгийн үр өгөөжөө нэмэгдүүлэхэд дэм болж байдаг. Түүнчлэн аж ахуй эрхлэгч өөрийн үйл ажиллагаандаа арилжааны нэрийг ашигласнаар хэлцлийн найдвартай байдал, гадаад илэрхийллийг нөгөө талд бий болгосноор итгэлийг хамгаалах зарчмыг хэрэгжүүлэх үндэс болдог.

Арилжааны нэр нь эдийн засгийн үр өгөөж бий болгодог утгаараа эд хөрөнгийн эрхэд тооцогдож түүнийг өвлүүлэх, бэлэглэх, шилжүүлэх, бусад этгээдийн эрх зөрчих үйлдлээс хамгаалах зэрэг эрх зүйн хамгаалалт шаардлагатай болдог. Түүнчлэн бизнесийн хамтрагч болох нөгөө талын хувьд арилжааны нэрэнд төөрөгдөхгүй, түүнээс ямар нэгэн хохирол хүлээхгүй байх зэрэг шаардлагын үүднээс эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах хэрэгцээ бий болгохоос гадна аж ахуй эрхлэгчийг нэрлэх, танин мэдэх, бараа бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, мэдээллийг түгээх, ялгаатай байдлыг бий болгох, хариуцлага хүлээх эрх зүйн үр дагаврыг үүсгэх зорилготой.

Онолын хувьд арилжааны нэр сонгох эрхийг гурван үндсэн ангилалд хуваадаг ба 1) Арилжааны нэр шударга байх зарчим, 2) Арилжааны нэр чөлөөтэй байх зарчим, 3) Холимог зарчим юм. Арилжааны нэр шударга байх зарчим гэдэг нь арилжааны нэр нь тухайн худалдаачны нэр, бизнесийн үйл ажиллагаа, үйл ажиллагаа явуулж буй газар нутаг зэрэгтэй тохирсон байх ёстой бөгөөд арилжааны нэрийг шилжүүлэх, өв залгамжлуулах зэргийг зөвшөөрдөггүй. Харин арилжааны нэр чөлөөтэй байх зарчим нь ямар нэгэн хязгаарлалт байхгүй ба Холимог зарчмын хувьд арилжаа эрхлэгчийн нэр, үйл ажиллагааны төрөлтэй зохицсон байхыг шаардах боловч үйл ажиллагаагаа

шилжүүлэх, бэлэглэх, өв залгамжлуулах, арилжаа эрхлэгчийн овог нэр өөрчлөгдөх, үйл ажиллагааны төрлөө өөрчлөх зэрэгт өмнөх худалдааны тэмдэгээ үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрдөг онцлогтой.⁵

Гэтэл манай улсын хувьд арилжааны нэр гэх ойлголтыг зохицуулаагүй байх бөгөөд Иргэний хууль дахь хуулийн этгээдийн оноосон нэр, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль дахь барааны тэмдгийн алинд нь хамаарах эсэх нь тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “барааны тэмдэг гэдэг нь иргэн, хуулийн этгээдийн өөрийн үзүүлж буй бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг” ойлгох бол хуулийн этгээдийн нэр нь тухайн хуулийн этгээдийг бусад хуулийн этгээдээс ялгах чадварыг илэрхийлдэг.

Дээрхээс үзэхэд барааны тэмдэг гэдэгт арилжааны нэр хамаарахааргүй бөгөөд Иргэний хууль дахь хуулийн этгээдийн оноосон нэртэй илүү төсөөтэй ойлголт юм. Гэсэн хэдий ч хуулийн этгээдийн оноосон нэр нь өөрөө бие даасан барааны тэмдэгт хамаарах эсэх нь тодорхойгүй, хуулийн этгээдийн оноосон нэр олгох субъект, барааны тэмдгээр бүртгэж, гэрчилгээжүүлэх субъектүүд нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон Оюуны өмчийн газар байдаг.

Иймд хуулийн этгээдийн нэрээр дамжуулан аж ахуй эрхэлж буй этгээдийг бусдаас ялгах, өөрийн нэрийг хуулиар хамгаалуулах, бусдад ашиглуулах замаар ашиг олох боломжид саад учруулдаг. Өөрөөр хэлбэл хуулийн этгээдийн нэр болон арилжааны нэр нь барааны тэмдэгт хамаарах талаар эрх зүйн зохицуулалтгүйгээс хуулийн этгээдийн ижил төстэй нэр олгох, бусад этгээд тухайн нэрийг өөрт ашигтайгаар ашиглах замаар бусдыг төөрөгдүүлэн ашиг олох үйлдлүүд гарч байгааг шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргаанаас тодорхой харж болно. Тухайлбал, Монгол Улсын Их сургууль болон Монголын Үндэсний их сургууль гэсэн нэр нь хуулийн этгээдийн оноосон нэр боловч англи хэлэн дээр аль аль нь ижил нэр томъёогоор илэрхийлэгддэг. Зөвхөн англи хэлэнд бус монгол хэлний хувьд ч улсын болон үндэсний гэх хоёр үг ялгаатай мэт боловч нэг ижил сургууль мэтээр ойлгогдох тохиолдол цөөнгүй.

Түүнчлэн өөр нэгэн жишээ нь “Бодь” ХХК болон “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд үүссэн Бодь нэрийг аль нь давуу эрхтэйгээр ашиглах тухай маргаан юм. Энэ хэрэг нь бүртгэлийн маргаан гэж үзэж Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэх явцад захиргааны эрх зүйн маргаан бус иргэний эрх зүйн маргаан гэж үзэж Иргэний хэргийн шүүхэд шилжүүлсэн. Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн магадлалд “хуулийн этгээдийн оноосон нэр нь барааны тэмдэгт хамаарахгүй, оюуны өмчийн хамгаалагдах эрхийн объектэд хамаарахгүй” гэж зааснаас үзэхэд арилжааны нэрийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой зохицуулаагүйгээс шүүхээр шийдвэрлэгдэж буй маргааны хүрээнд хуулийн этгээдийн нэр нь барааны тэмдэгт хамаарахгүй, оюуны өмчөөр хамгаалагдах объект биш гэж үзсэнээс тодорхой харж болно.

⁵落合誠一、大塚隆児（2007年）「商法Ⅰ－総則・商行為」、49－53頁。

“Бодь ” гэдэг үгийн утгыг хэл зүйн толь бичигт “хар хоргүй, амарлингуй, бодь сэтгэл”, “бодь хүн, бод гөрөөс амьтан” гэсэн 2 утгаар тайлбарласан байх бөгөөд уг үг нь Монгол хэлний үгсийн санд багтаж, түгээмэл хэрэглэгддэг үг байх тул “Бодь ” гэх нэрийг барааны тэмдгийн нэгэн адил хамгаалагдах оюуны өмч гэж үзэх боломжгүй юм.

Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн 8 дугаар зүйлд “Холбооны гишүүн бүх оронд аж ахуйн нэгжийн нэрийг барааны тэмдгийн бүрдэлд орсон эсэхээс үл хамааран түүнийг мэдүүлэг гаргахыг шаардахгүйгээр эсхүл бүртгэлгүйгээр хамгаална” гэж заасан ба уг заалтад нэхэмжлэлийн шаардлагад зааж буй “Бодь” гэх нэрийг барааны тэмдгийн адил хамгаалах объект гэж үзэхгүй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт зааснаар зохигч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаархи нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэг хүлээдэг бөгөөд “Бодь ” гэх нэрийг оноосон нэр болгон барааны тэмдгийн болон хуулийн этгээдийн өмчийн /нэрийн/ хамгаалалтад орсон гэдгийг нэхэмжлэгч тал нотолж чадаагүй болно.⁶

2016.10.13-ны №1672 тоот “Бодь” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Бодь Интернэшнл” ХХК-д холбогдох Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн магадлалын үндэслэл хэсгээс

Гэтэл “Бодь” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Бодь Интернэшнл” ХХК-ийн маргааныг Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хурлаас тус маргаан нь захиргааны эрх зүйн маргаан бус иргэний эрх зүйн маргаан гэдэг үндэслэлээр Иргэний хэргийн шүүхийн харьяалалд шилжүүлсэн байна. Харин тус маргаантай агуулгын хувьд адил нэгэн маргааныг Захиргааны хэргийн шүүх анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн хуралдаанаар эцэслэн шийдвэрлэсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн /2003 он/ 2 дугаар зүйлийн 2.1-д “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасны дагуу хуулийн этгээд байгуулах, түүнийг улсын бүртгэлд бүртгэх, улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцаанд Иргэний хууль эрх зүйн эх сурвалж болох бөгөөд Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т зааснаар хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан байж болохгүйгээс гадна бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байхыг хориглосон /зөвшөөрөөгүй/ байна.

Тухайн тохиолдолд, “Airmarket” гэх гадаад үгийг кирилл үсгээр хэрхэн /“Эйрмаркет”, “Аэрмаркет” гэж/ илэрхийлснээс үл хамааран тухайн нэрийг ижил /адил/ гэж үзэх бөгөөд энэхүү нэрийн өмнө болон хойно өөр оноосон нэрийг нэмснээр ялгагдах боломжтой боловч “говь” гэсэн бүс нутаг, байршил заасан үгийг оруулснаар нэг салбарт үйл ажиллагаа явуулах компаниудын хувьд бусдыг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй гэж үзэхээр болжээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газар нь “Эйрмаркет говь” нэр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн өөр хуулийн этгээдийн нэртэй давхцаагүй боловч “бусдыг төөрөгдөлд оруулахаар ижил төсөөтэй” байгааг анхаарч үзэлгүй нэрийн баталгаажуулалтын хуудас олгож, тухайн нэрээр хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэн нь Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасантай нийцээгүй, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байна.

Нөгөөтэйгүүр, Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцын 8 дугаар зүйлд “аж ахуйн нэгжийн нэрийг барааны тэмдгийн бүрдэлд орсон эсэхээс үл хамааран түүнийг мэдүүлэг гаргахыг шаардахгүйгээр эсхүл бүртгэлгүйгээр хамгаална” гэж заасан ба тус конвенцид Монгол Улс нэгдэн орж, 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталж Монгол улсын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөгдөхөөр байх тул анхан шатны шүүх маргааны үйл баримтад дээрх конвенцын холбогдох заалтыг хэрэглэсэн нь үндэслэлтэй болжээ.

⁶ www.shuukh.mn

2016.11.23-ны №403 тоот “Аэрмаркет” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт холбогдох, “Говь Эйрмаркет” ХХК-ийн гуравдагч этгээдээр оролцсон Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоолын хэсгээс

Дээрх шүүхийн тогтоолоос үзэхэд арилжааны нэртэй холбоотой маргаан нь зарим тохиолдолд бүртгэлтэй холбоотой буюу захиргааны хэргийн маргаан, зарим тохиолдолд оюуны өмчтэй холбоотой буюу иргэний эрх зүйн маргаан гэж үзэж шийдвэрлэж байгаа нь арилжааны нэрийн тодорхой зохицуулалтгүйгээс аж ахуй эрхлэгч арилжааны нэрийг ашиглах явцад үүсч буй маргаануудыг шийдвэрлэхэд хүндрэл үүсгэх нь дамжиггүй.

Түүнчлэн хувиараа аж ахуй эрхлэгч нь аж ахуйн үйл ажиллагаандаа бусдад ялгарах арилжааны нэр ашиглах боломжтой бөгөөд хуулийн этгээдийн нэгэн адил арилжааны нэрээр дамжуулан бараа, бүтээгдэхүүний мэдээллийг түгээх, сурталчлах, бусдаас ялгах шаардлагатай бөгөөд эдийн засгийн эргэлтэд оруулах замаар ашиг хүртэх боломжтой байдаг. Харин манай улсын хувьд зөвхөн хуулийн этгээдийн хувьд хуулийн этгээдийн оноосон нэрийг авч ашиглах эрхтэй боловч хувиараа аж ахуй эрхлэгчийн хувьд арилжааны нэртэй байх, түүнийг ашиглах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Гэтэл хуулийн этгээдийн оноосон нэр нь арилжааны нэрийн хувьд барааны тэмдэгийн хамгаалагдах эрхийн объектэд хамаарснаар аж ахуй эрхлэгч өөрийн бизнесийн нэрээ зөвхөн дотоодод төдийгүй олон улсад хамгаалуулах, тухайн нэрийг бусдад гэрээний үндсэн дээр шилжүүлэх, ашиглуулах замаар ашиг олох боломжийг олгодог ч манай улсын эрх зүйн зохицуулалтын хувьд арилжааны нэрийг зохицуулаагүй орхигдуулсан байна.

4. ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Дараагийн нэг асуудал нь Иргэний хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт юм. Хөөн хэлэлцэх хугацаа гэдэг нь эрх зүйн харилцаанд баталгаат байдлыг бий болгох, эрх зүйн үүднээс тодорхой хугацаа өнгөрснөөр маргаан гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь үүрэг гүйцэтгэгч тодорхой хугацаа өнгөрсний дараа хуучирсан өр нэхэгдэхээс хамгаалах нь шударга гэж үздэгт оршино. Учир нь хэлцэл хийснээс хойш хэдий их хугацаа өнгөрнө төдий чинээ хуучин шаардах эрхийн эсрэг өөрийгөө хамгаалах боломжгүй болж, үйл явдал бүдгэрдэг. Нөгөө талаас зарим тохиолдолд иргэний эрх зүйн харилцаанд хэт богино хөөн хэлэлцэх хугацаа сонгох тохиолдолд тухайн эрх зүйн харилцааг хамгаалж, хэлцлийг биелүүлэх бодит ашиг сонирхлын тогтолцоо бий болгоход чиглэгддэг.⁷

Ялангуяа, аж ахуй эрхлэгчдийн хоорондын хэлцлийн харилцаа түргэн, шуурхай, хариуцлагатай байхад үндэслэдэг тул иргэд хоорондын хэлцлээс үүсэх шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаанаас илүү богино хугацааг тогтоодог жишиг байна. Өмнө дурдсанчлан Иргэний хууль гэдэг нь иргэн, хуулийн этгээд, аж ахуй эрхлэгч гэж ялгамжтайгаар зохицуулдаггүй ямар ч субъектэд адил үйлчлэх ерөнхий хууль тул хөөн хэлэлцэх хугацааны хувьд ч нэгэн адил ерөнхий хугацаагаар зохицуулдаг. Гэтэл хоёр иргэний хооронд хийгдэх гэрээ хэлцэл, иргэн аж ахуй эрхлэгч, аж ахуй эрхлэгч аж ахуй

⁷ Б.Тэмүүлэн нар, “Иргэний эрх зүйн ерөнхий анги” 2013, 275 тал.

эрхлэгчтэй хийх хэлцлээс үүсэх харилцааны хувьд талуудын хүлээх үүрэг, хүчин төгөлдөр байх хугацаа нь нэгэн адил байх боломжгүй, ялгамжтай авч үзэх нь зохистой юм.

Тухайлбал, иргэн өөрийн хэрэгцээнд таарсан зөөврийн компьютер авахдаа тухайн зөөврийн компьютерийн хүчин чадал, програм хангамжийн, доторх эд ангийн талаар нарийн мэдлэгтэй байж, заавал түүнийг шалгаж авах үүргийг хүлээх боломжгүй. Өөрөөр хэлбэл худалдан авагч иргэнд заавал тухайн зөөврийн компьютерийн талаар мэдлэгтэй байх үүрэг оногдуулбал бүх иргэдийг зөөврийн компьютерийн талаар нарийн мэргэшсэн байхыг шаардахтай адил ойлголт юм.

Гэтэл компьютер худалдаалдаг аж ахуй эрхлэгчийн хувьд нийлүүлэгчээс олон тооны зөөврийн компьютерийг худалдан авахдаа жирийн иргэнээс илүү үүргийг хүлээх шаардлагатай. Тухайлбал, шалган авах үүргээ биелүүлээгүйгээс хэдэн жилийн дараа ямар нэгэн доголдолтой байсан гэх шалтгаанаар маргаан үүсгэх нь арилжааны үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй байх шинжид сөрөг нөлөөг үзүүлдэг. Иймд иргэн өөрийн хэрэгцээнд эд зүйл худалдан авах, аж ахуй эрхлэгч ашиг олох зорилгоор худалдан авах үйлдэл нь талуудын хүлээх үүрэг, гомдол гаргах хугацаа, хөөн хэлэлцэх хугацааны хувьд ялгамжтай байх шаардлагатай.

Манай улсын эрх зүйн зохицуулалтын хувьд гэрээний талуудын хүлээх үүрэг, хариуцлага, шаардлага гарах хөөн хэлэлцэх хугацааны хувьд субъектийн ялгамжгүй нэгэн адил зохицуулсан нь чөлөөт зах зээлийн тогтолцоо бүхий улсын хувьд аж ахуй эрхлэгчийн хооронд маргаан үүсэх, маргаанаас үүдсэн бизнесийн алдагдал ихсэх зэргээр сөрөг нөлөөллийг үзүүлдэг. Харин гэрээний нэг тал нь санаатайгаар бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний доголдлыг нуун дарагдуулсан бол ялгамжтай зохицуулалт хамаарахгүй байна.

Өөрөөр хэлбэл иргэд хоорондын хэлцлээс үүсэх харилцаатай харьцуулахад аж ахуй эрхлэгчдийн хоорондын хэлцлийн хөөн хэлэлцэх хугацаа богино байх нь хэлцэл илүү түргэн, шуурхай явагдах бөгөөд энэ нь аж ахуй эрхлэгч маш олон тооны этгээдтэй гэрээ, хэлцэл хийснээс үүсэх маргаан гарахгүй байх, маргаан үүссэн ч аль болох шуурхай шийдвэрлэгдэх ач холбогдолтой. Ингэснээр Арилжааны хуулийн хэлцэл түргэн, шуурхай бөгөөд найдвартай, хариуцлагатай байх зарчмыг хангах үндсэн нөхцөл болно.

Түүнчлэн хөөн хэлэлцэх хугацаанаас ялгаж үзэх ёстой зүйл нь гомдлын шаардлага гаргах хугацаа юм. Хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа уг шаардах эрх үүссэнтэй холбоогүй, зөвхөн эсрэг талын татгалзах эрхийн улмаас уг шаардлагыг хэрэгжүүлэх боломжгүй болдог бол гомдлын шаардлага гаргах хугацаа өнгөрмөгц уг эрх үүсэх ч бололцоогүй болно. Тиймээс гомдлын шаардлага гаргах хугацаа нь шаардах эрхийг үгүйсгэх нөхцөл болдог.

Дээр дурдсанчлан манай улсын эрх зүйн зохицуулалтын хувьд хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоогоогүй ч гомдлын шаардлага гаргах хугацааны хувьд ялгамжтай байхаар зохицуулсан зүйлүүд байдаг. Тухайлбал Иргэний хуулийн 254 дүгээр зүйл буюу “худалдах, худалдан авах гэрээний доголдлоос үүсэх шаардах эрх”-ийн хувьд 254 дүгээр зүйлийн 254.6-д “Худалдагч эд хөрөнгийн баталгаа тогтоосон бол энэ хугацааны дотор, баталгаат хугацаа тогтоогоогүй бол тухайн эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэн авснаас хойш 6 сарын дотор доголдлыг илрүүлсэн худалдан авагч нь

энэ хуулийн 254.1-т заасан шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй” байхаар заасан бол 255 дугаар зүйлийн 255.1.2 дахь хэсэгт “аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь уг үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийг шилжүүлэн авах үедээ нэн даруй шалган авах үүргээ биелүүлээгүй бол шаардлага гаргах эрхээ алдана” гэж заасан. Өөрөөр хэлбэл дээрх зохицуулалт нь хэлцлийн оролцогч талууд болох иргэн, аж ахуй эрхлэгч этгээд гэдгээр тэдний хүлээх үүргийг ялгамжтайгаар зохицуулсан боловч Иргэний хууль хувь хүн, хуулийн этгээдийн харилцааг хамтад нь зохицуулсан учир аж ахуй эрхлэгч гэдэгт ямар субьектийг ойлгох асуудал тодорхойгүйгээс дээрх зохицуулалтуудыг ялгаж хэрэглэхэд хүндрэл үүсдэг.

Тухайлбал, 2016 оны 11-р сарын 14-ний өдрийн 01079 дугаар бүхий шийдвэртэй хэргийн хувьд нэхэмжлэгч “Акума Эрин” ХХК-н зүгээс “МГВХЭ” ХХК-тай худалдах худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлд 16.200.000 төгрөгийг гарлуулахаар нэхэмжлэл гаргасан байдаг ба хариуцагчийн зүгээс уг эд хөрөнгө нь доголдолтой байсан тул гэрээнээс татгалзаж нэхэмжлэгчид төлсөн 2.000.000 төгрөгөө гаргуулахаар сөрөг нэхэмжлэл гаргасан байдаг. Шүүхээс тухайн эд хөрөнгийг шилжүүлэх үед доголдолтой байсан хэмээн үзэж Иргэний хуулийн 254.6, 256.1-ийг баримтлан 6 сарын дотор гомдлын шаардлага гаргасан хэмээн үзэж сөрөг нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна.

Хариуцагчийн худалдан авсан барааг зориулалтаар ашиглах боломжгүй, тоо хэмжээний хувьд тохироогүй тул М.Лханаа гомдлын шаардлага гаргаж барааг буцаах хүсэлт гаргасан нь гомдлын шаардлагыг 6 сарын дотор гаргах тухай Иргэний хуулийн 254 дүгээр зүйлийн 254.6-д нийцсэн ба хариуцагчийг биет байдлын доголдолтой бараа авсан гэж үзнэ. Хариуцагч барааны доголдлыг арилгуулах хүсэлт гаргасныг нэхэмжлэгч хүлээж аваагүй тул гэрээнээс татгалзаж барааны үнэд төлсөн 2 000 000 төгрөг, зардал нэхэмжилсэн нь үндэстэй. Иргэний хуулийн 254 дүгээр зүйлийн 254.1-д зааснаар худалдан авагч гэрээг цуцлах тухай шаардлага гаргах эрхтэй. Худалдан авсан эд хөрөнгийн доголдолтой холбогдуулан гэрээг цуцлах тохиолдолд худалдагч нь худалдан авагчид учирсан хохирол зардлыг нөхөн төлөх үүрэгтэй. Иймд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, сөрөг нэхэмжлэлийг хэсэгчлэн хангаж Акума-Эрин ХХК-аас 2 300 000 төгрөг гаргуулан хариуцагчид олгуулахаар зааж шийдвэрлэв.

2016.11.14-ны №01079 тоот Нэхэмжлэгч “Акума Эрин” ХХК-н нэхэмжлэлтэй “МГВХЭ” ХХК-д холбогдох Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгээс

Иймд энэхүү судалгаагаар аж ахуй эрхлэгчийн бүртгэл, арилжааны нэр, хөөн хэлэлцэх хугацаа нэмэх зэрэг аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэхийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэв.

5. ТӨЛӨӨЛӨХ БҮРЭН ЭРХИЙН ТАЛААРХ АСУУДАЛ

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Иргэний хууль батлагдаж, өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа билээ. Тус хуулийн 62-70 дугаар зүйлд буюу хуулийн 7 дугаар бүлэгт Төлөөллийн харилцааг зохицуулсан байна. Гэвч эдгээр зохицуулалтын хүрээнд “аж ахуй эрхлэгч” хоорондын хэлцэлд төлөөлөхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тусгаж өгөөгүй байна.

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т “Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно”, 26.5-т “Хуулийн этгээдийн удирдах байгууллагын эрх зүйн байдлыг хууль буюу үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно” гэж тус тус заасан.

Иргэний хууль дахь тус зохицуулалтын дагуу хуулийн этгээдийн удирдах байгууллага, тухайн хуулийн этгээдийг хэлцэлд төлөөлөхтэй холбоотой зохицуулалтыг агуулсан: Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, 28 дугаар зүйл, 32 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл, 84 дүгээр зүйл зэрэг хүчин төгөлдөр үйлчилж байна.

Гэвч хуулийн этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй удирдах байгууллагаас гадна, шүүхийн болон шүүхийн бус аливаа үйл ажиллагаа, хэлцэлд төлөөлөх ерөнхийлсөн бүрэн эрх олгогдсон этгээдийн талаар, түүний төлөөлөх бүрэн эрхийн талаар зохицуулсан хэм хэмжээ одоогоор хуульчлагдаагүй байна. Жишээ нь компанийн хувьд үйл ажиллагаа хариуцсан захирал, хүний нөөц хариуцсан захирал, хууль, эрх зүйн газрын захирал, борлуулалтын албаны дарга гэх мэт албан тушаал бий. Эдгээр албан тушаалын хувьд тухайн компанитай гэрээ байгуулах замаар компанийн тухайн нэг үйл ажиллагааны талаарх шүүхийн болон шүүхийн бус аливаа төлөөлөх бүрэн эрхийг эдэлж болно.

Харин манай улсын хувьд ихэнх тохиолдолд зөвхөн гүйцэтгэх захирлыг л итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхтэй этгээд гэж тайлбарлах байдлаар бусад этгээдийн бүрэн эрхийг ерөнхий байдлаар бус тусгайлсан байдлаар зохицуулах нь түгээмэл байна. Гэтэл эдгээр захирал, менежер, дарга гэх мэт албан тушаалтай этгээд нь бусадтай гэрээ байгуулах, хэлцэл хийх тохиолдолд тэдгээрийн төлөөлөх бүрэн эрхийг тодорхойлоогүйгээс гуравдагч этгээд төдийгүй, үүнээс үүдэн арилжаа, бизнесийн үйл ажиллагааны тогтвортой, түргэн шуурхай явагдах, найдвартай байдал хангагдах явдалд тодорхой хүндрэл учирч байна.

Одоогийн байдлаар дээрх харилцааг тухайн хуулийн этгээдийн дүрэм, гэрээ, дотоод журмаар л зохицуулж байгаа бөгөөд үүнийг тухайн хуулийн этгээдтэй хэлцэл байгуулах гэж буй аж ахуй эрхлэгч мэдэх боломжгүй байгаа юм.

Иргэний хуулин дахь төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлийн талаарх зохицуулалт нь иргэн хоорондын хэлцлийн талаарх зохицуулалт бөгөөд энэ нь аж ахуй эрхлэгч хоорондын хэлцлийн харилцаанд төдийлөн тохиромжгүй болно.

Учир нь Иргэний хуулин дахь зохицуулалт нь аж ахуй эрхлэгчийн тодорхой онцлогийг тусгаагүй байна. Мөн хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн хувьд өөрийн эрхэлж буй үйл ажиллагааны тодорхой хэсгийг бусад этгээдэд бүрэн эрх олгох байдлаар хэрэгжүүлсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар мөн нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

ТНИ ХХК-ийн зүгээс Улаанбаатар хотод олон улсын арга хэмжээ зохион байгуулагдахтай холбогдуулан өөрийн байранд үйл ажиллагаа явуулж байсан Т Банк-д АТМ-ээ шилжүүлэн байрлуулах шаардлагыг тавьсан байна. Үүний хариуд Т Банкны тус салбарын захирал нь АТМ шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн компанид “хөлсийг нь өгчих, АТМ-г шилжүүлэх зардал зөвшөөрөгдөх юм шиг байна” гэсэн хариу өгчээ.

Тиймээс ТНИ ХХК АТМ-ийг шилжүүлэх зардлыг гүйцэтгэгч Ө ХХК-д төлж, Ө ХХК нь Т Банкны тус салбарын захирал ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

ТНИ ХХК нь үүний дараа Т Банк-нд хандаж, мөнгөө шаардсан боловч салбарын захирал өөрчлөгдсөн гэсэн хариу авсан байна. Ингээд ТНИ ХХК нь Т банкид хандаж тухайн хөлсийг төлөхийг шаардсан нэхэмжлэлийг гаргасан байна.

Хариуцагч болох Т банкны хувьд шүүхэд гаргасан тайлбартаа “салбартай л харьцаж байсан байна. Салбар нь бие даасан, төв банкныг төлөөлөх эрх бүхий хуулийн этгээд биш, зөвхөн гүйцэтгэх захирал л ийм эрхтэй” гээд тус банкны гэрээ бүртгэх, хянах журамд зааснаар “зөвхөн орон нутгийн салбарын захирал ажил гүйцэтгэх гэрээ байгуулж болно” гэж заасан байдаг гэсэн байна.

2018 оны 04 сарын 04 өдрийн Дугаар 649 Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шийдвэр

6. ӨРСӨЛДӨХГҮЙ БАЙХ ҮҮРГИЙН ТАЛААРХ АСУУДАЛ

Манай улсын хувьд тодорхой аж ахуйн нэгжид ажиллаж байсан этгээд тухайн аж ахуйн нэгжээс гарч, адил төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн ажилтан болсон тохиолдолд эсхүл өөрөө тийм төрлийн аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг байгуулсан бол өөрийн өмнө ажиллаж байсан аж ахуйн нэгжтэй өрсөлдөхгүй байх үүргийг ногдуулсан хуулийн зохицуулалт дутмаг байна.

Жишээ нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлд дараах байдлаар зохицуулсан байдаг⁸.

84.4.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

84.4.6.компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх.

84.5.Компанийн эрх бүхий албан тушаалтан компанитай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд өөрөөр заагаагүй бол албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш гурван жилийн туршид энэ хуулийн 84.4.6-д заасан үүргийг хүлээнэ.

Монголын томоохон компани болох М компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Б нь адил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг С компанийн гүйцэтгэх захирлаар ажиллах болсон гэх мэт тохиолдлууд байна.

Компанийн тухай хуулийн дээрх зохицуулалтаас харвал өмнө ажиллаж байсан компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх үүргийг компанийн эрх бүхий албан тушаалтан (Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх

⁸ Мөн Байгууллагын нууцын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Байгууллагын нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн этгээд уул нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.” гэж заасан байна.

удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг субъектууд байна)-нд хүлээлгэсэн боловч, адил төрлийн аж ахуйн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд түүнийг ямар нөхцлийн дагуу хориглох талаар нарийвчлан зохицуулаагүй байна.

Жишээ нь аливаа аж ахуйн нэгж нь өөрийн эрхлэн явуулдаг байсан аж ахуйн тодорхой нэг үйл ажиллагаагаа бусад аж ахуйн нэгжид шилжүүлсэн тохиолдолд буюу тухайн аж ахуйн нэгжийн эрхийг өөр аж ахуйн нэгж залгамжлан авсан бол өөрийн аж ахуйн үйл ажиллагааны эрхээ шилжүүлсэн аж ахуйн нэгж нь шилжүүлэн авсан аж ахуйн нэгжтэй өрсөлдөхүйц үйл ажиллагаа явуулахгүй байх үүргийг хүлээлгэх тохиолдолд ямар урьдчилсан нөхцлийг хангасан байх шаардлагатай болох талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Энэхүү өрсөлдөхгүй байх үүргийг үүргийн эрх зүйн ерөнхий ангийн хүрээнд судалж, бусдын эрхийг хамгаалах ерөнхий үүрэг, онцгой үүргийн хүрээнд авч үзэх, зохицуулах боломжийг онолын төдийгүй, практикийн түвшинд судлан үзэх шаардлагатай байна.

7. АЖ АХУЙ ЭРХЛЭГЧИЙН АШГИЙН ТӨЛӨӨХ ЗОРИЛГЫГ ХАНГАХ АСУУДАЛ

Аж ахуй эрхлэгчийн хувьд зорилго нь ашиг олох явдал бөгөөд эрх зүйн тогтолцоогоор үүнийг дэмжих ёстой. Гэвч одоо хэрэгжиж буй Иргэний хуулийн хүрээнд аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах эрх зүйн орчин хангалттай бүрдсэн үү гэдэг нь сонирхол татсан асуудал юм. Иргэний эрх зүйгээс арилжааны эрх зүйн гол ялгарах шинж нь ашгийн төлөөх зарчмыг сууриа болгож буйд оршдог. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдийн үйл ажиллагаа нь ашгийн төлөө эсвэл ашгийн бус байж болох бөгөөд аль алинд нь үйлчлэх ерөнхий зохицуулалтууд байдаг. Харин арилжааны эрх зүйн зохицуулалт нь ашгийн төлөө үйл ажиллагааг дэмжих, тус зорилгыг хангахад чиглэгдэнэ.

7.1 ХҮҮ ШААРДАХ ЭРХ

Иргэний хуулийн 222-р зүйлийн 222.5 дахь хэсэгт “Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй” гэж заасан байдаг. Манай улсын шүүхийн практикт “тохирсон хүү” гэх ойлголтыг хэрхэн ойлгох талаар талууд гэрээгээр тохиролцож “тохирсон хүү” гэж үзэх үү, эсвэл гэрээгээр тохиролцсон эсэхээс үл хамаарах хуульд заасан хүү юу гэсэн асуудал маргаан дагуулдаг.

Уг заалтад заасан “тохирсон хүү” гэдгийг судлаачдын зүгээс хуульд заасан хүү гэж тайлбарлах хандлага ажиглагдаж байна. Энэ тухай Б.Буянхишиг “Хүү төлөхөд чиглэсэн үүрэг нь хуульд зааснаар эсвэл гэрээний тохиролцоонд тусгаснаар үүсдэг. Жишээ нь ИХ-ийн §222.5 мөнгөн төлбөрийн үүргийн хугацааг хэтрүүлсэн бол хуульд заасан хүүг төлөх тухай, мөн ИХ-ийн §§281, 282-т зээлийн гэрээгээр талууд хүү тохирч болохыг тусгасан⁹”, Л.Банзрагч “Үүрэг гүйцэтгэгч хугацаа хэтрүүлэх гэсэн агуулгаар зохицуулагдсан нь зөвхөн гэрээний үүрэгт хамаарахгүй харин гэрээний болон гэрээний бус үүргийн аль алинд нь хамаарах зохицуулалт болохыг харуулж байна. Ийнхүү бүхий

⁹ Б.Буянхишиг “Үүргийн эрх зүйн ерөнхий анги” нэмж засварласан хоёр дахь хэвлэл, УБ хот, 2017 он, 82 дахь тал

л үүрэгт хамааралтай гэдэг утгаараа гэрээгээр тохирсон хүү бус харин хуулиар тогтоосон хариуцлагын шинжтэй хүү болох нь тодорхой байна”¹⁰ гэж тус тус авч үзжээ.

Энэ хандлагыг дагаад шүүхийн практик мөн уг заалтыг хуульд заасан хүү шаардах эрх олгосон заалт гэж тайлбарлах байдал ажиглагдаж байна.

Гэвч дээрх байдлаар уг заалтын агуулгыг талууд гэрээгээрээ тохирсон хүүгийн тухай бус хуульд заасан хүүг зохицуулж буй гэж тайлбарлах нь учир дутагдалтай юм. Ялангуяа Иргэний хуулийн 1-р зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх зарчмын үүднээс авч үзвэл уг заалтыг үүрэг гүйцэтгэгч мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол шууд хүү шаардах эрхийг үүрэг гүйцэтгүүлэгчид олгож буй заалт гэж тайлбарлах огт шаардлагагүй юм. Учир Иргэний хуулийн үндсэн тогтолцоо нь хэрвээ үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол түүнээс учирсан бодит хохирлыг нөхөн төлүүлэх байдаг. Шууд хүү тооцох ёстой гэсэн тайлбар нь бодит хохирлыг нөхөн төлүүлэх Иргэний хуулийн үндсэн зарчимд нийцэхгүй. Иймд уг заалтыг талууд гэрээндээ мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол хүү төлөхөөр талууд тохирсон тохиолдолд хэрэглэх нь гэрээний эрх чөлөө болон бодит хохирлыг нөхөн төлүүлэх зарчимтай нийцэх юм.

Харин Арилжааны эрх зүйн хувьд аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах үүднээс аж ахуй эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд гэрээгээр тохиролцсон эсэхээс үл хамааран хуульд зааснаар хүү шаардах эрхтэй байх нь зөв юм. Аж ахуй эрхлэгч нь мөнгөн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хугацаанд нь авсан бол аж ахуй эрхэлдэггүй этгээдтэй харьцуулахад тухайн мөнгийг ашгийн төлөөх үйл ажиллагааныхаа эргэлтэд оруулан үр шимийг хүртэх нь ойлгомжтой. Иймд хуульд зааснаар хүү шаардах эрхийг автоматаар үүсдэг тогтолцоог арилжааны эрх зүйн хэм хэмжээгээр бий болгох шаардлагатай байна. Нөгөө талаас Иргэний хуулийн 222-р зүйлийн 222.5 дахь хэсгийг хуульд заасан хүү шаардах эрх гэж тайлбарлаж буй нь зарим талаараа практикт нийцсэн тайлбар бөгөөд энэ нь аж ахуй эрхлэгч хуульд зааснаар хүү шаардах эрхийг автоматаар олж авах эрхтэй байхаар хуульчлах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

7.2 ХУУЛЬД ЗААСАН ХҮҮГИЙН ХЭМЖЭЭ

Иргэний хуулийн 222-р зүйлийн 222.5 дахь хэсгийг хуульд зааснаар хүү шаардах эрхийг олгож буй заалт гэж тайлбарласнаар үүсэж буй асуудал нь “тохирсон хүү” гэдэгт хэр хэмжээний хүүг ойлгох вэ гэсэн асуудал шүүхийн практикт гарч байна.

Дээрх тохиолдлоос харахад тохирсон хүүгийн хувь хэмжээг шүүгчийн зүгээс тухайн хэрэгт тохируулан тогтоож байна. Ийнхүү “тохирсон хүү” гэх тодорхойгүй, ерөнхий нэр томьёо хэрэглэсэн нь хуулийн зохицуулалтыг уян хатан байдлаар хэрэглэх боломжийг нээж өгч буй бөгөөд хууль тогтоогчийн урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдалд тухай бүр шүүхээс зохистой шийдвэр гаргахад ач холбогдолтой заалт болно.

¹⁰ Л.Банзрагч “Үүрэг гүйцэтгэгч хугацаа хэтрүүлсний үр дагавар буюу хүү төлөх үүрэг ” Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2017, №3, 77 дахь тал

Харин аж ахуй эрхлэгчийн хувьд ийм тодорхойгүй зохицуулалтын үйлчлэлд байх нь зохисгүй байдаг. Учир нь аж ахуй эрхлэгч нь орлого, зарлагаа тооцох ёстой бөгөөд хир хэмжээний өр төлөөс үүрч буйгаа мэдэх боломжтой байх ёстой. Иймд аж ахуй эрхлэгчийн хувьд эрх зүйн харилцааг тодорхой болгох үүднээс хуульд заасан хүүгийн хэмжээг тодорхой зааж өгөх шаардлагатай.

Хүүгийн хэмжээг тодорхой зааж өгөөгүй улмаас нэхэмжлэгч тал хүү шаардах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүрч байна.

Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.9, 56.5-д зааснаар зээлийн гэрээг хүчин төгөлдөр бус байх хэлцэл гэж үзэж “Б” ХХК-аас 1.900.974.000 төгрөг гаргуулж, “У” ХХК-д олгуулахаар шийдвэрлэсэн.

“Б” ХХК нь дээрх шийдвэрийн дагуу боломжит хугацаанд төлөөгүй, шүүхийн шийдвэр гарснаас хойш 11 сарын дотор буюу 345 хоногийн дараа төлж дуусгасан.

Иймд “У” ХХК нь “Б” ХХК-аас шүүхийн шийдвэрийн дагуу төлбөл зохих 1,900,974,000 төгрөгийг ердийн боломжит хугацаанд төлөөгүйтэй холбогдуулан Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.5 дахь хэсэгт “Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй” гэж заасныг үндэслэн уг авлагад жилийн 18 хувийн хүү тооцож нийт 303,058,979 төгрөг 51 мөнгийг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг гаргажээ.

- **Анхан шатны шүүх:** нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.
- **Давж заалдах шатны шүүх:** “Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.5 дахь хэсэгт заасныг баримтлан хариуцагч “Б” ХХК-иас 166,335,225 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч “У” ХХК-д олгож, нэхэмжлэлийн шаардлагын үлдэх 136,723,755 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчилсөн.
- **ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**
- 2018 оны 06 сарын 19 Дугаар 001/ХТ2018/01008 Улаанбаатар хот

Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.5-д заасан зохицуулалт нь үүрэг гүйцэтгүүлэгч нь хуулиар тогтоогдсон хамгийн бага хохирлоо нөхөн төлүүлэх боломжийг бий болгосон ба нэхэмжлэгч УБ хотын банк нь 18 хувийг “тохирсон хүү” гэж тооцохдоо гэрээнд заасан нөхцлийг хэрэглэсэн нь үндэслэл муутай, хуульд нийцээгүй, шүүх Иргэний хуулийн 222.5 дахь хэсгийг зөв тайлбарлан хэрэглэж чадаагүй байна.

Давж заалдах шатны шүүх Монгол банкнаас 2013 оны 6 дугаар сард бодлогын хүү 10.5 хувь байхаар тогтоосон, нийтэд илэрхий үйл баримт гэж дүгнэн, хариуцагчийн шүүхийн шийдвэрт заасан мөнгөн төлбөрийг гүйцэтгэж эхэлсэн өдөр хүртэл хугацаанд жилийн 10.5 хувиар хүү тооцож, 166,335,225 төгрөгийг хариуцагч байгууллагаас гаргуулж нэхэмжлэгчид олгохоор анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулахдаа шүүх Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.5-д заасныг үндэслэл бүхий тайлбарлаагүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасныг зөрчсөн байх тул хяналтын шатны шүүхээс магадлалыг хүчингүй болгов.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2013 оны 10 сарын 29-ний өдрийн тогтоол

Энэ тохиолдолд хүүгийн хэмжээний асуудал хөндөгдөхөөс гадна “Б” ХХК нь “У” ХХК-д 1.900.974.000 төгрөгийг 2013 оны 10 сарын 29-ний өдрийн шийдвэр гарснаас хойш 11 сарын дотор буюу 345 хоногийн дараа төлж дууссан боловч шүүхээс “У” ХХК-ийн шаардлагыг огт хангаагүй нь “мөнгө унтдаггүй” гэсэн аж ахуйн харилцаанд байдаг ердийн ухамсарыг зөрчиж байна. Энэ нь одоогийн Иргэний хуулийн “ерөнхий” зохицуулалтын хүрээнд аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах явдал нь төвөгтэй байгааг харуулна.

7.3 ХӨЛС ШААРДАХ ЭРХ

Аж ахуй эрхлэгч бусдын өмнөөс аливаа үйл ажиллагаа явуулсан, хэлцэл хийсэн бол гэрээндээ хөлс авахаар тодорхой тохиролцоогүй байсан ч түүний ашгийн төлөөх

зорилгыг хангах үүднээс хуульд зааснаар зохих хөлс авах боломжтой байх ёстой. Иргэний хуулийн үүргийн ерөнхий ангийн зохицуулалтад энэ талаар тодорхой зохицуулалт байдаггүй. Харин иргэний хуулийн гэрээний тусгай төрөл тэр дундаа бусдад ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээнд дараах зохицуулалтууд байна.

№	Гэрээний төрөл	Иргэний хуулийн зохицуулалт	Тайлбар
1	Ажил гүйцэтгэх гэрээ	343.1.Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ. 344.1.Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ болон хөлс төлөх арга, журам, хугацааг талууд тохиролцон тодорхойлно. 344.2.<u>Ажил гүйцэтгэсний хөлсийг талууд тохиролцоогүй боловч гүйцэтгэсэн ажлын шинж, ажил гүйцэтгэх болсон нөхцөл байдал</u> зэргээс шалтгаалан захиалагч тухайн төрлийн ажил гүйцэтгэхэд мөрддөг эрх бүхий байгууллагаас баталсан жишиг үнэлгээний жагсаалт байвал тухайн жагсаалтыг үндэслэн, тийм жагсаалт байхгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнэлгээгээр бодож хөлс төлнө. <u>358.1.Ажил гүйцэтгэх тодорхой төрлийн бүх гэрээнд энэ бүлгийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.</u>	Хөлсний талаар гэрээгээр шууд тохироогүй байхад хөлс төлөхийг зөвшөөрч буй боловч энэ нь гүйцэтгэсэн ажлын шинж, ажил гүйцэтгэх болсон нөхцөл байдал зэргийг шүүх үнэлж тогтоохоор байна. Энэ заалт нь Иргэний хуулийн 358-р зүйлийн 358.1-т заасны дагуу ажил гүйцэтгэх төрлийн бүх гэрээнд үйлчлэх боломжтой.
2	Хөлсөөр ажиллах гэрээ	359.1.Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ. 359.2.Энэ гэрээний зүйл нь бүх төрлийн ажил, үйлчилгээ байж болно. 360.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол <u>ажил гүйцэтгэсний хөлсийг ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэсний дараа төлнө.</u> 360.2.Шаардлагатай бол хөлсийг хэсэгчлэн, тодорхой хугацаанд төлөхөөр тохиролцож болно.	Иргэний хуулийн 360-р зүйлийн 360.1, 360.2-т хөлсийг хэзээ, хэрхэн төлөх талаар зохицуулжээ. Харин гэрээгээр хөлсний талаар тохироогүй бол хэрхэх талаар тодорхой зохицуулалт байхгүй ч дээр дурдсан Иргэний хуулийн 358-р зүйлийг 358.1-ийг баримтлан Иргэний хуулийн 344.2-г хэрэглэх боломжтой.

3	Аялал жуулчлалын гэрээ	370.1.Аялал жуулчлалын гэрээгээр аялал жуулчлал зохион байгуулагч нь жуулчинд хэлэлцэн тохиролцсон үйлчилгээ үзүүлэх, жуулчин нь ийнхүү үйлчилгээ үзүүлсний төлөө хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ. 371.3.Аялал жуулчлал зохион байгуулагч нь гуравдагч этгээдийг аялалд оролцуулахтай холбогдож гарсан <u>нэмэлт зардлаа нөхөн төлүүлэхээр жуулчнаас шаардах эрхтэй.</u> 373.2.Энэ хуулийн 373.1-д заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгосон бол аялал жуулчлал зохион байгуулагч нь хэлэлцэн тохиролцсон хөлс авах эрхээ алдана. <u>Нэгэнт үзүүлсэн доголдолгүй үйлчилгээнийхээ хөлсийг шаардах эрхтэй.</u>	Аялал жуулчлалын гэрээ нь ажил гүйцэтгэх гэрээний тусгай төрөл тул Иргэний хуулийн 344.2-г хэрэглэх боломжтой.
4	Тээвэрлэлтийн гэрээ	380.1.Тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь зорчигч буюу ачаа, тээшийг тогтоосон газар хүргэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.	Тээвэрлэлтийн гэрээ нь ажил гүйцэтгэх гэрээний тусгай төрөл тул Иргэний хуулийн 344.2-г хэрэглэх боломжтой.
5	Даалгаврын гэрээ	399.1.Даалгаврын гэрээгээр даалгавар гүйцэтгэгч нь даалгавар өгөгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар тодорхой үйлдэл хийх, хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол даалгавар өгөгч нь хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ. 399.2.<u>Даалгавар гүйцэтгэгчийн хийж байгаа тухайн үйлдэл зайлшгүй хариу төлбөрийн шинжтэй бол</u> талууд хөлсийг харилцан тохиролцсон гэж үзнэ.	Даалгаврын гэрээний хувьд хийж байгаа тухайн үйлдэл зайлшгүй хариу төлбөрийн шинжтэй бол гэрээгээр хөлс талаар тохиролцоогүй орхигдуулсан ч даалгавар гүйцэтгэгч нь хөлс шаардах эрхтэй байна.
6	Хөрөнгө итгэмжлэх гэрээ	406.1.Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр итгэмжлэгч нь хөдлөх эд хөрөнгө буюу эрхийг итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх, итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг хүлээн авч итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн, захиран зарцуулах үүрэг тус тус хүлээнэ. 406.5.Гэрээнд өөрөөр заагаагүй бол итгэмжлэгдсэн өмчлөгч итгэмжилсэн хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаа явуулсны төлөө <u>итгэмжлэгчээс хөлс авахгүй.</u>	Хөрөнгө итгэмжлэх гэрээний хувьд гэрээгээр хөлсний талаар тохиролцоогүй бол итгэмжлэгдсэн өмчлөгч нь хөлс шаардах эрхгүй байна.
7	Илгээмжийн гэрээ	407.1.Илгээмжийн гэрээгээр илгээгч өөрийн нэрийн өмнөөс захиалагчийн зардлаар	Илгээмжийн гэрээний хувьд

		ачаа, илгээмжийг тээвэрлэхтэй холбоотой үйлдэл хийж, захиалагч гэрээнд заасан хөлсийг төлөх үүргийг тус тус хүлээнэ. 407.2.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол илгээмжийн гэрээнд <u>даалгаврын гэрээний журам нэгэн адил үйлчилнэ.</u>	Иргэний хуулийн 407-р зүйлийн 407.2-т зааснаар даалгаврын гэрээний журам нэгэн адил үйлчлэх тул Иргэний хуулийн 399-р зүйлийн 399.2-т заасны дагуу хийж байгаа тухайн үйлдэл зайлшгүй хариу төлбөрийн шинжтэй бол гэрээгээр хөлс шаардах эрхтэй байна.
8	Зуучлалын гэрээ	410.1.Зуучлалын гэрээгээр зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, зуучлуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс, шагнал төлөх үүргийг тус тус хүлээнэ. 410.2.<u>Хөлс, шагналын хэмжээг харилцан тохиролцоогүй бол тогтсон нийтлэг жишиг хэмжээгээр тохиролцсон гэж үзнэ.</u>	Зуучлалын гэрээний хувьд гэрээгээр хөлс төлөх талаар тохироогүй бол тогтсон нийтлэг жишиг хэмжээгээр хөлсийг тохиролцсон гэж үзэн зуучлагч хөлсөө шаардах эрхтэй байна.
9	Худалдааны зуучлалын гэрээ	413.12.Худалдааны зуучлагчид олгох <u>зуучлалын хөлс, шагналыг хэн төлөх</u> талаар тохиролцоогүй бол гэрээний талууд тогтоосон хөлс, шагналыг тэнцүү хэмжээгээр төлөх үүрэгтэй.	Худалдааны зуучлалын гэрээ, худалдааны төлөөллийн гэрээ, худалдааны комиссын гэрээний зохицуулалт дунд хөлсний талаар гэрээгээр тохиролцоогүй бол хэрхэх талаар зохицуулалт байхгүй байна.
10	Худалдааны төлөөллийн гэрээ	415.3.Худалдааны төлөөлөгч буюу комисс нь үйлчлүүлэгчийн заавраар түүний эрх ашиг, ердийн шаардлагад нийцүүлэн үүргээ гүйцэтгэж, үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангана. Гэрээнд өөрөөр заагаагүй бол улирал бүрийн сүүлчийн арав хоногт өөрийн үйл ажиллагааны үр дүн, <u>үйлчилгээний хөлс, шагналын тооцоо, комиссийн төлбөрийн</u> дүн зэргийг агуулсан тайланг үйлчлүүлэгчид гаргаж өгнө.	Иргэний хуулийн 344.2-г хэрэглэх боломжтой.
11	Худалдааны комиссын гэрээ	416.1.Хөлс, шагнал, шимтгэлийн хэмжээг харилцан тохиролцоогүй бол тогтсон нийтлэг жишиг, хэмжээгээр тохиролцсон гэж үзнэ.	
12	Хадгалалтын гэрээ	422.1.Хадгалалтын гэрээгээр хадгалагч нь хадгалуулагчаас шилжүүлэн өгсөн хөдлөх эд хөрөнгийг хадгалах үүрэг хүлээнэ. 422.2.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгалалт төлбөргүй байх бөгөөд хэрэв	Хадгалагч хадгалалтыг аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд явуулж

		хадгалагч хадгалалтыг <u>аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд явуулж байгаа бол урьдчилан тохиролцоогүй ч хадгалалтын хөлсийг харилцан тохиролцсон гэж үзнэ.</u>	байгаа бол урьдчилан тохиролцоогүй ч хадгалалтын хөлсийг харилцан тохиролцсон гэж үзэн шаардах эрхтэй байна.
--	--	---	--

Дээрхээс авч үзвэл хөрөнгө итгэмжлэх гэрээнээс бусад тохиолдолд гэрээгээр хөлсний талаар тохиролцоогүй ч бусдад ажил үйлчилгээ үзүүлсэн, бусдын өмнөөс хэлцэл хийсэн этгээд нь эрх бүхий байгууллагаас баталсан жишиг үнэлгээний жагсаалт байвал тухайн жагсаалтыг үндэслэн, тийм жагсаалт байхгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнэлгээгээр бодож хөлс шаардах эрхтэй байна. Гэхдээ “хөлсийг харилцан тохиролцсон гэж үзнэ” гэх тохиолдол нь бусдын өмнөөс үйл ажиллагаа явуулж, хэлцэл хийж буй этгээд нь хэн байна вэ гэхээсээ илүүтэй гүйцэтгэсэн ажлын шинж, ажил гүйцэтгэх болсон нөхцөл байдал, аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд явуулж байгаа эсэхээс хамаарч байна.

Энэ зохицуулалт нь аж ахуй эрхлэгчийн зарим үйл ажиллагаанд хөлсийг харилцан тохиролцсон гэж үзэж хөлсөө шаардах эрхтэй байх, зарим үйл ажиллагаанд хөлсийг харилцан тохиролцсон гэж үзэхгүй байх үр дагавартай юм. Гэтэл аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах үүднээс аж ахуй эрхлэгчийн гүйцэтгэсэн уг ажил нь түүний аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хамаардаг л бол хөлс шаардах эрхтэй байх нийтлэг зохицуулалт шаардлагатай байна.

Нөгөө талаас аж ахуйн үйл ажиллагааг Иргэний хуульд заасан цөөн тооны нэрлэгдсэн гэрээгээр хязгаарлаж болохгүй тул нэрлэгдээгүй гэрээ байгаа тохиолдолд одоогийн Иргэний хуулийн зохицуулалтын хүрээнд аж ахуй эрхлэгч нь бусдын өмнөөс хэлцэл хийсэн, үйл ажиллагаа явуулсан тохиолдолд гэрээгээр тусгайлан тохиролцоогүй бол гүйцэтгэсэн ажлынхаа хөлсийг шаардах эрхгүй байхаар байна.

7.5 ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЗАРДАЛ

Иргэний эрх зүй дэх гэрээтэй холбоотой зардлыг гэрээ байгуулах зардал болон үүрэг гүйцэтгэх зардал гэж 2 хувааж авч үздэг. Гэрээ байгуулах болон гэрээний үүргийн гүйцэтгэлд гарах зардлыг хэн хариуцах нь чухал ач холбогдолтой юм. Гэрээ байгуулах зардлын талаар Иргэний хуульд тодорхой зохицуулалт байхгүй байна. Ийнхүү хуулийн зохицуулалтгүй байдлын улмаас гэрээ байгуулах зардлыг хэрхэн хэн хариуцах асуудал шүүхийн практик маргаан дагуулсан асуудал юм. Энэ асуудал тодоор илэрсэн маргаан бол банкуудын зээл олгохдоо авч буй шимтгэл, хураамж гэх төлбөрийг давхардуулж авдаг, шимтгэлийг бодит зардалтай уялдуулаагүй буюу өндрөөр тооцдог гэсэн маргаан юм. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын зүгээс “...банкуудын зээл олгохдоо авч буй шимтгэл, хураамж гэх төлбөрийг **давхардуулж авдаг, шимтгэлийг бодит зардалтай уялдуулаагүй** буюу **өндрөөр тооцдог**, эдгээр шимтгэл, хураамжийн талаар **төөрөгдүүлсэн мэдээллийг** харилцагч нартаа өгдөг” гэх зөрчлийг тогтоон нэр бүхий 9 банкинд улсын байцаагчийн дүгнэлт, “...өөрийн банкны зээлийн үйлчилгээний шимтгэл, хураамжийн талаар мэдээллийг зээлдэгчдэд бүрэн, үнэн зөв өгч байх, зээлийн шимтгэл, хураамжийг давхардуулан авахгүй байх, зээл олгосны шимтгэлийг гарч буй зардалтай уялдуулан үндэслэлтэй тогтоох” албан шаардлага хүргүүлснийг илт хууль бусад

тооцуулах нэхэмжлэлийн шаардлагыг нэр бүхий 9 банк шүүхэд гаргаж, шүүх ШӨХТГ-ын улсын байцаагчийн “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагууд, “Хяналт шалгалтын тухай” дүгнэлтүүдийг хүчингүй болгосон байдаг. Энэ тохиолдолд шимтгэл авах нь зөв эсэх талаар бус, шимтгэлийг хэрхэн авах талаар маргаж буй нь энэ талын зохицуулалт тодорхой бус байгааг харуулдаг.

Үүнээс гадна тухайлбал дор дудсан маргаан зээлдэгч болон банкны хооронд гардаг. Маргааны гол агуулга нь зээлийн шимтгэл буюу гэрээ байгуулах зардлыг хэн хариуцах талаар болон зээлийн шимтгэлийн хэмжээ үндэслэлгүй байгаа талаар юм.

Нэхэмжлэгч М шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: Би 2015.01.22-ны өдөр “А” банкны салбараас 2 орон сууц барьцаалан 15/37 тоот зээлийн гэрээ болон 15/37 тоот зээлийн барьцааны гэрээ байгуулан 43 000 000 төгрөгний зээл авсан. Гэтэл “А” банк нь надаас зээлийн шимтгэл гэж 260 000 төгрөгийг суутган авсан би уг зээлийн гэрээний шимтгэлийг ямарч үндэслэлгүй гэж үзэж байна. Гэрээг нотариатаар батлуулах төлбөр, гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх төлбөрийг би гаргасан, эдийн засагчийг зурганд явах үед нь би өөрийн машинаараа явж өгсөн, Банкны зүгээс ямар нэгэн зардал гараагүй. Иймд “Ариг банк”-ны зээлийн гэрээний шимтгэл хэмээн 43 000 000 төгрөгнөөс суутгасан 260 000 төгрөгийг нэхэмжилж байна.

Хариуцагч “А банк” ХХК шүүхэд гаргасан хариу тайлбартаа: Нэхэмжлэгч иргэн М-н “Зээлийн шимтгэлд суутгасан 260 000 төгрөгийг гаргуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй байна. **“Зээлийн шимтгэл” гэдэг нь банкны зээл олгох үйл ажиллагаатай холбогдуулан гарсан тодорхой хэмжээний зардал** буюу төлбөр юм. Тухайлбал, зээлийн түүхийн судалгаа, зээл хүсэгчийн үйл ажиллагаатай танилцаж үнэлэлт дүгнэлт өгөх, барьцаа хөрөнгийн үнэлгээ тайланг судлах, түүнийг бүртгүүлэх, тухайн зээл хүсэгчийн үйл ажиллагаатай танилцах зэрэг үйл ажиллагаа явуулахад гардаг тодорхой зардал юм. Энэ үйл ажиллагаатай холбогдуулан гарсан зардлыг нөхөх зорилгоор зээлдэгчээс төлбөр авдаг байх бөгөөд үүнийг зээлийн гэрээ болон Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журмын дагуу явуулдаг. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 10 дугаар сарын 17-ний өдрийн 446 дугаар тушаалаар батлагдсан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1-д “ипотекийн зээлийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс дараах зардал /үүнд зээл үүсэх харилцаа, зээлийн өргөдөл, баримт бичгийн судалгаа хийж шийдвэр гаргах, барьцаа хөрөнгийн үнэлгээ тайлан, зээлийн түүхийн судалгаа, шуудан холбоо, нэмэлт судалгаа ба хяналт шалгалт, хугацаа сунгасны шимтгэл хамаарна/-ыг шингээсэн шимтгэлийг зээлдүүлэгч зээлдэгчээр төлүүлэх бөгөөд энэ нь нийт зээлийн дүнгийн 1 хувиас хэтрэхгүй байна” гэж заасан. Энэ салбарын харилцааны үндсийг хуулиар “хориглоогүй бүхнийг зөвшөөрнө” гэсэн чөлөөт зах зээлийн нийтлэг зарчим илэрхийлдэг бөгөөд холбогдох хууль болоод зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журамд **арилжааны банкнаас иргэн, хуулийн этгээдэд зээл олгохдоо ямар нэгэн хэлбэрээр шимтгэл авахыг хориглосон хэм хэмжээ байхгүй.** Иймд нэхэмжлэгчийн тус банкнаас зээл олгохдоо суутган авсан зээлийн шимтгэл нь үндэслэлгүй гэж үзэж байгаа нь ямарч хуулийн үндэслэлгүй байх тул нэхэмжлэгч иргэн М-н “Зээлийн шимтгэлд суутгасан 260 000 төгрөгийг гаргуулах тухай” нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Арилжааны хуулиар гэрээний зардлыг хэрхэн хувиарлах талаар зохицуулалт бий болгох нь маргаанаас урьдчилан сэргийлэх, мөн аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх үйл ажиллагааг дэмжих, эрх зүйн харилцааг илүү тодорхой болгоно. Иймд гэрээнд өөрөөр тохиролцоогүй бол талууд гэрээ байгуулах зардлыг тэнцүү хариуцах зохицуулалт бий болгох шаардлагатай юм.

8. ХЭЛЦЛИЙН БАТАЛГААТ БАЙДЛЫГ ХАНГАХ

Аль хэдийн олж авсан эрх, ашиг сонирхлоо бусдын үйлдлийн улмаас алдахгүй байх явдлыг хуулиар хамгаалахыг “хөдөлгөөнгүй баталгаат байдал” гэж нэрлэдэг. Нөгөө талаас шинээр эрх, ашиг сонирхол олж авах гэж буй тохиолдолд тухайн эрх, ашиг

сонирхол олж авч буй үйлдлийг хуулиар хамгаалахыг “хөдөлгөөнт баталгаат байдал” буюу “хэлцлийн баталгаат байдал” гэж хэлдэг. Тухайлбал А-гийн өмчлөлийн зүйлийг хадгалж буй Б нь тухайн эд хөрөнгийг өөрийн хөрөнгө гэж хэлэн В-д худалдсан тохиолдолд, тухайн худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр гэж үзэн В-г хамгаалах явдлыг хэлцлийн баталгаат байдлыг хангах, тухайн худалдах худалдан авах гэрээг хүчингүй гэж үзэн А-г хамгаалахыг хөдөлгөөнгүй баталгаат байдал гэж хэлдэг.

Өөрөөр хэлбэл өмнөх эрх бүхий этгээд болох А-г хамгаалах уу, эсвэл шинээр хэлцэлд оролцож байгаа гуравдагч этгээд болох В-г хамгаалах уу гэдэг асуудлыг шийдэх ёстой болдог. Арилжааны эрх зүйн харилцааны хувьд хэлцлийн баталгаат байдлыг хангах үүднээс худалдааны хэлцэлд оролцож буй нэг тал нөгөө талынхаа дотоод харилцааг судлалгүйгээр гадаад илрэлд нь итгэн хэлцэл хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх, бодит байдалтай нийцэхгүй гадаад илрэлийг бий болгосон талд хариуцлагыг оногдуулах агуулга бүхий зохицуулалтыг өөртөө агуулдаг. Нөгөө талаас хувийн эрх зүйн хөгжлийн явцыг авч үзвэл эхэн үедээ эрх бүхий этгээдийг хамгаалахыг илүү чухалчилж байсан боловч капиталист нийгмийн хөгжлийг дагаад гэрээний эрх зүйн харилцаанд хэлцлийн баталгаат байдлыг хангах буюу гуравдагч этгээдийг хамгаалах явдлыг чухалчлах болж ирсэн байдаг.

ХБНГУ-ын Иргэний хуульд эсрэг тал нь өмчлөх эрхтэй гэсэн итгэл үнэмшлийг хамгаалдаг бол Худалдааны хуулиар барьцаалах, захиран зарцуулах эрхтэй гэсэн гуравдагч этгээдийн итгэл үнэмшлийг хамгаалдаг байна.

Манай улсын хувьд Иргэний хуулиар эсрэг тал нь өмчлөх эрхтэй гэсэн итгэл үнэмшлийг л хамгаалах бөгөөд ХБНГУ-ын Худалдааны хууль шиг өмчлөх эрхээр хязгаарлагдахгүй барьцаалах, захиран зарцуулах эрхтэй гэсэн итгэл үнэмшлийг хамгаалдаггүй.

ХБНГУ-ын Худалдааны хууль

§ 366 [Хөдлөх эд хөрөнгийг шударгаар олж авах]

(1) Арилжаа эрхлэгч нь үйл ажиллагаа эрхлэх явцдаа бусдын өмчлөлд буй зүйлсийг **барьцаалсан** эсвэл **захиран зарцуулсан** бол Германы Иргэний Хуулийн холбогдох зүйл заалтыг **бүрэн эрхгүй этгээдийн шилжүүлгээс эрх олж авах гэж буй этгээдийн тусын тулд хэрэглэх** ба эдгээр нь **эд зүйлийг захиран зарцуулах эрх бий гэж итгэж үнэмшсэн нөхцөлд ч** гэсэн хамгаалалт олгоно.

9. ХЭЛЦЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

Аж ахуйн харилцаанд үүргийн гүйцэтгэл хангах аргыг хэрэглэх нь үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэхгүй байх эрсдэлээс зайлсхийх бизнес эрхлэгчийн гол механизм болдог. Бизнесийн харилцаанд талуудын хооронд хэлцэл байнга давтагдан хийгдэх нь нийтлэг тул ердийн тохиолдолтой харьцуулахад үүргийн гүйцэтгэл хангах аргыг нэг удаагийн хэлцлийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор бус талуудын хоорондын бизнесийн харилцаанд байнга дахин давтан үүсэж байдаг бүхий л үүргийг баталгаажуулах үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг бий болгох шаардлагатай болдог.

9.1 СААТУУЛАН БАРИХ ЭРХ

Иргэний хуулийн 215-р зүйлийн 215.1 дэх хэсэгт “Үүрэг гүйцэтгүүлэгч хүлээсэн үүргээ биелүүлж үүрэг гүйцэтгэх боломж бүрдүүлэх хүртэл үүрэг гүйцэтгэгч нь мөнгөн төлбөрийнхөөс бусад үүргийн гүйцэтгэлийг саатуулж болно” гэж заасан. Энэхүү зохицуулалтаар үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардах эрхийн эсрэг үүрэг гүйцэтгэгч мөн шаардах эрх хэрэгжүүлэх боломжтой бол энэ үүргийг биелүүлэх хүртэл хариу үүргээс татгалзах эрхтэй байх ба үүрэг гүйцэтгэгчийн саатуулан барих эрхийг зохицуулдаг. Энэ саатуулах эрхийн хувьд харилцан шаардах эрхүүд холбоотой байх буюу нэг ижил эрх зүйн харилцаанаас үүдэлтэй байх урьдчилсан нөхцөл тавигддаг.

Түүнчлэн Иргэний хуулийн гэрээний тусгай төрлийн зохицуулалтанд саатуулан барих эрхийг хуульчилж өгсөн байна.

№	Гэрээ	Иргэний хуулийн заалт	Тайлбар
1	Худалдах худалдан авах эрх	258.2.Худалдан авагч эд хөрөнгийн үнийг төлөх, зохих зардлыг нөхөн төлөх хүртэл худалдагч <u>эд хөрөнгийг өөртөө үлдээж саатуулах эрхтэй.</u> 258.3.Худалдан авагч эд хөрөнгийг хүлээн авсан боловч эрхийнхээ дагуу буцааж өгөх хүсэлтэй бол түүнийг хадгалж, бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд худалдагч зохих зардлыг төлөх хүртэл худалдан авагч <u>үг эд хөрөнгийг өөртөө үлдээх эрхтэй.</u>	
2	Эд хөрөнгө хөлслөх гэрээ	301 дүгээр зүйл. Хөлслүүлэгчийн саатуулан барих эрх 301.1.Газар, байшин болон орон сууц хөлслүүлэгч нь <u>эд хөрөнгө хөлслөх гэрээг биелүүлэхтэй холбоотой шаардлагаа хангуулах зорилгоор</u> тухайн газар, байшин орон сууцанд байгаа хөлслөгчийн эд хөрөнгийг саатуулан барих эрхтэй. 301.2.Хөлслүүлэгчийн барьцаалсан эд хөрөнгийг хөлслөгч нь аж ахуйн хэвийн үйл ажиллагаагаа хангахад ашиглах зориулалтаар, эсхүл амьдралын ердийн нөхцөлд тохирсон харилцааны улмаас буцаан авсан бол тухайн эд хөрөнгийн хувьд саатуулан барих эрх дуусгавар болно. 295.2.Газар хөлслөгч нь өөрийн ямар нэг шаардлагыг хангуулах зорилгоор гэрээ дуусгавар болсны дараа газрыг саатуулан барьж болохгүй.	Нэг ижил эрх зүйн харилцаанаас үүдэлтэй байх урьдчилсан нөхцөл тавигдаж байна.
3	Түрээсийн гэрээ	329 дүгээр зүйл. Түрээслүүлэгчийн барьцааны эрх 329.1.Түрээслүүлэгч нь <u>түрээсийн гэрээгээр түрээслэгчид гаргах шаардлагаа хангуулахын тулд</u> түрээслэгчийн түрээсэлж авсан эд хөрөнгийг ашигласны үр дүнд олж авсан эд юмс, үр шимийг барьцаалах эрхтэй.	Нэг ижил эрх зүйн харилцаанаас үүдэлтэй байх урьдчилсан нөхцөл тавигдаж байна.
4	Ажил гүйцэтгэх	354 дүгээр зүйл. Ажил гүйцэтгэгчийн барьцааны эрх	Нэг ижил эрх зүйн харилцаанаас

	гэрээ	354.1.Ажил гүйцэтгэгч <u>өөрийн шаардлагыг хангах зорилгоор эзэмшилдээ байгаа, захиалагчийн захиалсан ажлын үр дүн болох</u> хөдлөх эд хөрөнгийг барьцаалах эрхтэй. 354.2.Хэрэв гэрээний зүйл нь барилга байгууламж буюу түүний тодорхой хэсэг байвал ажил гүйцэтгэгч өөрийн шаардлагыг хангуулахаар барилга байгууламж барих газрын хувьд баталгаат ипотекийн эрхтэй.	үүдэлтэй байх урьдчилсан нөхцөл тавигдаж байна.
5	Ачаа тээвэрлэлтийн гэрээ	392 дугаар зүйл. Ачаа барьцаалах тээвэрлэгчийн эрх 392.1. <u>Тээвэрлэлтийн зардлыг төлүүлэхийн тулд</u> тээвэрлэгч нь ачааг захиран зарцуулах эрх үүсэх хүртэл ачааг барьцаалах эрхтэй.	Нэг ижил эрх зүйн харилцаанаас үүдэлтэй байх урьдчилсан нөхцөл тавигдаж байна.
6	Хадгалалтын гэрээ	429.17. <u>Эд хөрөнгийн хадгалалттай холбогдон үүссэн зардлыг төлүүлэхээр</u> хадгалагч тухайн эд хөрөнгийг барьцаалах эрхтэй. 429.18.Агуулахын баримтыг бичилт хийн шилжүүлсэн бол шинэ эзэмшигчид барьцаалах эрх үүснэ.	Нэг ижил эрх зүйн харилцаанаас үүдэлтэй байх урьдчилсан нөхцөл тавигдаж байна.

Иргэний хуулийн дагуу саатуулан барих эрх үүсэхийн тулд барьцаагаар хангагдах шаардах эрх болон барьцааны зүйл нь хооронд холбоотой байх шаардлагатай буюу барьцааны зүйлтэй холбогдож үүссэн шаардах эрх байх хэрэгтэй. Энэ нь бизнесийн харилцаанд зохистой биш юм.

Харин бизнес эрхлэгчдийн хооронд тогтмол хийгдэж буй арилжаанаас үүссэн шаардах эрхийг хангуулахын тулд тухайн арилжаатай холбоогүй тусдаа хэлцлийн дагуу эсрэг талын өмчлөлийн зүйл нь шаардах эрх бүхий бизнес эрхлэгчийн эзэмшилд байгаа бол үүнийг саатуулан барих байдлаар тухайн шаардах эрхээ хангуулж болохоор хуульчлах шаардлагатай. Өөрөөр хэлбэл шаардах эрх болон саатуулан барьж буй зүйл нь тодорхой хэлцлээр холбогдсон байхыг иргэний хууль шиг шаардах албагүй.

9.2 БАТЛАН ДААЛТЫН ГЭРЭЭ

Иргэний хуулийн 458-р зүйлийн 458.3 дахь хэсэгт “Батлан даалтын гэрээгээр батлан даагчийн хүлээсэн үүрэг нь үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэгт хамаарна” гэж заасан бөгөөд батлан даагч бусдын үүргийг үндсэн үүрэг гүйцэтгэгчийн хажуугаарр зэрэгцэн гүйцэтгэхээр амлах тул юуны өмнө батлан даах үүрэг үүссэн ёстой гэж үздэг. Иймээс бизнес эрхлэгчдийн хооронд тогтмол хийгдэж буй арилжаанаас үүссэн үүргийн гүйцэтгэлийг нийтэд нь хангах арга болж чадах эсэх эргэлзээтэй байна.

9.3 ХАМТРАН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ

Иргэний хуулийн 242-р зүйлийн 242.2 дахь хэсэгт “Хамтран хүлээх үүрэг нь хууль буюу гэрээнд зааснаар, эсхүл үүргийн зүйлийн үл хуваагдах шинж чанартай холбоотой үүснэ” гэж заасан тул гэрээгээр хамтран үүрэг гүйцэтгэхээр тохироогүй тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэх харилцаа үүсэхгүй гэж үзэхээр байна. Иймээс үүрийн харилцаанд олон этгээд оролцох тохиолдолд иргэний хуулийн дагуу үүрэг гүйцэтгэгчид үүргээ гүйцэтгэхдээ бие биеэсээ хамааралгүйгээр өөрт ногдох хэсгээ хариуцах бөгөөд

үүрэг үл хуваагдах шинжтэй эсхүл гэрээ болон хуульд өөрөөр заагаагүй л бол хэсгээр үүрэг гүйцэтгэх нь үндсэн зарчим гэж хэлж болно.

Харин бизнесийн харилцаанд үүргийг бүхэлд нь гүйцэтгэх хүртэл үүрэг гүйцэтгэгчдийн хэн нь ч үүргээс чөлөөлөгдөхгүй буюу хамтран үүрэг гүйцэтгэхээр зохицуулах зөв юм. Хамтран үүрэг гүйцэтгэх зарчмыг бизнесийн харилцаанд үндсэн зарчим болгож хэрэглэх шалтгаан нь худалдааны хэлцлээс үүсэх үүргийг илүү баталгаажуулах бөгөөд хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэн нэг нь үүрэг гүйцэтгэх чадамжгүй боллоо гэхэд бусад үүрэг гүйцэтгэгчид үүргийг бүхэлд нь гүйцэтгэх үүрэг хүлээдэгт байдаг. Ингэснээр хэсгээр үүрэг гүйцэтгэхтэй харьцуулахад хамтран үүрэг гүйцэтгэх тогтолцоо нь үүргийн гүйцэтгэлийг илүү баталгаажуулдаг тул арилжааны хэлцэлд хамтран үүрэг гүйцэтгэх зарчмыг үндсэн зарчимын хүрээнд авч ашиглах зохицуулалт бий болгох хэрэгцээ шаардлага байна.

9.4 БАРЬЦАА

Иргэний хуулийн 167-р зүйлийн 167.1 дах хэсэгт “Үүрэг гүйцэтгүүлэгч ипотекийн эрхийн бүртгэлийг нотолгоо болгохгүйгээр зөвхөн өөрийн шаардлагыг нотлох замаар ипотекийн эрхээ хангуулахаар хэлэлцэн тохиролцож болох бөгөөд уг ипотекийг улсын бүртгэлд баталгаат ипотек гэж бүртгэнэ” гэж зааснаар байнгын арилжааны харилцаатай байдаг этгээдтэй үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байгуулан ирээдүйд арилжааны харилцаанаас үүсэх үүргийн гүйцэтгэлийг тодорхой үнийн дүнгээр хангуулах тохиролцоог хийх боломжийг баталгаат ипотек олгодог.

Үл хөдлөх хөрөнгөнөөс бусад хөрөнгөд баталгаат ипотекийн адил хууль зүйн үр дагавар бий болгох шаардлагатай байна.

9.5 ҮЛ МАРГАХ ЖУРАМ

Иргэний хуулийн 234-р зүйлийн 234.4 дэх хэсэгт “Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаардана”, Иргэний хуулийн 453-р зүйлийн 453.2 дахь хэсэгт “Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол тухайн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлдүүлэгч захиран зарцуулах эрхтэй. Энэ заалт зөвхөн хөдлөх эд хөрөнгөнд хамаарна” гэж тус тус үл маргаж журмын талаар зохицуулсан байдаг боловч гэрээгээр тохиролцсон үл маргах журмыг албадан биелүүлэх тогтолцоо манай улсад байдаггүй тул эдгээр бодитоор хэрэгжихэд саад байна.

Үл маргаж журам нь шүүхийн шатыг алгасах, үүргийн гүйцэтгэлээ хурдан шуурхай хугацаанд олж авах боломжийг олгодог тул хэлцлийн нийтлэг зохицуулалт байдлаар талууд тохиролцвол гэрээндээ хэрэглэдэг байх зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

10. ХЭЛЦЛИЙН ХУРДАН ШУУРХАЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДАЛ

Хэлцлийн хурдан шуурхай байдлыг хангах гэдэг нь хэлцэл богино хугацаанд байгуулагдах, өөрчлөгдөх, дуусгавар болсон эсэх нь тодорхой болж байх ёстойг хэлдэг.

10.1 ГОМДЛЫН ШААРДЛАГА ГАРГАХ ХУГАЦАА

Хөөн хэлэлцэх хугацаа болон гомдлын шаардлага гаргах хугацааны хоорондын харилцааны талаар авч үзэх шаардлагатай байна. Учир нь Иргэний хуулийн 76-р зүйлийн 76.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан, түүнчлэн гомдлын шаардлага гаргах буюу баталгаат хугацаа тогтоосон бол гомдлын шаардлагын хариуг авсан буюу эдгээр хугацаа дууссан үеэс үүснэ” гэж заажээ. Иргэний хуульд дараах байдлаар гомдлын шаардлага гаргах хугацааг зохицуулдаг.

№	Гэрээ	Иргэний хуулийн зохицуулалт
1	Хууран мэхэлж хийсэн хэлцэл	59.4.Сонирхогч этгээд энэ зүйлд заасан хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах үндэслэл байгааг мэдсэнээс <u>хойш нэг жилийн дотор нөгөө талдаа гомдлын шаардлага гаргах эрхтэй.</u>
2	Хүч хэрэглэж хийсэн хэлцэл	60.3.Хүч хэрэглэн хэлцэл хийлгэсэн бол хэлцэл хийгч этгээд нь уг хэлцэл хийснээс <u>хойш нэг жилийн дотор нөгөө талдаа гомдлын шаардлага гаргах эрхтэй.</u>
3	Худалдах худалдан авах гэрээ	254.6.Худалдагч эд хөрөнгийн баталгаат хугацаа тогтоосон бол энэ хугацааны дотор, баталгаат хугацаа тогтоогоогүй бол тухайн эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэн <u>авснаас хойш зургаан сарын дотор</u> доголдлыг илрүүлсэн худалдан авагч энэ хуулийн 254.1-д заасан шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй.
2	Ажил гүйцэтгэх гэрээ	349.1.Ажил гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол <u>ажил хүлээн авснаас хойш зургаан сарын дотор, хэвийн байдлаар хүлээн авах үед илрүүлэх боломжгүй дутагдлын тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш нэг жилийн дотор гаргана.</u> Барилга, байшингийн ийм дутагдлын талаар ажил хүлээн авснаас <u>хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргаж болно.</u> 349.2.Хууль буюу гэрээнд баталгаат хугацаа заасан бөгөөд уг хугацааны дотор ажлын дутагдлыг илрүүлсэн бол гомдлын шаардлага гаргах хугацааг дутагдал илрүүлсэн өдрөөс эхлэн тоолно. 349.3.Энэ зүйлд заасан гомдлын шаардлага гаргах хугацаа <u>дууссан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно.</u>
3	Аялал жуулчлалын гэрээ	375.1.Жуулчин энэ хуулийн 372.3, 374 дүгээр зүйлд заасан шаардлагыг гэрээнд заасан <u>аяллын хугацаа дууссанаас хойш нэг сарын дотор аялал жуулчлал зохион байгуулагчид гаргаж болно.</u> 376.2.Хөөн хэлэлцэх хугацааг аялал жуулчлал зохион байгуулагч гомдлын шаардлагаас татгалзсан буюу гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн тоолно.
4	Тээвэрлэлтийн гэрээ	394.2.Ачаа хүлээн авагч ачааны илэрхий гэмтэл, дутагдлын талаархи шаардлагыг <u>ачаа хүлээн авсан өдөр,</u> харин далд дутагдалтай холбоотой шаардлагыг ачааг <u>хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор</u> бичгээр тээвэрлэгчид гаргана. 394.4.Ачаа хүлээн авагч хугацаа хэтэрсэнтэй холбоотой шаардлагаа ачаа хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор тээвэрлэгчид бичгээр гаргасан тохиолдолд хугацаа хэтэрснээс үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй. 395.2.3.бусад тохиолдолд гомдлын шаардлагын хариуг авсан буюу <u>гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан</u>

		<u>өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тоолно.</u>
--	--	--

Энд Иргэний хуулийн “гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно” гэсэн шийдэл нь ялангуяа аж ахуйн хэлцэлд тохиромжгүй юм. Өөрөөр хэлбэл ердийн тохиолдолд шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа тоологдож байгаа бол худалдах худалдан авах, ажил гүйцэтгэх гэх мэт гэрээнүүдийн хувьд тухайлбал доголдлын хувьд доголдолтой байсныг мэдсэн бол гомдлын шаардлага гаргах хугацаа тоологдон түүний дараагаар хөөн хэлэлцэх хугацаа тоологдож байна.

Аж ахуйн хэлцлийн хувьд хэлцэл хурдан шуурхай хугацаанд тодорхой болж байх ёстой тул гомдлын шаардлага гаргах хугацаа нь хөөн хэлэлцэх хугацаа дотроо орж тоологддог байх ёстой. Иймд гомдлын шаардлага гаргасан үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь зөв юм.

Нөгөө талаас “гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно” гэсэн шийдлийн ач холбогдол төдийлөн тодорхойгүй байна.

10.2 АЖ АХУЙ ЭРХЛЭГЧИД БАЙХ АНХААРАЛ БОЛГООМЖТОЙ БАЙХ ҮҮРЭГ

Аж ахуй эрхлэгчид байх анхаарал болгоомжтой байх үүрэг болон аж ахуй эрхлэгч бус этгээдийн анхаарал болгоомжтой байх үүрэг хоорондоо ялгаатай болохыг Монгол Улсын Иргэний хуулиар хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэвч шүүхийн практикт эдгээрийг ялгаж хэрэглэхгүй байгаа байдал ажиглагдаж байна.

1. Хэргийн товч агуулга:

Д нь 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдөр орон сууц захиалах гэрээ байгуулан “Ю” ХХК-ийн 16 давхар орон сууцанд 1 м.кв талбайн үнийг 1.880.000 төгрөгөөр бодож, Улаанбаатар хотын банкнаас зээл авч, төлбөрийг шилжүүлж, урьдчилгаа 30 хувийг төлсөн. Уг байр нь нийт 56.64 м.кв талбайтай гэж тооцон 2015 оны 02 сарын 08-ны өдөр өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ гарч, орон сууцандаа орсон. 2016 оны 12 сарын 06-ны өдөр “Инженер геодези” ХХК-иар хэмжилт хийлгэж үзэхэд нийт талбай 53.27 мкв гэж гарсан бөгөөд “Ю” ХХК нь орон сууцны талбайгаас 3.37 мкв талбайг дутуу хүлээлгэж өгсөн тул 6.335.600 төгрөгийг гаргуулахаар шаарджээ. Хариуцагч “Ю” ХХК шүүхэд гаргасан тайлбартаа 2013 оны 04 сарын 12-ны өдрийн “Үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах гэрээ”-ний дагуу Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, 15 дугаар хороололд байрлах 71, 72, 73 тоот, барилгыг “Өндөрбуянт холдинг” ХХК-иас шилжүүлэн авсан бөгөөд уг барилгыг худалдан авахдаа барилгын батлагдсан зураг, бүх төрлийн ажлын акт, холбогдох зөвшөөрлийг үндэслэн хүлээн авсан. Бид борлуулалтын талбайн хэмжээ, үнийг худалдан авагчдад урьдчилсан байдлаар танилцуулдаг. Манай компани барилгын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй компаниудаар зураг төслийг хийж гүйцэтгүүлсэн бөгөөд уг зураг төслийн дагуу баригдсан болохыг улсын комисс тогтоосон байгаа тул бид хөндлөнгийн компаний талбайн хэмжээг тооцож гаргасныг хүлээн зөвшөөрөхгүй учир нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

2. Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

Иргэний хуулийн 248 дугаар зүйлийн 248.2.-т зааснаар худалдан авагч эд хөрөнгийг хүлээн авсныг гэрчлэх тодорхой үйлдэл хийсэн бол түүнийг эд хөрөнгө хүлээн авсанд тооцох ба эд хөрөнгө хүлээж авах үедээ уг эд хөрөнгийн доголдлын талаар мэдсэн буюу мэдэх боломжтой байхад түүнийг хүлээн авсан худалдан авагч эд хөрөнгийн

доголдлын талаар шаардлага гаргах эрхээ алдахаар Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн 255.1.1-д заасан. Нэхэмжлэгч орон сууцыг 2015 оны 2 дугаар сарын 3-ны өдөр хүлээн авч, улмаар 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр улсын бүртгэлд өмчлөгчөөр бүртгүүлсэн байх тул тухайн үед орон сууцны талбайг хэмжүүлэх, эд хөрөнгийн доголдлыг мэдэх боломжтой байжээ.

Нөгөө талаар орон сууцны талбайн хэмжээний зөрүүтэй байдал нь барилгын ашиглалтын явцад мэдэгдэх далд доголдол биш бөгөөд нэхэмжлэгч худалдан авсан орон сууцны талбайн талаар шаардлага гаргах эрхээ алдсан байх тул илүү төлсөн төлбөрийг буцаан гаргуулах тухай нэхэмжлэгчийн шаардлагыг хангах хууль зүйн үндэслэлгүй.

Дээрх үндэслэлээр хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзэв.

2017 оны 09 сарын 29-ний өдрийн
001/ХТ2017/01058 дугаартай УДШ-ийн тогтоол

Энэ талаар мөн 2017 оны Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмжид “...орон сууцны талбайн хэмжээг мэргэжлийн эсвэл зохих байгууллагаар **хэмжүүлж, шалгаж**, эд хөрөнгөө хүлээн авах, энэ байдлаар эд хөрөнгөө аваагүй бол худалдан авагч Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн 255.1.1-т зааснаар шаардах эрхээ алдана.” гэж мөн дурдсан байдаг. Энэ тохиолдолд Улсын Дээд шүүх нь “мэдэх боломжтой” гэсэн урьдчилсан нөхцлийг хэрэглэхдээ “орон сууцны талбайн хэмжээг мэргэжлийн эсвэл зохих байгууллагаар хэмжүүлж, шалгаж, эд хөрөнгөө хүлээн авах” гэдэгтэй дүйцүүлж буйг харж болно.

Гэтэл Иргэний хуулийн 255-р зүйлийн 255.1.2-т “аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь уг үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийг шилжүүлэн авах үедээ нэн даруй **шалган авах үүргээ биелүүлээгүй**” гэж аж ахуй үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдээс эд хөрөнгө хүлээн авахдаа ердийн тохиолдолтой харьцуулахад илүү анхааралтай байхыг хуулиар шаарддаг тул энгийн иргэн заавал эд хөрөнгийг хүлээн авахдаа заавал шалгах үүрэг хүлээхгүй.

Эндээс дүгнэлт хийвэл хоёр аж ахуй эрхлэгчийн хоорондын худалдах, худалдан авах гэрээнд эрх зүйн харилцааг аль болох эрт үеэс тодорхой болгох зорилго бүхий худалдан авагч аж ахуй эрхлэгчид оногдуулсан шалгах үүрэг болон ердийн “мэдэх боломжтой” гэсэн урьдчилсан нөхцлийг хооронд нь ялгамжтай байдлаар авч үзээгүй байна. Энэ нь иргэний эрх зүй болон арилжааны эрх зүйн, ахуйн харилцаа болон аж ахуйн харилцааг хооронд нь тодорхой байдлаар ялгаж, системчлэж ирээгүйтэй холбоотой болов уу.

11. ГЭРЭЭ БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Иргэний хуульд гэрээ байгуулах талаар аж ахуй эрхлэгч болон ажил хэргийн хүрээнд тогтсон заншилтай холбоотой хэд хэдэн зохицуулатууд тусгагджээ. Үүнд Иргэний хуулийн §189.4, §42.3, §196.2, §196.1.7, §200.4, §202.2-г зохицуулалтууд дурдаж болно.

№	Ялгаатай тал	Иргэний эрх зүйн хэм хэмжээ	Худалдааны эрх зүйн хэм хэмжээ
1	Гэрээний чөлөөт байдлын зарчим	§189.1.Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.	§189.4 Тодорхой нэр төрлийн <u>бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, үйлчилгээ эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд</u> энэхүү үйл ажиллагааны хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй
2	Хэлбэрийн шаардлага	§42.2.Энгийн хэлбэртэй бичгийн хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.	§42.3. <u>Ажил хэргийн хүрээнд тогтсон заншлын</u> дагуу техникийн хэрэгслээр шууд хуулбарлан буулгасан гарын үсгийг түүний эхтэй адилтган үзэж болно.
3	Дуугүй хүлээн зөвшөөрөх	§42.9.Хууль буюу гэрээнд заасан тохиолдолд хэлцэл хийх тухай саналд хариу өгөхгүй байгааг хэлцэл хийхээр хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.	§196.2.Бусдад үйлчилгээ үзүүлэх <u>аж ахуй эрхлэгч нь ажил төрлийн байнгын холбоо</u> бүхий этгээдээс тухайн төрлийн үйл ажиллагаа гүйцэтгүүлэх тухай саналыг хүлээн авсан бол ердийн боломжит хугацааны дотор хариу явуулах үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй бол түүнийг гэрээ байгуулахаар дуугүй хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
4	Саналд дурдсанаас өөр нөхцөлөөр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн хариу	§195.6.Гэрээ байгуулах саналаас өөр нөхцөлөөр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн хариуг гэрээ байгуулах тухай шинэ санал гэж үзнэ.	§196.1.7. <u>Ажил хэргийн хүрээнд тогтсон заншил ёсоор</u> санал гаргагч талыг хүлээн зөвшөөрнө гэж үзээд санал хүлээн авагч тал нь саналд дурдсанаас өөр нөхцөлөөр гэрээ байгуулахаар хариу илгээсэн тохиолдолд санал гаргагч татгалзсан тухайгаа нэн даруй мэдэгдээгүй гэрээг байгуулсанд тооцно.
5	Стандарт нөхцөл ил тод байх	200.3.Дараахь нөхцөл бүрдсэн тохиолдолд стандарт нөхцөл нь талуудын хооронд байгуулсан гэрээний салшгүй хэсэг болно: 200.3.1.санал гаргагч тал нь гэрээ байгуулж байгаа газарт стандарт нөхцөлийг ил тод харагдахаар бичиж энэ нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй гэрээг байгуулахаар заасан бол; 200.3.2.нөгөө тал нь дээрх нөхцөлтэй танилцах боломжтой	§200.4.Санал хүлээн авагч тал нь <u>аж ахуй эрхлэгч</u> этгээд бөгөөд ажил хэргийн онцлогоос хамаарч стандарт нөхцөлийг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан бол стандарт нөхцөл нь гэрээний салшгүй хэсэг болно.

		байсан бөгөөд уг нөхцөлийг зөвшөөрсөн бол.	
6	Стандарт нөхцөлд тавигдах хязгаарлалт	Тус заалтын эсрэг тайлбарын дагуу аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэнд уг заалт хамаарахгүй.	§202.2. Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй иргэнтэй гэрээ байгуулахаар санал гаргаж байгаа тал нь дараахь нөхцөлүүдийг гэрээний стандарт нөхцөлд тусгасан бол тэдгээр нь хүчин төгөлдөр бус байна: *15 үндэслэлийг тоочиж заасан

Дээрх хүснэгт манай Иргэний хууль аж ахуй эрхэлдэг этгээд болон аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй этгээдийн хувьд гэрээ байгуулахтай холбоотой үйлчлэх эрх зүйн зохицуулалт ялгаатай байхаар зохицуулсан тодорхой харагддаг.

Иргэний хууль дахь гэрээ байгуулахтай холбоотой зохицуулалтууд аж ахуй эрхлэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцэж буй эсэхийг авч үзье.

11.1 ГЭРЭЭ БАЙГУУЛАГДАХ ТОХИРОЛЦООНЫ АГУУЛГА

Тодорхой эрх зүйн үр дагаварт чиглэсэн, гэрээ байгуулах санал ба хүлээн зөвшөөрөх саналаас бүрдсэн, дор хаяж хоёр талын хүсэл зоригийн илэрхийлэл тодорхой агуулгаар нэгдсэн байхыг гэрээ гэнэ гэж тодорхойлдог¹¹. Гэрээ байгуулах саналд агуулгын хувьд ямар шалгуур тавих талаар дараах зохицуулалтуудад тусгагдсан байдаг. Иргэний хуулийн 195-р зүйлийн 195.2 дахь хэсэгт “Гэрээ байгуулах саналд гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан байна”, 195.3 дахь хэсэгт “Хуульд заасан буюу гэрээнд зайлшгүй тусгавал зохих, түүнчлэн нэг талын хүссэний дагуу нөгөө тал нь зөвшөөрсөн нөхцөлийг гэрээний гол нөхцөл гэнэ” гэж тус тус заажээ.

Энд гэрээний гол нөхцөл гэж юу болох талаар тодруулах шаардлагатай болдог. Гэрээний санал наад заах нь хуульд заасан буюу гэрээнд зайлшгүй тусгавал зохих нөхцөл болох үндсэн үүргийн талаарх агуулгыг өөртөө агуулсан байж сая гэрээний санал болно. Талууд хүсвэл үндсэн үүргээс гадна бусад нөхцөлөөр тохиролцох нь нээлттэй. Гол асуудал нь гэрээний саналд дурдсан бүх нөхцөлийг хүлээн зөвшөөрөх хариу нь огт өөрчлөөгүй байх ёстой гэдэг ойлголт юм.

Гэтэл энд гэрээний саналд үндсэн үүргээс гадна бусад нөхцөлийн талаар тусгасан бөгөөд талууд гэрээний үндсэн үүргийн талаар тохиролцсон ч бусад нөхцөлийн талаар тохиролцоогүй бол гэрээ байгуулагдах эсэх, ялангуяа талууд төдийлөн ач холбогдол өгөөгүй нөхцөлөөр тохиролцоогүй гэх үндэслэлээр гэрээ байгуулагдаагүй гэх нь зохистой эсэх талаар авч үзэх шаардлагатай байна. Тухайлбал гэрээ байгуулагдах явцад зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөх гэх мэт гадаад хүчин зүйлийн улмаас гэрээ байгуулах нь ашиггүй болсон тал ач холбогдол багатай нөхцөл дээр тохиролцоогүй шалтгаанаар гэрээ байгуулагдаагүй гэх нь зохисгүй юм.

Энэ талаар зарим гадаад орны хууль тогтоомжийн жишээг авч үзье.

¹¹ Б.Буянхишиг “Үүргийн эрх зүй ерөнхий анги” Нэмж засварласан хоёр дахь хэвлэл, УБ хот, 2017 он, 46 дахь тал

Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн 19-р зүйлд дараах байдалаар зохицуулагдсан байна.

19 дүгээр зүйл

- (1) Гэрээ байгуулах саналын хариуд уг саналыг зөвшөөрнө гэсэн боловч түүнд нэмэлт, хязгаарлалт, бусад өөрчлөлт агуулсан бол энэ нь саналаас татгалзсан бөгөөд гэрээ байгуулах шинэ санал гаргасан гэж үзнэ.
- (2) Гэхдээ гэрээ байгуулах саналын хариуд зөвшөөрнө гэсэн боловч уг саналын нөхцөлийг үндсээр нь өөрчлөөгүй зөвхөн нэмэлт буюу өөр нөхцөл агуулсан бөгөөд хэрэв санал гаргагч хэт удахгүйгээр эдгээр өөрчлөлтөөс амаар татгалзаагүй буюу энэ тухай мэдээлэл илгээгээгүй бол дээрх хариуг зөвшөөрөл гэж үзнэ. Хэрэв санал гаргагч ийнхүү эсэргүүцээгүй бол уг саналын нөхцөлүүд нь зөвшөөрөлд дурдсан өөрчлөлттэйгээр гэрээний нөхцөл болно.
- (3) Барааны үнэ, төлбөр, чанар, тоо хэмжээ, нийлүүлэх газар, хугацаа, гэрээний нэг талаас нөгөө талын өмнө хүлээх хариуцлагын хэмжээ, маргаан шийдвэрлэх зэрэг зүйлтэй холбоотой нэмэлт буюу өөр нөхцөл нь гэрээ байгуулах саналын нөхцөлийг үндсээр нь өөрчлөхөд хүргэнэ гэж үзнэ.

Тус конвенцийн 19-р зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан зохицуулалт нь манай улсын Иргэний хуулийн 195-р зүйлийн 195.6 дахь хэсэгт заасан зохицуулалттай ижил буюу гэрээний саналаас өөр нөхцөлөөр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн хариуг гэрээний шинэ санал гэж үздэг. Харин анхаарал татаж буй зохицуулалт нь 19-р зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан зохицуулалт бөгөөд нэмэлт оруулсан, өөр нөхцөлөөр гэрээ байгуулахыг хүлээн зөвшөөрсөн хариу байх тохиолдолд шинэ санал гэж үзэлгүйгээр хүлээн зөвшөөрөх хариу гэж үздэг. Гэхдээ санал гаргагч тал хэт удахгүйгээр эдгээр өөрчлөлтөөс амаар татгалзаагүй буюу энэ тухай мэдээлэл илгээгээгүй байх гэдэг урьдчилсан нөхцөл тавигдаж байна.

Түүнчлэн АНУ-ын Худалдааны нэгдсэн загвар хууль(Uniform Commercial Code)-ийн §2-207-д саналыг хүлээн зөвшөөрсөн хариу дахь нэмэлт нөхцөлийг хэрхэн зохицуулсан талаар авч үзье.

§ 2-207(1) Тодорхой бөгөөд зохистой үед илэрхийлсэн хүлээн зөвшөөрсөн хариу, зохих хугацааны дотор хүлээн авсан гэрээ байгуулсан талаарх мэдэгдэл нь хэдийгээр гэрээний санал болон тохиролцсон агуулгад нэмэлт оруулсан эсвэл өөр агуулга(нэмэлт нөхцөл)-тай байсан ч түүнийг хүлээн зөвшөөрөх хариу гэж үзнэ. Харин гэрээний санал болон тохиролцсон агуулгад нэмэлт оруулсан эсвэл нэмсэн өөр агуулгын талаар санал хүлээн авагч талаас санал гаргагч тал санал нийлэх тохиолдолд гэрээ байгуулагдахаар нөхцөл тавьсанаа тодорхой илэрхийлсэн тохиолдолд энэ заалт үйлчлэхгүй.

§ 2-207(2) Нэмэлт нөхцөл нь тухайн гэрээнд нэмэлт оруулахаар гаргасан санал гэж тайлбарлагдана. Худалдаачин хооронд дор дурдсанаас бусад тохиолдолд гэрээний нэг хэсэг нь болно.

А.Гэрээний саналд зөвхөн гэрээний саналд заасан нөхцөлийг хүлээн зөвшөөрөхөөр тодорхой хязгаарласан бол,

Б.Нэмэлт нөхцөл нь гэрээний саналыг бодитоор/үндсээр нь/ өөрчлөөгүй бол,

В.Нэмэлт нөхцөлийн талаар татгалзах мэдэгдэл аль хэдийн гаргасан, эсвэл нэмэлт нөхцөлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш боломжит хугацааны дотор татгалзах тухай мэдэгдэл гаргасан

Эдгээр зохицуулалт нь англи-америкийн эрх зүйн тогтолцоотой орны эрх зүйн зарчим болох гэрээний байгуулахыг хүлээн зөвшөөрсөн хариу нь гэрээний санал яв цав тохирч байх ёстой гэсэн mirror image rule-г худалдааны бодит практикт нийцүүлэн өөрчилсөн байдаг.

АНУ-ын Худалдааны нэгдсэн загвар хуулийн §2-207(1)-т зааснаар гэрээ байгуулахыг хүлээн зөвшөөрсөн хариу нь гэрээний саналд шинэ нөхцөл нэмсэн, гэрээний саналтай өөр нөхцөлийг агуулсан байсан ч санал гаргагч нь саналдаа тусгайлан заагаагүй л бол хүлээн зөвшөөрөх хариу болох бөгөөд гэрээ байгуулагдана. Харин нэмэлт нөхцөл нь зарчмын хувьд гэрээнд нэмэлт оруулах шинэ санал болох бөгөөд эсрэг талын зөвшөөрөл шаардлагатай боловч худалдаачин хоорондын хэлцэл бол тусгай зохицуулалт үйлчилдэг. Өөрөөр хэлбэл нэмэлт нөхцөл нь худалдаачин хоорондын гэрээнд эсрэг талын зөвшөөрөл шаардлагагүй шууд гэрээний нэг хэсэг болдог (§2-207(2)).

Дээрх Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, АНУ-ын Худалдааны нэгдсэн загвар хуулийн дээрх зохицуулалттай төстэй зохицуулалтыг Арилжааны хуулиар бий болгох шаардлагатай байна.

12. АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ ТӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТААТАЙ БАЙДЛААР НАРИЙВЧЛАН ЗОХИЦУУЛАХ АСУУДАЛ

№	Асуудал	Мөн чанар, цар хүрээг тогтоох
1	Арилжааны гэрээний тусгай төрлийн зохицуулалтыг бизнест таатай байдлаар нарийвчлан зохицуулах асуудал	1. Худалдах худалдан авах-онцлог, Түрээс, Санхүүгийн түрээс, Франчайзинг, мерчендайз 2. Ажил гүйцэтгэх-онцлог, Даатгал, Аялал жуулчлал, Даалгавар-онцлог, Илгээмж 3. Худалдааны зуучлал, комисс 4. Тээвэрлэлт, Барааны агуулахад эд хөрөнгө хадгалалт 5. Зээл тооцооны үүрэг-онцлог, Батлан даалт-онцлог 6. Тооцоо нийлэх, Үнэт цаас 7. Хамтран ажиллах-онцлог

Худалдах, худалдан авах гэх мэт тусгай төрлийн гэрээний зарим зохицуулалт нь ахуйн шинжтэй гэрээний харилцаанд шударга, зохистой үр дүнг бий болгодог ч аж ахуйн шинжтэй үйл ажиллагаанд нийцэхгүй байгаа нь харагддаг. Тухайлбал худалдах худалдан авах гэрээний доголдлын талаарх зохицуулалтыг жишээ болгон авч үзье.

Иргэний хуулийн 254-р зүйлийн 254.1 дэх хэсэгт “Худалдан авагч нь эд хөрөнгийн доголдлыг арилгуулах буюу доголдолгүй тухайн төрлийн эд хөрөнгөөр солиулах, доголдлыг арилгахад гаргасан зардлаа төлүүлэх, эсхүл гэрээг цуцлах тухай шаардлага гаргах эрхтэй” гэж заасан. Энэ заалтын талаар худалдан авагч эдгээр шаардах эрхүүдээс алийг нь ч сонгон хэрэгжүүлэх эрхтэй юу, эсвэл тодорхой ээлж дараалалтайгаар гаргах ёстой юу гэсэн асуулт гарч ирдэг.

Энэ талаар Б.Буянхишиг “Иргэний хуулийн §254.1-ийн дагуу худалдан авагч нь ахин гүйцэтгэлийг өөрөөр хэлбэл доголдлыг арилгуулах, эд зүйлийг солиулах хоёрын аль нэгийг сонгож шаардах боломжтой. Энэ зүйлд тусгагдсан бусад эрхийг худалдан авагч онолын хувьд үүргээ зохих ёсоор гүйцэтгэх нэмэлт хугацаа олгосны эцэст хэрэгжүүлнэ”¹² гэсэн нь эдгээр шаардах эрхүүдийг ээлж дараалалтайгаар гаргах ёстой гэсэн санааг дэмжсэн байна

Шүүхийн практикт Иргэний хуулийн 254-р зүйлийн 254.1 дэх хэсэгт заасан шаардах эрхүүдээс худалдан авагч аль нэгийг нь сонгон нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрдөг.

2018 оны 12 сарын 20 Дугаар 3853 Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг:

Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсэгт заасан худалдах, худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг хүлээнэ. Энэхүү гэрээний худалдагчийн гол үүрэг нь биет байдлын болон эрхийн доголдолгүй эд хөрөнгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх юм.

Уг үүргээ худалдагч зохих ёсоор биелүүлээгүй бол худалдан авагч Иргэний хуулийн 254 дүгээр зүйлийн 254.1 дэх хэсэгт заасан шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй.

2018 оны 12 сарын 25-ны Дугаар 0041 Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг:

Иргэний хуулийн 254 дүгээр зүйлийн 254.6 дахь заалтад “Худалдагч эд хөрөнгийн баталгаат хугацаа тогтоосон бол энэ хугацааны дотор, баталгаат хугацаа тогтоогоогүй бол тухайн эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэн авснаас хойш зургаан сарын дотор доголдлыг илрүүлсэн худалдан авагч энэ хуулийн 254.1-д заасан шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй” гэж заасны дагуу бетон зуурмагийн доголдлыг арилгуулах буюу доголдолгүй тухайн төрлийн эд хөрөнгөөр солиулах, доголдлыг арилгахад гаргасан зардлаа төлүүлэх, эсхүл гэрээг цуцлах тухай шаардлагыг бетон зуурмагийг хүлээн авсан 2017 оны 9 сараас хойш 6 сарын дотор гаргаж байсан байдал хэргийн баримтаар тогтоогдоогүй болно

Эхлээд доголдлыг арилгуулах, эд зүйлийг солиулах шаардах эрхээ хэрэгжүүлэх ёстой дараа нь бусад эрхийг хугацаа тогтоон хэрэгжүүлнэ гэж хуульд тодорхой заагаагүй тул гэрээний зүйл доголдолтой тохиолдолд худалдан авагч нь доголдлыг арилгуулах, эд зүйлийг солиулах, доголдлыг арилгахад гаргасан зардлаа төлүүлэх, гэрээг цуцлах эрх гэсэн эрхүүдээс аль нэгийг сонгон хэрэгжүүлэх боломжтой гэж тайлбарлах нь одоо байгаа зохицуулалтын хүрээнд боломжит тайлбар юм.

Харин худалдан авагчид доголдолтой холбоотой шаардах эрхүүдийг өөрийн дураар сонгон хэрэглэх боломжийг олгодог уг зохицуулалт нь аж ахуйн үйл ажиллагаанд зохимжтой эсэх нь эргэлзээтэй байна.

Энэ тохиолдолд худалдагчийн хэлцэл байгуулагдсан гэдэгт итгэж буй ашиг сонирхол хөндөгдөхөөр байна. Өөрөөр хэлбэл аж ахуйн харилцаанд байх ёстой хэлцэл хурдан шуурхай байх зарчим зөрчигдөх юм. Нөгөө талаас зах зээлийн хүчин зүйлийн улмаас барааны үнэ буурсан бол худалдан авагч тухайн гэрээнээс татгалзаж, өөр хямд

¹² Б.Буянхишиг “Иргэний эрх зүйн тусгай анги III-I” Дөрөвдүгээр хэвлэл, УБ хот 2015 он 54 дэх тал

гэрээ байгуулах ашиг сонирхолтой болох боломжийг бүрдүүлж гэрээний харилцааг тогтворгүй болгож байна.

1.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Дээр дурдсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд голлон анхаарал татаж байна. Үүнд:

1. Хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэхгүй, санхүүгийн тайлан тооцоо хөтөлдөггүй нь арилжааны хэлцлийн найдвартай аюулгүй байдлыг хангаж чадахгүй байна,
2. Хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэхгүй, санхүүгийн тайлан тооцоо хөтөлдөггүй нь далд эдийн засгийг бий болгож байна,
3. Аж ахуй эрхлэгчийн зарим мэдээллийг ил тод болгосноор арилжааны хэлцлийн аюулгүй, түргэн шуурхай, найдвартай баталгаат байдлыг хангаж, хэлцлийн зардлыг бууруулах,
4. Аж ахуй эрхлэгчийн бүртгэл буруу бүртгэгдснээс үүсэх үр дагаврыг аж ахуй эрхлэгч өөрөө хүлээж, хэлцлийн нөгөө талын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй,
5. Аж ахуй эрхлэгчийн төлөөлөгчийг бүртгэснээр хэнтэй хэлцэл хийж байгаа, тухайн этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй этгээд мөн эсэхийг мэдэхгүйгээс төлөөлөн бүрэн эрхгүй этгээдийн хэлцэлд тооцогдож хэлцэл хүчингүй болсноор хэлцлийн нөгөө талыг хохироох нөхцөл үүсгэж байна.
6. Аж ахуй эрхлэгчийн арилжааны нэрийн зохицуулалт тодорхойгүйгээс нэрийг бусдад ашиглуулах, түрээслэх замаар ашиг олох боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.
7. Арилжааны нэрийг барааны тэмдэгт хамааруулан зохицуулаагүйгээс нэрийг давхардуулан олгох, бусдыг төөрөгдүүлэх байдлаар ашиглах боломжийг олгож байна.
8. Арилжаа эрхлэгч, иргэдийн гэрээнээс үүсэх маргааны хөөн хэлэлцэх хугацааг ижил зохицуулснаас арилжааны түргэн, шуурхай, баталгаат байдалд сөрөг нөлөө үзүүлнэ.
9. Хувиараа аж ахуй эрхлэгчдийн хувьд өөрийн аж ахуйн үйл ажиллагааны тодорхой хэсгийг эсхүл бүхэлд нь тодорхой этгээдэд бүрэн эрх олгох замаар хэрэгжүүлэх тохиолдолд тухайн төлөөлөх бүрэн эрхийг хэрхэн олгох талаар зохицуулах.
10. Хуульд хуулийн этгээдийн удирдах байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн талаар товч зохицуулсан боловч, ихэнх тохиолдолд хуулийн этгээдийг төлөөлөх бүрэн эрхийн талаар тухайн хуулийн этгээдийн дүрмээр зохицуулж байна. Энэ нь гуравдагч этгээдийг, хэлцлийн нөгөө тал болох аж ахуй эрхлэгчийн хувьд хэлцлийн нөгөө талын талаар мэдэх, урьдчилан таамаглах, өөрийн бизнесийн үйл ажиллагааг төлөвлөхөд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.
11. Хуулийн этгээдийн дүрэм, тухайн албан тушаалтантай байгуулсан гэрээнд төлөөлөх бүрэн эрхийн талаар тодорхой тусгагдаагүй тохиолдолд талуудын эрхийг зохистойгоор

харгалзан үзсэн шийдвэрийг шүүхийн зүгээс гаргахад ашиглагдах тодорхой шалгуурыг хуулийн зохицуулалтын дагуу бий болгох.

12. Аж ахуйн эрхлэгчийн талаарх тодорхой бүртгэлийн тогтолцоогоор дамжуулан төлөөлөх бүрэн эрхийн талаар илүү илэрхий, ил тод байдлыг бий болгох.

13. Аж ахуйн нэгжид ажиллаж байсан ажилтан, албан тушаалтан, эсхүл тодорхой эрхээ бусдад шилжүүлсэн аж ахуйн нэгжид адил төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхгүй байх буюу өрсөлдөхгүй байх үүргийг хуулийн дагуу хүлээлгэх.

14. Аж ахуй эрхлэгчийг тодорхойлсон зохицуулалт байхгүйн улмаас аж ахуйн үйл ажиллагаа болон ахуйн шинжтэй үйл ажиллагааг хооронд нь ялгах боломжгүйд хүрч байна.

15. Аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах талаарх зохицуулалт тодорхойгүй, ойлгомжгүй, дутуу байгаа улмаас бизнесийн үйл ажиллагаа хамгаалагдахгүй, одоо байгаа зохицуулалт хэрэгцээ шаардалгад нь нийцэхгүй байна.

16. Иргэний хуулийн зохицуулалт нь нэг удаагийн шинжтэй харилцааг зохицуулсан байх тул байнгын аж ахуйн харилцаатай байдаг этгээдүүдийн хоорондын харилцааг зохицуулахад хангалтгүй байгаа улмаас аж ахуйн хэлцлийн баталгаат, тогтвортой байдал алдагдаж байна.

17. Иргэний хуулийн зарим зохицуулалт аж ахуйн харилцаанд хэлцлийн хурдан шуурхай байдлыг хангах асуудлыг алдагдуулсан байна. Тухайлбал гомдлын шаардлага гаргах хугацааг дурдаж болно.

18. Иргэний хуулийн гэрээ байгуулахтай холбоотой зохицуулалт техникийн шинжтэй зохицуулалтыг хатуу байдлаар хуульчилсан бөгөөд практик дээр олон янз хэлбэрээр байгуулагдаж буй аж ахуйн хэлцлийг уян хатан байдлаар зохицуулахад саад үүсгэхээр байна.

19. Иргэний хуулийн тусгай ангийн зарим зохицуулалтыг аж ахуй эрхлэгчийн ашиг сонирхлыг хангах үүднээс бие даасан тусгай хуулиар дахин системчлэх шаардлагатай байна.

1.2 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох¹³:

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Хувиараа аж ахуй эрхлэгч	Хувиараа аж ахуй эрхлэгчийн хувьд өөрийн

¹³ Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Харин манай тохиолдол нь “аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй тул энэхүү судалгааны 1.2 дахь хэсгийн нэршлээс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй бүлгийг хассан болно.

		тодорхой аж ахуйн үйл ажиллагааны талаар шүүхийн болон шүүхийн бус аливаа үйлдэл хийх ерөнхийлсөн эрхийг олгох боломжийг хуулиар олгоогүй төдийгүй, энэ тохиолдолд бусад этгээдийн итгэж, үнэмшсэнийг хэрхэн дүгнэх талаар хуулиар зохицуулаагүй байгаа нь хувиараа аж ахуй эрхлэгчдийн эрх зөрчигдөхөд хүргэж байна. Түүнчлэн хувиараа аж ахуй эрхлэгчийг бүртгэх тогтолцоог бий болгох, тухайн аж ахуй эрхлэгчид арилжааны нэр ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах шаардлагатай учир тэдний эрх ашиг хөндөгдөнө. Аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах, хэлцлийн баталгаат байдлыг хангах зохицуулалтыг бий болгосноор аж ахуйн үйл ажиллагаа идэвхтэй явагдах болно. Нөгөө талаас хэлцэл хийхдээ аж ахуй эрхлэгч иргэнээс илүү анхаарал болгоомжтой байх хариуцлага бий болно.
2	Хуулийн этгээд	Хуулийн этгээдийн хувьд удирдах байгууллагаас бусад тодорхой албан тушаалтаны хувьд шүүхийн болон шүүхийн бус аливаа үйлдэл хийх ерөнхийлсөн эрх олгогдсон тохиолдолд тухайн бүрэн эрхийн хүрээг хэрхэн тайлбарлах, бусад этгээдийн итгэж, үнэмшсэнийг хэрхэн дүгнэх талаар хуулиар зохицуулаагүй байгаа нь хуулийн этгээдийн эрх зөрчигдөхөд хүргэж байна. Аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах, хэлцлийн баталгаат байдлыг хангах зохицуулалтыг бий болгосноор аж ахуйн үйл ажиллагаа идэвхтэй явагдах болно. Нөгөө талаас хэлцэл хийхдээ аж ахуй эрхлэгч ердийн хүнийхээс илүү хэмжээнд анхаарал болгоомжтой байх хариуцлага бий болно.
3	Хэрэглэгч	Хэрэглэгчийн хувьд тухайн аж ахуйн эрхлэгчийн талаар хангалттай мэдээлэл авахгүй байх эрсдэлтэй. Аж ахуй эрхлэгчийг тодорхой байдлаар тодорхойлж өгөөгүйгээс хуулийн хэм хэмжээг хэрэглэх хүрээг тодорхойлоход давхардал, хийдэл үүсэх магадлалтай байна. Аж ахуй эрхлэгчид хэрэглэх ёстой хэм хэмжээг хэрэглэгчид хэрэглэж, түүнд хүндрэл учруулах магадлалтай байна.
4	Төрийн байгууллага, төрийн бус байгууллага	Аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах тохиолдолд эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулж буй эсэх, эсхүл тухайн байгууллагын дотоод дүрмийн талаар бүрэн мэдээлэлгүйгээс болж эрх нь зөрчигдөх магадлалтай.

1.3 Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

А. Аж ахуй эрхлэгчийн бүртгэлийн тухайд

Манай орны хувьд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх нэгдсэн тогтолцоо байхгүй бөгөөд зөвхөн хуулийн этгээдийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн хэлбэрийг бүртгэснээр хязгаарлагдаж байна. Өөрөөр хэлбэл Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасан ашгийн төлөө хуулийн этгээд болох компани, нөхөрлөлийн хэлбэрээр бизнесийн буюу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэдэг байна. Тухайлбал Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо нь иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээс бүрдэнэ” гэж заасан.

Үүнээс үзэхэд Иргэний бүртгэл нь иргэний төрсөн, нас барсан, шилжсэн, үрчилсэн, гэрлэсэн зэрэг хувь иргэнд чиглэсэн бол хуулийн этгээдийн бүртгэл нь зөвхөн хуулийн этгээд хэлбэрээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой бүртгэл хийдэг. Харин эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл нь иргэн, хуулийн этгээд харгалзахгүйгээр хуулиар бүртгүүлэх шаардлага тавигдсан эд хөрөнгийг бүртгэж, өмчлөх эрхийг баталгаажуулдаг бүртгэл байна.

Манай орны хувьд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай анхны хууль 2003 онд батлагдсанаас хойш нийт 9 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, 2018 онд шинэчилсэн найруулгын төслийг баталсан юм. Уг хууль нь 8 бүлэг, 28 зүйлтэй бөгөөд Монгол Улсад хуулийн этгээд шинээр үүсэн байгуулагдсан, өөрчлөн байгуулагдсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бичгээр болон цахим хэлбэрээр бүртгэх, иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгох, улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Хувиараа аж ахуй эрхлэгчтэй холбоотой бүртгэл Татварын ерөнхий хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу бүртгэгдэх ёстой боловч хуулийн этгээдийн бүртгэлтэй нэгэн адил заавал бүртгүүлэх эрх зүйн механизм байхгүй юм. Өөрөөр хэлбэл, аж ахуй эрхлэгчид татвар ногдуулах зорилго бүхий бүртгэл хийдгээс татвар төлөхгүй байх үүднээс бүртгэгддэггүй. Түүнчлэн татварын бүртгэл нь аж ахуй эрхлэгчийн мэдээллийг нийтэд ил болгохгүй бөгөөд аж ахуй эрхлэгчдийн хэлцлийн баталтгаат, найдвартай байдалд нөлөө үзүүлэхгүй.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 6 дугаар зүйлд жижиг, дунд хэмжээний аж ахуй эрхлэгчдийг бүртгэх зохицуулалт тусгагдсан ч сайн дурын бүртгэл бөгөөд заавал бүртгэх тогтолцоо биш бөгөөд үүнд хувиараа аж ахуй эрхлэгч болон хуулийн этгээдийн хэлбэрээр аж ахуй эрхлэгч аль аль нь бүртгүүлэх боломжтой боловч арилжаа эрхлэгчийн нэгдсэн бүртгэлийн тогтолцоо биш юм.

Түүнчлэн аж ахуй эрхлэгчийн бүртгэлийн тогтолцооны гол зорилго нь аж ахуй эрхлэгчийн мэдээллийг нээлттэй болгох замаар хэлцлийг түргэн, шуурхай, баталгаатай явагдах боломжийг олгох боловч манай улсад ийм тогтолцоо байхгүйгээс аж ахуй эрхлэгчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн зохицуулалт мөн хэрэгжих боломжгүй. Өөрөөр хэлбэл төлөөллийн харилцааг зөвхөн Иргэний хуулийн төлөөллийн зохицуулалтаар зохицуулах бөгөөд төлөөлөх эрхгүй этгээдийн хийсэн хэлцэл, төлөөллийн гаднах байдалд итгэсэн хэлцлийн нөгөө талын хамгаалалтын зохицуулалт, итгэлийг хамгаалах зарчмууд хэрэгжих боломжгүй бөгөөд эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь асуудал үүсэх шалтгаан болж байна.

Б. Арилжааны нэрийн талаар

Арилжааны нэр нь эдийн засгийн үр өгөөж бий болгох утгаараа эд хөрөнгөд тооцогдож түүнийг өвлүүлэх, бэлэглэх, шилжүүлэх, гадны халдлагаас хамгаалах зэрэг эрх зүйн хамгаалалт шаардлагатай болдог. Түүнчлэн бизнесийн хамтрагч болох нөгөө талын хувьд арилжааны нэрэнд төөрөгдөхгүй, түүнээс ямар нэгэн хохирол хүлээхгүй байх зэрэг шаардлагын үүднээс эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах хэрэгцээ бий болгохоос гадна аж ахуй эрхлэгчийг нэрлэх, танин мэдэх, бараа бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, мэдээллийг түгээх, ялгаатай байдлыг бий болгох, хариуцлага хүлээх эрх зүйн үр дагаврыг үүсгэх зорилготой.

Гэтэл манай улсын хувьд арилжааны нэр гэх ойлголтыг зохицуулаагүй байх бөгөөд Иргэний хууль дахь хуулийн этгээдийн оноосон нэр, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль дахь барааны тэмдгийн алинд нь хамаарах эсэх нь тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “барааны тэмдэг гэдэг нь иргэн, хуулийн этгээдийн өөрийн үзүүлж буй өрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг” ойлгох бол хуулийн этгээдийн нэр нь тухайн хуулийн этгээдийг бусад хуулийн этгээдээс ялгах чадварыг илэрхийлдэг.

Дээрхээс үзэхэд барааны тэмдэг гэдэгт арилжааны нэр хамаарахааргүй бөгөөд Иргэний хууль дахь хуулийн этгээдийн оноосон нэртэй илүү төсөөтэй ойлголт юм. Гэсэн хэдий ч хуулийн этгээдийн оноосон нэр нь өөрөө бие даасан барааны тэмдэгт хамаарах эсэх нь тодорхойгүй, хуулийн этгээдийн оноосон нэр олгох субъект, барааны тэмдгээр бүртгэж, гэрчилгээжүүлэх субъектүүд нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон Оюуны өмчийн газар байдаг.

Иймд хуулийн этгээдийн нэр буюу аж ахуй эрхэлж буй этгээдийг бусдаас ялгах, өөрийн нэрийг хуулиар хамгаалуулах, бусдад ашиглуулах замаар ашиг олох боломжид саад учруулдаг. Өөрөөр хэлбэл хуулийн этгээдийн нэр болон арилжааны нэр нь барааны тэмдэгт хамаарах талаар эрх зүйн зохицуулалтгүйгээс хуулийн этгээдийн ижил төстэй нэр олгох, бусад этгээд тухайн нэрийг өөрт ашигтайгаар ашиглах замаар бусдыг төөрөгдүүлэн ашиг олох үйлдлүүд гарч байгааг шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргаанаас тодорхой харж болно.

Түүнчлэн хувиараа аж ахуй эрхлэгч нь аж ахуйн үйл ажиллагаандаа арилжааны нэр ашиглах боломжтой бөгөөд хуулийн этгээдийн нэгэн адил арилжааны нэрээр дамжуулан бараа, бүтээгдэхүүний мэдээллийг түгээх, сурталчлах, бусдаас ялгах шаардлагатай бөгөөд эдийн засгийн эргэлтэд оруулах замаар ашиг хүртэх боломжтой байдаг. Харин манай улсын хувьд зөвхөн хуулийн этгээдийн хувьд хуулийн этгээдийн оноосон нэрийг авч ашиглах эрхтэй боловч хувиараа аж ахуй эрхлэгчийн хувьд арилжааны нэртэй байх, түүнийг ашиглах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Гэтэл хуулийн этгээдийн оноосон нэр нь арилжааны нэрийн хувьд барааны тэмдэгийн хамгаалагдах эрхийн объектэд хамаарснаар аж ахуй эрхлэгч өөрийн бизнесийн нэрээ зөвхөн дотоодод төдийгүй олон улсад хамгаалуулах, тухайн нэрийг бусдад гэрээний үндсэн дээр шилжүүлэх, ашиглуулах замаар ашиг олох боломжийг олгодог ч манай улсын эрх зүйн зохицуулалтын хувьд арилжааны нэрийг зохицуулаагүй орхигдуулсан байна.

В. Хөөн хэлэлцэх хугацааны талаар

Хөөн хэлэлцэх хугацааны талаар Монгол Улсын Иргэний хуулийн 74-82 дугаар зүйлд зааснаар зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, дээрх зохицуулалт нь Иргэний хууль дахь үүргийн эрх зүйд бүхэлд нь адил үйлчлэх зохицуулалт бөгөөд иргэд хоорондын хэлцлийн харилцаа болон аж ахуй эрхлэгч хоорондын хэлцлийн харилцааны хөөн хэлэлцэх хугацааны талаар ялгамжтай зохицуулаагүй. Хэдийгээр Татварын хууль татвар ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа зэргээр бусад хуульд ялгамжтай байдлаар хөөн хэлэлцэх хугацааг заасан байдаг ч энэ нь гэрээний үүрэгтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацаанд хамаардаггүй.

Энэ нь аж ахуй эрхлэгчдийн хоорондын гэрээ, хэлцэл хийснээс хойш удаан хугацаа өнгөрсний дараагаар маргаан үүсэх, хэлцлийн баталгаат байдлыг алдагдуулахад хүргэдэг. Тухайлбал, Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д “хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа арван жил”, “гэрээний үүрэгтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацаа 3 жил”, “үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа 6 жил” зэргээр тусгасан нь эрх зүйн харилцааны объектийн хувьд ялгамжтайгаар зохицуулсан байна.

Г. Төлөөлөх бүрэн эрхийн талаар

Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид аж ахуйн үйл ажиллагааны талаар шүүхийн болон шүүхийн бус аливаа үйлдэл хэрэгжүүлэх бүрэн эрх олгогдсон этгээд болон аж ахуй эрхлэгч хоорондын хэлцэлд төлөөлөх бүрэн эрхийн талаар нарийвчлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй байна.

Одоогийн байдлаар Иргэний хуулийн 62-р зүйлээс 70-р зүйл хүртэлх хэм хэмжээний дагуу энэхүү харилцааг зохицуулж байгаа боловч, эдгээр зохицуулалт нь иргэд хоорондын төлөөллийн харилцаанд хэрэглэгдэх бөгөөд энэ нь аж ахуйн үйл ажиллагааны ашгийн төлөөх шинж, хэлцэл хурдан, шуурхай байх, гэрээний зардал аль болох бага байх, хэлцлийн баталгаат байдлыг хангах зэрэг зарчимд суурилаагүй хэм хэмжээ болно.

Хуулийн этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй удирдах байгуулагаас гадна, шүүхийн болон шүүхийн бус аливаа үйл ажиллагаа, хэлцэлд төлөөлөх ерөнхийлсөн бүрэн эрх олгогдсон этгээдийн талаар, түүний төлөөлөх бүрэн эрхийн талаар зохицуулсан хэм хэмжээ одоогоор хуульчлагдаагүй байна. Жишээ нь компанийн хувьд үйл ажиллагаа хариуцсан захирал, хүний нөөц хариуцсан захирал, хууль, эрх зүйн газрын захирал, борлуулалтын албаны дарга гэх мэт албан тушаал бий. Эдгээр албан тушаалын хувьд тухайн компанитай гэрээ байгуулах замаар компанийн тухайн нэг үйл ажиллагааны талаарх шүүхийн болон шүүхийн бус аливаа төлөөлөх бүрэн эрхийг эдэлж болох юм. Гэвч бодит байдал дээр гүйцэтгэх захирлын бүрэн эрхэд эдгээр хоорондоо ялгаа бүхий харилцаанд төлөөлөх бүрэн эрхийг бүхэлд олгосон мэтээр хандаж, аж ахуйн үйл ажиллагааг явуулахад хүндрэл, чирэгдэл учрах байдал гарсаар байна.

Д. Аж ахуйн шинжтэй хэлцлийн талаар

Иргэний хуулийн зохицуулалт нь нэг удаагийн шинжтэй харилцааг зохицуулахад чиглэгдсэн тул байнгын аж ахуйн харилцаатай байдаг этгээдүүдийн хоорондын харилцааг зохицуулахад хангалтгүй байна. Хэлцэл хийж буй аж ахуйн эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах, хурдан шуурхай хугацаанд эрх зүйн харилцаа тодорхой

болох зохицуулалт хангалттай системчлэгдээгүй байна. Аж ахуйн шинжтэй хэлцлийг зохицуулах зарим зохицуулалт байхгүй буюу зохицуулалтын хувьд хангалтгүй байна.

Түүнчлэн Арилжаа (худалдаа)-ны эрх зүйн хувьд ерөнхий ангийн шинжтэй зохицуулалтууд болох худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгчийн талаарх зохицуулалт нь иргэний эрх зүйн хувьд тусгай ангид хамаарах зохицуулалтад тооцогдож байна. Тиймээс Арилжаа (худалдаа)-ны эрх зүйн ерөнхий болон тусгай ангийн системчлэлийг аж ахуйн шинжтэй хэлцлийн хувьд нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Ингэснээр тухайн хэлцэл хоорондын харилцан, хамаарал, системчилсэн тайлбар хийх асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах болно.

Үүнээс гадна аж ахуйн шинжтэй хэлцлийг байгуулах этгээд буюу аж ахуй эрхлэгчийг гүйцэт тодорхойлж өгөөгүйгээс иргэд хоорондын хэлцлийн хувьд аж ахуйн эрхлэгчид хамаарах ёстой зохицуулалтыг хэрэглэх аюултай.

Хэдийгээр манай улсын Иргэний хуульд арилжааны эрх зүйн шинж бүхий зохицуулалтыг агуулж буй болохыг өмнөх хэсэгт тодорхой эрх зүйн зохицуулалтын хүрээнд тайлбарласан бөгөөд тухайн зохицуулалтууд нь тодорхой бус, ерөнхий зохицуулалтын шинжтэйгээс шүүх хуулийг хэрэглэхдээ иргэн болон аж ахуй эрхлэгчийн харилцааг ялгахгүйгээр шийдвэрлэж буй тохиолдол байна. Эдгээрийг тус бүрт нь дараах байдлаар дэлгэрүүлэн үзье.

Ж. Аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх шинжийн талаар

Иргэний хуулийн 222-р зүйлийн 222.5 дахь хэсэгт “Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй” гэж заасан байдаг. Манай улсын шүүхийн практикт “тохирсон хүү” гэх ойлголтыг хэрхэн ойлгох талаар талууд гэрээгээр тохиролцож “тохирсон хүү” гэж үзэх үү, эсвэл гэрээгээр тохиролцсон эсэхээс үл хамаарах хуульд заасан хүү юу гэсэн асуудал маргаан дагуулдаг. Өөрөөр хэлбэл шүүхийн практик мөн уг заалтыг хуульд заасан хүү шаардах эрх олгосон заалт гэж тайлбарлах байдал ажиглагдаж байна.

Түүнчлэн Иргэний хуулийн 222-р зүйлийн 222.5 дахь хэсгийг хуульд зааснаар хүү шаардах эрхийг олгож буй заалт гэж тайлбарласнаар үүсэж буй асуудал нь “тохирсон хүү” гэдэгт хэр хэмжээний хүүг ойлгох вэ гэсэн асуудал шүүхийн практикт гарч байна.

Иймд хуульд зааснаар хүү шаардах эрхийг автоматаар үүсдэг тогтолцоог арилжааны эрх зүйн хэм хэмжээгээр бий болгох шаардлагатай байна. Нөгөө талаас Иргэний хуулийн 222-р зүйлийн 222.5 дахь хэсгийг хуульд заасан хүү шаардах эрх гэж тайлбарлаж буй нь зарим талаараа практикт нийцсэн тайлбар бөгөөд энэ нь аж ахуй эрхлэгч хуульд зааснаар хүү шаардах эрхийг автоматаар олж авах эрхтэй байхаар хуульчлах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Мөн “тохирсон хүү” гэх тодорхойгүй, ерөнхий нэр томьёо хэрэглэсэн нь хуулийн зохицуулалтыг уян хатан байдлаар хэрэглэх боломжийг нээж өгч буй бөгөөд хууль тогтоогчийн урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдалд тухай бүр шүүхээс зохистой шийдвэр гаргахад ач холбогдолтой заалт болно. Харин аж ахуй эрхлэгчийн хувьд ийм тодорхойгүй зохицуулалтын үйлчлэлд байх нь зохисгүй байдаг. Учир нь аж ахуй эрхлэгч нь орлого, зарлагаа тооцох ёстой бөгөөд хир хэмжээний өр төлөөс үүрч буйгаа мэдэх боломжтой байх ёстой.

Дараагийн нэг асуудал нь аж ахуй эрхлэгч бусдын өмнөөс аливаа үйл ажиллагаа явуулсан, хэлцэл хийсэн бол гэрээндээ хөлс авахаар тодорхой тохиролцоогүй байсан ч түүний ашгийн төлөөх зорилгыг хангах үүднээс хуульд зааснаар зохих хөлс авах боломжтой байх ёстой. Иргэний хуулийн үүргийн ерөнхий ангийн зохицуулалтад энэ талаар тодорхой зохицуулалт байдаггүй. Харин иргэний хуулийн гэрээний тусгай төрөл тэр дундаа бусдад ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээнд хөлс шаардах эрхийг зохицуулсан байна.

Тус зохицуулалт нь аж ахуй эрхлэгчийн зарим үйл ажиллагаанд хөлсийг харилцан тохиролцсон гэж үзэж хөлсөө шаардах эрхтэй байх, зарим үйл ажиллагаанд хөлсийг харилцан тохиролцсон гэж үзэхгүй байх үр дагавартай юм. Гэтэл аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах үүднээс аж ахуй эрхлэгчийн гүйцэтгэсэн уг ажил нь түүний аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хамаардаг л бол хөлс шаардах эрхтэй байх нийтлэг зохицуулалт шаардлагатай байна.

Нөгөө талаас аж ахуйн үйл ажиллагааг Иргэний хуульд заасан цөөн тооны нэрлэгдсэн гэрээгээр хязгаарлаж болохгүй тул нэрлэгдээгүй гэрээ байгаа тохиолдолд одоогийн Иргэний хуулийн зохицуулалтын хүрээнд аж ахуй эрхлэгч нь бусдын өмнөөс хэлцэл хийсэн, үйл ажиллагаа явуулсан тохиолдолд гэрээгээр тусгайлан тохиролцоогүй бол гүйцэтгэсэн ажлынхаа хөлсийг шаардах эрхгүй байхаар байна.

3. Гэрээ байгуулах зардал

Иргэний эрх зүй дэх гэрээтэй холбоотой зардлыг гэрээ байгуулах зардал болон үүрэг гүйцэтгэх зардал гэж 2 хувааж авч үздэг. Гэрээ байгуулах болон гэрээний үүргийн гүйцэтгэлд гарах зардлыг хэн хариуцах нь чухал ач холбогдолтой юм. Гэрээ байгуулах зардлын талаар Иргэний хуульд тодорхой зохицуулалт байхгүй байна. Ийнхүү хуулийн зохицуулалтгүй байдлын улмаас гэрээ байгуулах зардлыг хэрхэн хэн хариуцах асуудал шүүхийн практик маргаан дагуулсан асуудал болдог болохыг Зээлийн гэрээний шимтгэлийн асуудлаас тодорхой харагдаж байна.

Ё. Хэлцлийн баталгаат байдлыг хангах

Аль хэдийн олж авсан эрх, ашиг сонирхлоо бусдын үйлдлийн улмаас алдахгүй байх явдлыг хуулиар хамгаалахыг “хөдөлгөөнгүй баталгаат байдал” гэж нэрлэдэг. Нөгөө талаас шинээр эрх, ашиг сонирхол олж авах гэж буй тохиолдолд тухайн эрх, ашиг сонирхол олж авч буй үйлдлийг хуулиар хамгаалахыг “хөдөлгөөнт баталгаат байдал” буюу “хэлцлийн баталгаат байдал” гэж хэлдэг. Манай улсын хувьд Иргэний хуулиар эсрэг тал нь өмчлөх эрхтэй гэсэн итгэл үнэмшлийг л хамгаалах бөгөөд ХБНГУ-ын Худалдааны хууль шиг өмчлөх эрхээр хязгаарлагдахгүй барьцаалах, захиран зарцуулах эрхтэй гэсэн итгэл үнэмшлийг хамгаалдаггүй нь аж ахуйн үйл ажиллагаанд итгэлцлийг хамгаалах зарчим бүрэн хэрэгжих боломжгүй болгодог.

Е. Хэлцлийг баталгаажуулах

Иргэний хуулийн 215-р зүйлийн 215.1 дэх хэсэгт “Үүрэг гүйцэтгүүлэгч хүлээсэн үүргээ биелүүлж үүрэг гүйцэтгэх боломж бүрдүүлэх хүртэл үүрэг гүйцэтгэгч нь мөнгөн төлбөрийнхөөс бусад үүргийн гүйцэтгэлийг саатуулж болно” гэж заасан. Энэхүү зохицуулалтаар үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардах эрхийн эсрэг үүрэг гүйцэтгэгч мөн шаардах эрх хэрэгжүүлэх боломжтой бол энэ үүргийг биелүүлэх хүртэл хариу үүргээс

татгалзах эрхтэй байх ба үүрэг гүйцэтгэгчийн саатуулан барих эрхийг зохицуулдаг. Энэ саатуулах эрхийн хувьд харилцан шаардах эрхүүд холбоотой байх буюу нэг ижил эрх зүйн харилцаанаас үүдэлтэй байх урьдчилсан нөхцөл тавигддаг. Түүнчлэн Иргэний хуулийн гэрээний тусгай төрлийн зохицуулалтанд саатуулан барих эрхийг хуульчилж өгсөн байна.

Иргэний хуулийн дагуу саатуулан барих эрх үүсэхийн тулд барьцаагаар хангагдах шаардах эрх болон барьцааны зүйл нь хооронд холбоотой байх шаардлагатай буюу барьцааны зүйлтэй холбогдож үүссэн шаардах эрх байх хэрэгтэй. Энэ нь бизнесийн харилцаанд тохиромжгүй. Харин бизнес эрхлэгчдийн хооронд тогтмол хийгдэж буй арилжаанаас үүссэн шаардах эрхийг хангуулахын тулд тухайн арилжаатай холбоогүй тусдаа хэлцлийн дагуу эсрэг талын өмчлөлийн зүйл нь шаардах эрх бүхий бизнес эрхлэгчийн эзэмшилд байгаа бол үүнийг саатуулан барих байдлаар тухайн шаардах эрхээ хангуулж болохоор хуульчлах шаардлагатайг илтгэдэг.

Түүнчлэн Иргэний хуулийн 458-р зүйлийн 458.3 дахь хэсэгт “Батлан даалтын гэрээгээр батлан даагчийн хүлээсэн үүрэг нь үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэгт хамаарна” гэж заасан бөгөөд батлан даагч бусдын үүргийг үндсэн үүрэг гүйцэтгэгчийн хажуугаар зэрэгцэн гүйцэтгэхээр амлах тул юуны өмнө батлан даах үүрэг үүссэн ёстой гэж үздэг. Иймээс бизнес эрхлэгчдийн хооронд тогтмол хийгдэж буй арилжаанаас үүссэн үүргийн гүйцэтгэлийг нийтэд нь хангах арга болж чадах эсэх эргэлзээтэй байна.

Иргэний хуулийн 242-р зүйлийн 242.2 дахь хэсэгт “Хамтран хүлээх үүрэг нь хууль буюу гэрээнд зааснаар, эсхүл үүргийн зүйлийн үл хуваагдах шинж чанартай холбоотой үүснэ” гэж заасан тул гэрээгээр хамтран үүрэг гүйцэтгэхээр тохироогүй тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэх харилцаа үүсэхгүй гэж үзэх ба харин бизнесийн харилцаанд үүргийг бүхэлд нь гүйцэтгэх хүртэл үүрэг гүйцэтгэгчдийн хэн нь ч үүргээс чөлөөлөгдөхгүй буюу хамтран үүрэг гүйцэтгэхээр зохицуулах зөв юм. Хамтран үүрэг гүйцэтгэх зарчмыг бизнесийн харилцаанд үндсэн зарчим болгож хэрэглэх шалтгаан нь худалдааны хэлцлээс үүсэх үүргийг илүү баталгаажуулах бөгөөд хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэн нэг нь үүрэг гүйцэтгэх чадамжгүй боллоо гэхэд бусад үүрэг гүйцэтгэгчид үүргийг бүхэлд нь гүйцэтгэх үүрэг хүлээдэгт байдаг.

Иргэний хуулийн 167-р зүйлийн 167.1 дахь хэсэгт “Үүрэг гүйцэтгүүлэгч ипотекийн эрхийн бүртгэлийг нотолгоо болгохгүйгээр зөвхөн өөрийн шаардлагыг нотлох замаар ипотекийн эрхээ хангуулахаар хэлэлцэн тохиролцож болох бөгөөд уг ипотекийг улсын бүртгэлд баталгаат ипотека гэж бүртгэнэ” гэж зааснаар байнгын арилжааны харилцаатай байдаг этгээдтэй үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байгуулан ирээдүйд арилжааны харилцаанаас үүсэх үүргийн гүйцэтгэлийг тодорхой үнийн дүнгээр хангуулах тохиролцоог хийх боломжийг баталгаат ипотека олгодог. Үл хөдлөх хөрөнгөнөөс бусад хөрөнгөд баталгаат ипотекаын адил хууль зүйн үр дагавар бий болгох шаардлагатай байна.

Үл маргах журмын хувьд Иргэний хуулийн 234-р зүйлийн 234.4 дэх хэсэгт “Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаардана”, Иргэний хуулийн 453-р зүйлийн 453.2 дахь хэсэгт “Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол тухайн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлдүүлэгч

захиран зарцуулах эрхтэй. Энэ заалт зөвхөн хөдлөх эд хөрөнгөнд хамаарна” гэж тус тус үл маргаж журмын талаар зохицуулсан байдаг боловч гэрээгээр тохиролцсон үл маргах журмыг албадан биелүүлэх тогтолцоо манай улсад байдаггүй тул эдгээр бодитоор хэрэгжихэд саад байна.

Үл маргаж журам нь шүүхийн шатыг алгасах, үүргийн гүйцэтгэлээ хурдан шуурхай хугацаанд олж авах боломжийг олгодог тул хэлцлийн нийтлэг зохицуулалт байдлаар талууд тохиролцвол гэрээндээ хэрэглэдэг байх зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

10. Хэлцлийн хурдан шуурхай байдлыг хангах асуудал

Хэлцлийн хурдан шуурхай байдлыг хангах гэдэг нь хэлцэл богино хугацаанд байгуулагдах, өөрчлөгдөх, дуусгавар болсон эсэх нь тодорхой болж байх ёстойг хэлдэг.

Хөөн хэлэлцэх хугацаа болон гомдлын шаардлага гаргах хугацааны хоорондын харилцааны талаар авч үзэх шаардлагатай байна. Учир нь Иргэний хуулийн 76-р зүйлийн 76.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан, түүнчлэн гомдлын шаардлага гаргах буюу баталгаат хугацаа тогтоосон бол гомдлын шаардлагын хариуг авсан буюу эдгээр хугацаа дууссан үеэс үүснэ” гэж зааснаас гадна гэрээний тусгай төрлийн зохицуулалтад гомдлын шаардлага гаргах тусгай хугацааг заасан байдаг.

Энд Иргэний хуулийн “гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно” гэсэн шийдэл нь ялангуяа аж ахуйн хэлцэлд тохиромжгүй юм. Өөрөөр хэлбэл ердийн тохиолдолд шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа тоологдож байгаа бол худалдах худалдан авах, ажил гүйцэтгэх гэх мэт гэрээнүүдийн хувьд тухайлбал доголдлын хувьд доголдолтой байсныг мэдсэн бол гомдлын шаардлага гаргах хугацаа тоологдон түүний дараагаар хөөн хэлэлцэх хугацаа тоологдож байна.

Түүнчлэн хэлцлийн хурдан шуурхай байдлыг хангах гол асуудал нь аж ахуй эрхлэгчийн анхаарал болгоомжтой байх буюу доголдлыг шалгах үүрэг байдаг. Гэтэл аж ахуй эрхлэгчид байх анхаарал болгоомжтой байх үүрэг болон аж ахуй эрхлэгч бус этгээдийн анхаарал болгоомжтой байх үүрэг хоорондоо ялгаатай болохыг Монгол Улсын Иргэний хуулиар хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэвч шүүхийн практикт эдгээрийг ялгаж хэрэглэхгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Энэ талаар мөн 2017 оны Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмжид “...орон сууцны талбайн хэмжээг мэргэжлийн эсвэл зохих байгууллагаар **хэмжүүлж, шалгаж**, эд хөрөнгөө хүлээн авах, энэ байдлаар эд хөрөнгөө аваагүй бол худалдан авагч Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн 255.1.1-т зааснаар шаардах эрхээ алдана.” гэж мөн дурдсан байдаг. Энэ тохиолдолд Улсын Дээд шүүх нь “мэдэх боломжтой” гэсэн урьдчилсан нөхцлийг хэрэглэхдээ “орон сууцны талбайн хэмжээг мэргэжлийн эсвэл зохих байгууллагаар хэмжүүлж, шалгаж, эд хөрөнгөө хүлээн авах” гэдэгтэй дүйцүүлж буйг харж болно.

Гэтэл Иргэний хуулийн 255-р зүйлийн 255.1.2-т “аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь уг үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийг шилжүүлэн авах үедээ

нэн даруй **шалган авах үүргээ биелүүлээгүй**” гэж аж ахуй үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдээс эд хөрөнгө хүлээн авахдаа ердийн тохиолдолтой харьцуулахад илүү анхааралтай байхыг хуулиар шаарддаг тул энгийн иргэн заавал эд хөрөнгийг хүлээн авахдаа заавал шалгах үүрэг хүлээхгүй.

Эндээс дүгнэлт хийвэл хоёр аж ахуй эрхлэгчийн хоорондын худалдах, худалдан авах гэрээнд эрх зүйн харилцааг аль болох эрт үеэс тодорхой болгох зорилго бүхий худалдан авагч аж ахуй эрхлэгчид оногдуулсан шалгах үүрэг болон ердийн “мэдэх боломжтой” гэсэн урьдчилсан нөхцлийг хооронд нь ялгамжтай байдлаар авч үзээгүй байна. Энэ нь иргэний эрх зүй болон арилжааны эрх зүйн, ахуйн харилцаа болон аж ахуйн харилцааг хооронд нь тодорхой байдлаар ялгаж, системчлэж ирээгүйтэй холбоотой.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго: “Аж ахуй эрхлэгчийн хооронд үүсэх эрх зүйн харилцааг түргэн, шуурхай үүсгэж, дуусгавар болгох замаар арилжааны хэлцлийн баталгаат байдлыг хангах”;

Зорилт 1.: “Аж ахуй эрхлэгчийн зүгээс олгож буй төлөөлөх бүрэн эрхийн талаарх харилцааг нарийвчлан зохицуулах”;

Зорилт 2. “Аж ахуй эрхлэгчийн арилжааны бүртгэлийн тогтолцоог бий болгож, хэлцлийн баталгаат байдлыг хангах”;

Зорилт 3. “Арилжааны нэрийн зохицуулалтыг бий болгож оюуны өмчийн хамгаалагдах эрхийн объектэд хамааруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах зохицуулалтыг бий болгох”;

Зорилт 4. “Арилжаа эрхлэгчдийн хооронд байгуулагдах хэлцлийн хөөн хэлэлцэх хугацааг оновчтой тогтоож, хэлцэл түргэн, шуурхай хийгдэж, дуусгавар болох зохицуулалтыг бий болгох”;

Зорилт 5. “Аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах зорилготой хүү шаардах эрх, төлбөртэй байх зарчим, хуульд заасан хүүгийн хэмжээ зэрэг асуудлыг хамарсан зохицуулалтыг бий болгох буюу аж ахуй эрхлэгчийн хөрөнгө, үйлчилгээ зэргийн үнэ цэнийг алдагдуулахгүй байх”

Зорилт 6. “Аж ахуй эрхлэгчийн хэлцэл, гэрээ байгуулах зардлыг бууруулах зорилгоор, түүний итгэж, үнэмшсэнийг хамгаалах зохицуулалтыг нарийвчлан зохицуулах”

Зорилт 7. “Арилжаа (худалдаа)-ны гэрээний тусгай төрлийн талаарх зохицуулалтыг аж ахуйн үйл ажиллагаанд таатай байдлаар нарийвчлан зохицуулах”

Зорилт 8. “Арилжаа (худалдаа)-ны гэрээний тусгай төрлийн зохицуулалт хоорондын системчлэлийг тодорхойлох”

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 5.1 дүгээр зүйлд зааснаар асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгыг биелүүлэхэд чиглэсэн хувилбаруудыг тогтооно.

Аргачлалын дээрхи зүйлд зааснаар асуудлыг шийдвэрлэх доор дурдсан хувилбарууд байна:

- 5.1.1.“тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
- 5.1.2.хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;
- 5.1.3.зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
- 5.1.4.төрөөс санхүүгийн интервенц хийх;
- 5.1.5.төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
- 5.1.6.захиргааны шийдвэр гаргах;
- 5.1.7.хууль тогтоомжийн төсөл боловсруулах

Дээр дурдсан Аргачлалын 5.1.1–5.1.6-д заасан хувилбаруудын агуулгаас харахад эдгээр хувилбаруудын аль нь ч энэхүү тайлангийн Хоёр дахь хэсэгт заасан асуудлыг шийдвэрлэх зорилтод хүрэх хувилбар болохгүй байна. Учир нь энэхүү асуудал үүсэх болсон шалтгаан, нөхцөл нь одоогийн хууль тогтоомжид тухайн асуудлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй байгаа болно. Тиймээс зөвхөн “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” буюу Аргачлалын 5.1.7-д заасан хувилбараар зорилтод хүрэх боломжтой гэж үзэж байна.

Энэхүү дүгнэлтэд хүрэхдээ хувилбаруудыг сонгосноор зорилгод хүрэх байдал, хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үр өгөөжийн харьцаа зэрэг үзүүлэлтээр харьцуулан судалж дүгнэсэн болно.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Хуулиар зохицуулагдахгүй байгаа асуудал, бэрхшээл хэвээр үлдэнэ. Зорилгод хүрэх боломжгүй.	Зардал гарахгүй боловч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён	Хуулиар зохицуулагдаагүй байгаа асуудал бэрхшээл хэвээр үлдэнэ. Зорилгод хүрэх боломжгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан, нөхцлийг арилгаж, бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

	гэгээрүүлэх			
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан, нөхцлийг арилгаж, бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс интервенц хийх шаардлагагүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан, нөхцлийг арилгаж, бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Энэ нь бүхий л аж ахуй эрхлэгчид хамааралтай. Тодорхой холбоод үүнийг шийдвэрлэх боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан, нөхцлийг арилгаж, бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэрээр зохицуулах боломжгүй. Энэ нь хувийн чөлөөт байдлын зарчимд суурилна.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан, нөхцлийг арилгаж, бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зохицуулагдаагүй байгаа харилцааг зохицуулах боломжтой болно.	Зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэх гол гарц болно.	Үр дүнтэй.

Ерөнхийд нь ямар ч хуулийг батлахдаа хэнд хандаж, ямар харилцааг зохицуулах хэм хэмжээг бүтээх үү гэдэг нь гол асуудал боловч тухайн тохиолдолд 1) хууль тогтоох бүтцийн үндсийг тухайн хуулиар зохицуулагдах субъектэд зориулж бүтээх үү? 2) түүнийг зохицуулж буй харилцааг голчлох уу? 3) эсхүл хуулиар зохицуулагдах субъект, харилцааг аль алиныг нь голчилж хууль батлах уу гэх үндсэн гурван хандлага байдаг. Үндсэндээ энэхүү гурван хандлага нь хууль тогтоогч хуулийг батлахдаа аль хандлагыг нь чухалчлах уу гэдгээрээ ялгагдах ба тухайлбал субъектийг гол болгох хандлагаар хуулийг бүтээсэн тохиолдолд тухайн харилцааны зохицуулалтыг огт зохицуулахгүй гэсэн зүйл биш юм.¹⁴

Гэтэл 19 дүгээр зуунаас эхлэн эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий олон улсуудад Худалдааны хуулийг баталсан ч дээрх гурван хандлагын аль алиныг нь баримталсан байдаг. Юуны өмнө субъектийн онолыг баримталсан Худалдааны хуулийн гол төлөөлөгч нь 1900 оны Германы Худалдааны хууль юм. Өөрөөр хэлбэл Худалдааны хуулийн гол

¹⁴落合誠一、大塚隆児（2007年）「商法Ⅰ－総則・商行為」、10－11頁。

үндэс нь Худалдаа эрхлэгч гэх (Худалдааны хуулийн субъектийн онол) нэр томъёог тодорхойлж, тухайн худалдаа эрхлэгчд зориулагдсан байдлаар бүтэцлэгддэг байна. Үүнийг дагалдаад Худалдааны хууль нь худалдаачныг зохицуулах хууль бөгөөд хэлцлийн зохицуулалтыг худалдаачны хийж буй хэлцэл л хуулийн зохицуулах хүрээнд хамаарна гэж үзэж субъект нь хуулийн гол зохицуулах харилцаа болж хэлцлийн зохицуулалт нь түүнийг дагалдах шинжтэйгээр хуульчлагддаг. Тиймээс энэхүү Худалдааны хууль батлах хандлагыг Субъектив онол (Худалдаачны эрх зүй) гэж нэрлэдэг.

1998 оны ХБНГУ-ын Худалдааны хуулийн нэмэлт өөрчлөлтөөр худалдааны хэлцэл гэх ойлголтыг өргөтгөн аж ахуйн үйл ажиллагаа (Gewerbebetrieb) явуулж бүхий л этгээдийг худалдаачин буюу аж ахуй эрхлэгч гэж үзэхээр болсон байдаг.

Субъектив онол нь арилжааны хуулийг бүтээх сүүлийн үеийн дэлхийн чиг хандлага гэж хэлж болно. Тухайлбал Вьентнамын Худалдааны хуулийн 6-р зүйлд “Аж ахуй эрхлэгч гэж худалдааны бүртгэлд бүртгэгдсэн хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд, бие даан тогтвортой аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй хувь хүнийг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Субъектив онолын давуу тал нь ямар хэлцлийг худалдааны хэлцэл гэж тодорхойлох вэ гэсэн хүнд асуудалтай тулгарахгүй юм. Объектив онол нь тодорхой хэлцлийг худалдааны хэлцэл гэж үздэг бөгөөд худалдааны хэлцэлийг дотор нь объектив худалдааны хэлцэл, аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл гэж хуваадаг.

Яагаад зарим хэлцлийг объектив худалдааны хэлцэл гэж авч үзсэн бэ гэдгийг тодруулахын тулд дундад зуунд Европд худалдааны эрх зүй үүсч хөгжсөн үеийг авч үзэх шаардлагатай болдог. Тухайн үеийн Европын нийгэм газар тариалангийн үйлдвэрлэл дээр тогтож байсан бөгөөд энэ үед тухайн үеийг хүртлэх нийгмээс ялгагдах нэгэн онцлог бий болсон нь газар тариалангийн үйлдвэрлэлд технологийн дэвшил гарсантай холбоотойгоор газар тариалангийн үйлдвэрлэл харьцангуй тогтворжиж ирсэн ба тодорхой хэмжээнд илүүдэл гарах болж, уг илүүдлийг худалдан борлуулах үйл ажиллагаа бий болсон нь тухайн үеийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндэс болжээ. Ийнхүү уг төрлийн худалдан борлуулах үйл ажиллагаа явагдаж эхэлснээр газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн гэлтгүй олон төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулагдах болж бараа таваарын гүйлгээн/эргэлт/-д оролцох (財貨の流通媒介) үйл ажиллагаа нийгэмд төлөвшин, илүүдэл үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гүйлгээнд байнгын оролцож буй этгээд болох худалдаачид нь нийгмийн нэг давхаргыг бүрдүүлэх болжээ.

Гэхдээ зөвхөн бараа таваарын гүйлгээтэй холбон худалдааны эрх зүйн харилцааг тайлбарлах нь өнөө үед хэт явцуурсан хандлага болох билээ. Зөвхөн бараа таваарын гүйлгээ гэлтгүйгээр өөр төрлийн үйл ажиллагаа явуулсан ч гол нь яаж хийхээсээ хамаараад ашиг олох боломжтой юм. Өөрөөр хэлбэл объектив байдлаар өөртөө ашгийн төлөөх шинж агуулсан хэлцэл биш ч аж ахуйн зохион байгуулалтаар аливаа хэлцлийг хийвэл ямар ч хэлцэл худалдааны хэлцэл болох боломжтой гэж орчин үед үзэх болжээ.

Иймд ямар хэлцэл хийж байгаагаас үл хамааран аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулж байгаа бол аж ахуй эрхлэгч гэж үзэх субъектив онол нь арилжааны хуулийг

ХБНГУ-ын Арилжааны кодекс

§ 1 [Заавал арилжаа эрхлэгч байх ёстой этгээд]

(1) Энэ хуульд заасан арилжаа эрхлэгч гэдэгт худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг ойлгоно.

(2) Арилжаа эрхлэх гэдэгт аж ахуйн үйл ажиллагааны хэлбэр төрөл, хүрээ хязгаар нь худалдааны аргаар тохижуулсан ажлын байр шаардлагагүй гэж үзэхээс бусад аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах бүхий л тохиолдлыг ойлгоно.

§ 2 [Арилжаа эрхлэгч байж болох этгээд]

1. Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй нэгж нь энэ хуулийн §1-ийн 2-т заасан арилжаа эрхлэгч биш боловч арилжааны бүртгэлд бүртгэгдсэн бол арилжаа эрхлэгч гэж үзнэ. 2. Энэхүү аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч нь арилжааны хуулийн этгээдэд хамаарах хууль дүрмийн дагуу бүртгэлийг хийлгэж болно. 3. Ийнхүү бүртгүүлсэн бол энэ хуулийн §1.2-т заасан нөхцөл бүрдсэнээс бусад тохиолдолд тухайн хуулийн этгээдийг аж ахуй эрхлэгчийн хүсэлтээр бүртгэлээс хасч болно.

§ 3 [Хөдөө аж ахуй, ойн аж ахуй; арилжаа эрхлэгч байж болох этгээд]

(1) Хөдөө аж ахуй болон ойн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд энэ хуулийн §1 үйлчлэхгүй.

(2) Хэлбэр, төрлийн хувьд худалдаа үйлчилгээ явуулах шаардлага бүхий хөдөө аж ахуй ба ойн аж ахуй эрхлэгчид энэ хуулийн §2-ыг хэрэглэхдээ арилжааны бүртгэлд бүртгүүлсний дараа арилжааны нэгжийг бүртгэлээс хасахад үйлчлэх ерөнхий зохицуулалтыг баримтална.

(3) Хөдөө аж ахуй болон ойн аж ахуйн үйл ажиллагаатай эдгээр чиглэлийн дагавар үйл ажиллагааг холбосон бол уг дагавар үйл ажиллагаанд энэ зүйлийн 1 ба 2 дахь мөрийн зохицуулалт үйлчилнэ.

/орч. Б.Буянхишиг МУИС-ийн ХЗС-ийн багш /

хэрэглэхэд ямар ойлгомжтой болгодог бөгөөд орчин үеийн эдийн засгийн харилцаанд илүү зохимжтой хувилбар юм.

Үүний эсрэг хэлцэлд суурилсан Худалдааны хуулийн хандлага нь объектив онол (Худалдааны хэлцлийн эрх зүй) гэж нэрлэгдэж, үүний гол төлөөлөгч нь 1885 оны Испанийн Худалдааны хууль юм. Энэхүү хандлагаар хэн тухайн хэлцлийг хийх нь чухал биш бөгөөд тодорхой хүрээнд тогтоосон хэлцлийг худалдааны хэлцэл гэж тодорхойлж тухайн худалдааны хэлцэлд Худалдааны хууль үйлчилнэ гэсэн үзэл баримтлалаар хуулийг баталдаг. Энэ тохиолдолд заавал худалдаачны ойлголт байхгүй гэсэн утга биш ч худалдааны хэлцэл нь тэргүүлэх байр суурьтай байдаг. Өөрөөр хэлбэл худалдаа эрхлэгчийн хийсэн хэлцэл нь худалдааны хэлцлийн тодорхойлолтод хамаарахгүй бол худалдааны хэлцэлд тооцогдохгүй болохоор хэлцлийн зохицуулалтыг гол болгож худалдаа эрхлэгчийн зохицуулалт нь дагалдах шинжтэйгээр хуульчлагддаг.

Энэхүү объектив онол нь хэрэгжиж эхэлсэн цаг хугацааных нь хувьд аваад үзвэл бусад онолоосоо өмнө бий болсон байдаг. Тус онолоор Арилжааны хуулиар зохицуулах эрх зүйн харилцаа нь арилжааны хэлцлээр тодорхойлогдох болдог байна. Өөрөөр хэлбэл, арилжааны хэлцэл хийсэн л бол тухайн субъект иргэн байна уу, эсхүл аж ахуй эрхлэгч, худалдаачин байна уу гэдгийг харгалзан үзэхгүй гэсэн үг.

Тус онолын хувилбарын гол агуулга болон үндсэн шинж нь онолын гэхээсээ илүүтэйгээр түүхэн нөхцөл байдалд тулгуурласан гэж дүгнэж болох юм. Учир нь Францын хувьсгалын нөлөөгөөр ямар нэгэн нийгмийн анги, давхаргад тусгайлан

үйлчилдэг хууль батлах нь зарчмын бус үзэгдэлд тооцогдох болсон байдаг¹⁵. Ийм шалтгаанаар л зөвхөн аж ахуй эрхлэгч төдийгүй бүх иргэдэд хамааралтай байдлаар зохицуулах боломжийг эрэлхийлэх үүднээс арилжааны хэлцэл (acte de commerce) гэх ойлголтыг хууль зүйн техникийн зорилгоор ашиглах болж, объектив онолын эхлэлийг тавьсан байна.

Энэхүү объектив онол нь хамгийн анх 1807 оны Францын Арилжааны төрөлжсөн хуульд хэрэгжиж эхэлсэн боловч одоогийн Францын Арилжааны төрөлжсөн хууль нь холимог хувилбарыг баримталсан байна.

Учир нь арилжааны хэлцлийг тухайн хэлцлийг өөрийн үйл ажиллагаагаа болгосон этгээдийг тодорхойлохгүйгээр бүрэн дүүрэн тогтоох боломжгүй төдийгүй, одоогийн бизнесийн үйл ажиллагаанд ихэнх арилжааны хэлцлийг иргэн хооронд бус, харин аж ахуй эрхлэгч хооронд эсхүл аж ахуй эрхлэгч болон иргэд хооронд хийдэг болсон байна. Тиймээс энэхүү нөхцөл байдалд объектив онол бүрэн дүүрэн нийцэх боломжгүй хэмээн шүүмжлэгдэх болсон бөгөөд 1807 оны Францын Арилжааны төрөлжсөн хуулийн нөлөөн дор батлагдсан Германы 1861 оны Арилжааны төрөлжсөн хуулийн хувьд ч мөн адил объектив онолыг баримтлаагүй байдаг.

Объектив онолыг баримталсан тохиолдолд байнгын тогтвортой байдлаар ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа явуулдаггүй субъект (жирийн иргэний хувьд ч) ч мөн адил Арилжааны хуулийн үйлчлэлийн дагуу үйлдэл хийх шаардлагатай болох бөгөөд энэ нь иргэн болон аж ахуй эрхлэгчийн хоорондын ялгааг бүдгэрүүлэх төдийгүй, Иргэний хууль болон Арилжааны хуулийн харилцан хамаарлыг тодорхойлоход ихээхэн бэрхшээл учруулдаг байна.

Эцэст нь холимог тогтолцооны хандлага бөгөөд 1807 оны Францын Худалдааны хууль нь түүний төлөөлөл юм. Энэхүү тогтолцоо нь субьектийн зохицуулалт болон хэлцлийн зохицуулалтыг аль алиныг нь чухалчилж хуулиа батлах тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл энэхүү хандлагаар батлагдсан Худалдааны хуулийн бүтэц нь субьектийн онол, объектийн онолын аль нь давамгайл байх нь тодорхой бус байдаг. Энэ нь Францын Худалдааны хуулийг батлахдаа хууль тогтоогч Худалдаачны эрх зүйн уламжлалыг хадгалсан субьектийн онолын байр суурь болон Францын хувьсгалаар ангийн нийгмийг үгүйсгэсэн үзэл баримтлалыг дэмжсэн объектийн онолын байр суурийг алийг нь сонгох вэ гэсэн сонголттой нүүр тулж эцэстээ аль алийг нь Худалдааны хуулийн суурь болгосон явдал юм.

Япон улсын хувьд одоогийн Худалдааны хууль нь 1807 оны Францын Худалдааны хуультай адилаар холимог тогтолцоог авсан. Өөрөөр хэлбэл худалдаачны тодорхойлолт болон худалдааны хэлцлийг аль алийг нь Худалдааны хуулийн үндэс болгож худалдаа эрхлэгч болон худалдааны хэлцлийн аль алийг нь хангаж байж Худалдааны хуулийн зохицуулалт үйлчилнэ. Худалдаачны ойлголт нь худалдааны хэлцлээс урган гарсан (хувь хүн худалдаа эрхлэгч) болон түүнтэй хамааралгүй зохицуулалт (хуурамч худалдаа эрхлэгч)¹⁶ байдаг.

Энэ талаар Худалдааны хуулийн тодорхой зүйл, заалтыг судлан үзвэл Худалдааны хуулийн 4-р зүйлд худалдааны этгээдийн тодорхойлолтыг тусгасан байдаг

¹⁵ Teresa Rodriguez de las Heras Ballell, INTRODUCTION TO SPANISH PRIVATE LAW: FACING THE SOCIAL AND ECONOMIC CHALLENGES, ROUTLEDGE-CAVENDISH, 2009, p.3

¹⁶ 犠牲商人

бөгөөд түүний 1-р заалтад “Тус хууль дахь “худалдаа эрхлэгч” гэдэг нь өөрийн нэрээр, худалдааны хэлцэл хийх үйлдлийг өөрийн үйл ажиллагаагаа болгосон этгээдийг ойлгоно” гэж заасан байдаг (Энэ хэлбэрийн худалдаа эрхлэгчийг “Ерөнхий худалдаа эрхлэгч” гэж нэрлэдэг). Өөрөөр хэлбэл, худалдаа эрхлэгч гэх ойлголт нь худалдааны хэлцэл гэх ойлголтод тулгуурлан тодорхойлогдсон байгааг буюу худалдааны хэлцлийн зарчмыг баримталсан болохыг харж болно.

Тэгвэл дор өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний хуулийн хувьд иргэн хоорондын эрх зүйн харилцаа болон аж ахуй эрхлэгч хоорондын эрх зүйн харилцааг ямар шалгуураар зааглан ялгаж, өөр хоорондоо ялгамжтай зохицуулалтыг хийсэн бэ гэдэг талаар тодорхой жишээн дээр тулгуурлан авч үзье.

Монгол Улсын Иргэний хууль нь иргэн хоорондын болон аж ахуй эрхлэгч хоорондын аль аль эрх зүйн харилцааг зохицуулахуйц эрх зүйн хэм хэмжээг өөртөө агуулсан буюу монист загварыг хэрэглэсэн гэж дүгнэж болно. Тиймээс иргэн хоорондын болон аж ахуй эрхлэгч хоорондын эрх зүйн харилцааг зааглан ялгах тодорхой шалгуур шаардлагатай болох бөгөөд тухайн шалгуурын хувьд харьцуулсан эрх зүйн үүднээс авч үзэхэд объектив, субъектив, холимог гэсэн үндсэн гурван төрлийн шалгуур оршиж байгаа талаар дээр дурьдсан билээ. Монгол Улсын Иргэний хууль дахь зуучлалын гэрээ болон худалдааны зуучлагчийн талаарх эрх зүйн хэм хэмжээг харьцуулан судлах замаар дээрх гурван төрлийн шалгуурын алийг нь баримталж буй болох, эсхүл аль загвартай илүү ойролцоо зохицуулалтыг баримталж байгаа болох талаар тодорхой дүгнэлт хийхийг оролдъё.

Монгол Улсын Иргэний хуулийн 410 дугаар зүйлийн 410.1-д дараах байдлаар зохицуулсан байна.

410.1 “Зуучлалын гэрээгээр зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, зуучлуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс, шагнал төлөх үүргийг тус тус хүлээнэ.”

Харин энэхүү зуучлалын гэрээнээс “Худалдааны зуучлагч”-ийг ялгахын тулд Иргэний хуулийн 413 дугаар зүйлийн 413.1 дэх хэсэгт дараах байдлаар зохицуулсан байна.

413.1 “Аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд худалдах-худалдан авах, даатгал, тээвэр, эд хөрөнгө хөлслөх, эсхүл худалдааны бусад үйл ажиллагаанд зуучлал явуулж байгаа этгээд худалдааны зуучлагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

413.2 “Энэ хуулийн 413.1-д зааснаас бусад хэлцэл болон үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой хэлцлийг худалдааны зуучлагчийн тусламжтайгаар хэрэгжүүлсэн тохиолдолд худалдааны зуучлагч гэж үзэхгүй.”

Дээрх хоёр зохицуулалтыг харьцуулж үзвэл аль аль нь “хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх” үйл ажиллагаа боловч, тухайн зуучлалын үйл ажиллагааг буюу хэлцлийг “аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд” явуулж байгаа тохиолдолд тухайн субъект нь “Худалдааны зуучлагч”-д хамаарах бөгөөд 410-р зүйл бус харин 413 дугаар зүйлийг хэрэглэхээр зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, тухайн үйл ажиллагааг өөрийн үндсэн эрхлэх үйл ажиллагаагаа болгосон бөгөөд тухайн үйл ажиллагаа нь аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа байгаа тохиолдолд 413 дугаар зүйлийг хэрэглэхээр зохицуулсан байна.

Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбарт энэхүү аж ахуйн үйл ажиллагаа гэх ойлголтыг “эдийн засгийн хүрээнд бие даасан, үргэлжилсэн, гадагш хандсан, ашиг, орлогод чиглэсэн үйл ажиллагаа юм. Харин чөлөөт мэргэжлийн үйл ажиллагаа архитекторын ажил, урлагийн ажил, шинжлэх ухааны ажил зэрэг нь үйл ажиллагааны өөр төрөлд хамаарах эсэх болон улмаар аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах эсэхийг шүүх болон шинжлэх ухааны зүгээс тодруулах шаардлагатай” гэжээ¹⁷.

Тэгвэл дээрх “аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд” гэх нөхцлийг шүүхийн зүгээс хэрхэн тайлбарлаж буй талаар товч авч үзье.

Хэргийн товч агуулга:

“Т” ХХК нь “Н” ХХК-тай 2013 оны 10 дугаар сард ачаа тээврийн зуучлалын 13/18 тоот гэрээг нэг жилийн хугацаатай байгуулсан. Энэ гэрээний хүрээнд 2014 оны 7 дугаар сарын 3-наас 29-ний хооронд 11 чингэлэг ачаа тээвэрлүүлэн хүлээн авсан боловч гэрээнийхээ үүргийг биелүүлээгүй. Тиймээс гэрээний хөлсийг нэхэмжилсэн.

Хариуцагчийн зүгээс ачаа ирэх замдаа алдагдсан тул тухайн хохирлыг суутгаж авсан учраас төлбөрийг төлөх үндэслэлгүй гэж маргасан.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр: Иргэний хуулийн 413 дугаар зүйлийн 413.1, 232 дугаар зүйлийн 232.6-д заасныг баримтлан хариуцагч “Н” ХХК-иас төгрөг, хариуцагч “Г” ХХК-иас төгрөг тус тус гаргуулан нэхэмжлэгч “Т” ХХК-д олгож шийдвэрлэсэн.

Харин **Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар:** шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Иргэний хуулийн 380 дугаар зүйлийн 380.1, **410 дугаар зүйлийн 410.1**, 232 дугаар зүйлийн 232.8 дахь хэсэгт заасныг баримтлан гэж өөрчилж шийдвэрлэсэн байна.

Улсын Дээд шүүхийн хувьд: “Аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд худалдах-худалдан авах, даатгал, тээвэр, эд хөрөнгө хөлслөх, эсхүл худалдааны бусад үйл ажиллагаанд зуучлал явуулж байгаа этгээд худалдааны зуучлагчийн эрх эдэлж, үүрэг хүлээхээр Иргэний хуулийн 413 дугаар зүйлийн 413.1-д заасан ба **Зам, тээврийн яамнаас “Т” ХХК-д төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа явуулах гэрчилгээ олгожээ.** Анхан шатны шүүх зохигчдын хооронд худалдааны зуучлалын харилцаа үүссэн гэж үзсэн боловч хэрэгт авагдсан баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлж чадаагүй, уг алдааг давж заалдах шатны шүүх залруулж зөвтгөөгүй нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2-т нийцээгүй байна” гэж үзээд шийдвэр болон магадлалыг тус тус хүчингүй болгож анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн байна.

Дээрх шүүхийн шийдвэрүүдийг харьцуулан үзвэл анхан шатны шүүхийн хувьд шийдвэрийн үндэслэх хэсэгтээ “Гэрээний зүйл, шинж, талуудын эрх үүрэг, төлбөр төлөх нөхцөл зэргээс үзвэл талуудын хооронд Иргэний хуулийн 413 дугаар зүйлийн 413.1-д заасан тээвэр зуучлалын харилцаа үүссэн гэж үзэх үндэслэлтэй байна” гэснээс үзвэл зуучлалын гэрээ болон худалдааны зуучлагчийн харилцааг ялгахдаа тухайн гэрээний зүйл, шинж, талуудын эрх, үүрэг, төлбөр төлөх нөхцөл зэргийг харгалзан үзэх шаардлагатай гэж үзсэн бололтой.

¹⁷ Ё. Каят нар, “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар”УБ., 2010 он, хуу. 829-г үзнэ үү.

Харин давж заалдах шатны шүүхийн хувьд “Нэхэмжлэгч “Т” ХХК нь хариуцагч “Н” ХХК, “Г” ХХК-иудын барааг дотоодод тээвэрлэж ирэх, гадаадын тээврийн компанитай холбож өгөхөөр зуучилсан болох нь хэрэгт дээрх гэрээ зэрэг баримтууд болон талуудын тайлбараар тогтоогдож дотоод зардал гэж нэрлэгдсэн хэсгээр зуучлалын хөлс 2 671 400 төгрөг болох тогтоогдсон байх тул Иргэний хуулийн 410 дугаар зүйлийн 410.1 дэх хэсэгт заасны дагуу зуучлалын хөлс шаардах эрхтэй” гэж дүгнэсэн бөгөөд яагаад 410 дугаар зүйлийн дагуу шаардах эрхтэй талаар тодорхой үндэслэл дэвшүүлээгүй байна.

Улсын Дээд шүүхийн хувьд “Зам, тээврийн яамнаас “Т” ХХК-д төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа явуулах гэрчилгээ олгожээ.” гэсэн баримтыг үндэслэн 413 дугаар зүйлийн дагуу зохицуулагдах харилцаа байна гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Дээрх шүүхийн шийдвэрүүдийн үндэслэл тодорхой бус байгаа боловч анхан болон давж заалдах шатны шүүхийн зүгээс гэрээний үнийн дүн бага байгаа учраас худалдааны зуучлагч гэж тооцох эсхүл тооцохгүй талаар дүгнэлт хийсэн байж болохоор байгаа бөгөөд харин Улсын Дээд шүүхийн зүгээс тухайн үйл ажиллагааг аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд явуулах эрх олгогдсон эсэхийг гол шалгуур болгон дүгнэсэн байна.

Эндээс дүгнэвэл Монгол Улсын Иргэний хууль нь зуучлалын гэрээг л байгуулсан бол тухайн этгээдийг аж ахуй эрхлэгч гэж үзэхээр зохицуулаагүй байх тул объектив шалгуурыг баримтлаагүй болох нь тодорхой байна. Харин аж ахуйн буюу ашгийн төлөө зуучлалын үйл ажиллагааг байнгын тогтвортой, үргэлжилсэн байдлаар явуулж байгаа эсэхийг харгалзан үзэхээр зохицуулсан байх тул субъектив онолын шинжийг илүүтэйгээр баримталсан байна. Гэхдээ холимог онолын тодорхой шинжийг агуулсан эсэхийг шууд дүгнэх бололцоогүй болно.

Монгол Улсын одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд иргэд хоорондын хэлцлийн харилцаа болон аж ахуй эрхлэгч хоорондын хэлцлийн харилцааг ялгамжтайгаар зохицуулахгүй байгааг өмнөх хэсгүүдээс харж болно. Харин үүнийг эх газрын эрх зүйн систем бүхий Герман, Япон, Франц зэрэг улсуудын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл ялгамжтай байдлаар буюу Иргэний хууль, Худалдааны хууль гэсэн бие даасан хуулиудаар зохицуулж байна. Иймд дээр дурдсан 7 төрлийн хувилбаруудыг харьцуулан үзвэл иргэд хоорондын харилцааг аж ахуй эрхлэгчийн харилцаанаас ялган зохицуулахын тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл бие даасан Арилжааны хууль /Худалдааны хууль/-ийн төсөл боловсруулах уу гэдэг асуудал үүснэ.

Энэхүү судалгааны үр дүнгээс үзвэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хууль нь 2002 онд батлагдснаас хойш даруй 17 жил хэрэгжиж байгаа ч хувийн эрх зүйн харилцааг боломжит хэмжээнд зохицуулсаар байна. Түүнчлэн Иргэний хууль нь нийгэм дэх иргэн, хуулийн этгээд хоорондын үүсэх гэрээний болон гэрээний бус үүргийн харилцаа, өмчийн харилцааг цогцоор нь зохицуулдаг суурь хууль байх тул тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар аж ахуй эрхлэгчийн ялгамжтай зохицуулалтыг бий болгохоос илүүтэй аж ахуй эрхлэгчийн харилцааны онцлогийг агуулсан бие даасан хуулийн төсөл байх нь илүү оновчтой арга зам юм.

Өөрөөр хэлбэл Иргэний хууль нь иргэн, хуулийн этгээдийн хоорондын нийгмийн суурь харилцааг зохицуулах ерөнхий хууль байх бол Арилжаа /Худалдаа/-ны хуулийн төсөл нь зөвхөн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй субъектүүдэд хамаарах тусгай

хуулийн шинжтэй байх нь зохимжтой. Аж ахуй эрхлэгчдийн харилцааны онцлогийг тусгахдаа Иргэний хууль дахь зарчмаас ялгагдах шинжийг анхааран үзэх бөгөөд ялгамжтай зохицуулалт нь Арилжааны хуулиар, нийтлэг шинжтэй зохицуулалт нь Иргэний хуулиар зохицуулагдах учиртай.

Үүний үр дүнд Иргэний хуулийн одоогийн зохицуулалт, схем, бүтцэд өөрчлөлт оруулахгүйгээр бизнесийг илүү түргэн, шуурхай, баталгаатай байдлаар зохицуулж болох Арилжааны эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. Мөн бизнес буюу арилжааны эрх зүйн салбар нь эдийн засгийн хөгжлийг даган байнга хувьсан өөрчлөгддөг, динамик хөдөлгөөн ихтэй байдаг тул бие даасан хууль байх нь эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд нийцүүлэн Арилжааны хууль өөрчлөгдөж болох ба үүнийг даган хувийн эрх зүйн суурь хууль болох Иргэний хуульд тэр бүр өөрчлөлт оруулахгүйгээр асуудлыг шийдвэрлэх эерэг талтай.

Харин бие даасан хуулийн төсөл байх тохиолдолд дээр дурдсан Субъектив онол, Объектив онол, Холимог онол гэсэн зохицуулалтын гурван хувилбараас давуу болон сул талыг нь судлан үзэж аль тохиромжтой хувилбарыг сонгох шаардлагатай. Энэхүү зохицуулалтын хувилбарыг 5 дугаар бүлэгт харьцуулан үзэх болно.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 1-ын 1, 2, 3, 4 дүгээр хүснэгтээс үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин аж ахуй эрлэгч хоорондын гэрээ, хэлцэл түргэн, шуурхай явагдах, найдвартай, баталгаатай байх боломжийг хангана.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх бөгөөд аж ахуй эрхлэгчдийн хэлцлээс үүсэх маргаан багасах, хэлцлийн үүрэг түргэн шуурай биелэгдснээр хэлцлийн мөнгөн болон мөнгөн бус зардал багасч ашиг нэмэгдэх боломжтой. Бизнесийн ашиг нэмэгдэхийг дагалдан бараа бүтээгдэхүүний үнэ хямдарч, эдийн засагт эерэг нөлөөг үзүүлнэ.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Эдийн засгийн эерэг нөлөөллийг дагалдан нийгэмд мөн адил эерэг нөлөөг үзүүлнэ.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Судалгааны 3-р хэсэгт субъектив, объектив, холимог онолыг харьцуулан судалсны үндсэн дээр дээрх гурван хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

5.1 Гарч болох эерэг болон сөрөг үр дагавар

Хувилбар 1 буюу субъектив онолын Субъектив онол нь арилжааны хуулийг бүтээх сүүлийн үеийн дэлхийн чиг хандлага гэж хэлж болно. Субъектив онолын давуу тал нь ямар хэлцлийг худалдааны хэлцэл гэж тодорхойлох вэ гэсэн хүнд асуудалтай тулгарахгүй юм. Объектив онол нь тодорхой хэлцлийг худалдааны хэлцэл гэж үздэг бөгөөд худалдааны хэлцэлийг дотор нь объектив худалдааны хэлцэл, аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл гэж хуваадаг. Иймд ямар хэлцэл хийж байгаагаас үл хамааран аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулж байгаа бол аж ахуй эрхлэгч гэж үзэх субъектив онол нь арилжааны хуулийг хэрэглэхэд ямар ойлгомжтой болгодог бөгөөд орчин үеийн эдийн засгийн харилцаанд илүү зохимжтой хувилбар юм.

Хувилбар 2 буюу объектив онолын хувьд Арилжааны хуулиар зохицуулах эрх зүйн харилцаа нь арилжааны хэлцлээр тодорхойлогдох болдог байна. Өөрөөр хэлбэл, арилжааны хэлцэл хийсэн л бол тухайн субъект иргэн байна уу, эсхүл аж ахуй эрхлэгч, худалдаачин байна уу гэдгийг харгалзан үзэхгүй гэсэн үг. Энэхүү объектив онол нь хамгийн анх 1807 оны Францын Арилжааны төрөлжсөн хуульд хэрэгжиж эхэлсэн боловч одоогийн Францын Арилжааны төрөлжсөн хууль нь холимог хувилбарыг баримталсан байна.

Учир нь арилжааны хэлцлийг тухайн хэлцлийг өөрийн үйл ажиллагаагаа болгосон этгээдийг тодорхойлохгүйгээр бүрэн дүүрэн тогтоох боломжгүй төдийгүй, одоогийн бизнесийн үйл ажиллагаанд ихэнх арилжааны хэлцлийг иргэн хооронд бус, харин аж ахуй эрхлэгч хооронд эсхүл аж ахуй эрхлэгч болон иргэд хооронд хийдэг болсон байна. Тиймээс энэхүү нөхцөл байдалд объектив онол бүрэн дүүрэн нийцэх боломжгүй хэмээн шүүмжлэгдэх болсон бөгөөд 1807 оны Францын Арилжааны төрөлжсөн хуулийн нөлөөн дор батлагдсан Германы 1861 оны Арилжааны төрөлжсөн хуулийн хувьд ч мөн адил объектив онолыг баримтлаагүй байдаг.

Объектив онолыг баримталсан тохиолдолд байнгын тогтвортой байдлаар ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа явуулдаггүй субъект (жирийн иргэний хувьд ч) ч мөн адил Арилжааны хуулийн үйлчлэлийн дагуу үйлдэл хийх шаардлагатай болох бөгөөд энэ нь иргэн болон аж ахуй эрхлэгчийн хоорондын ялгааг бүдгэрүүлэх төдийгүй, Иргэний хууль болон Арилжааны хуулийн харилцан хамаарлыг тодорхойлоход ихээхэн бэрхшээл учруулдаг байна.

Хувилбар 3 буюу Холимог онолын хувьд энэхүү тогтолцоо нь субъектийн зохицуулалт болон хэлцлийн зохицуулалтыг аль алиныг нь чухалчилж хуулиа батлах тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл энэхүү хандлагаар батлагдсан Худалдааны хуулийн бүтэц нь субъектийн онол, объектийн онолын аль нь давамгайл байх нь тодорхой бус байдаг. Энэ нь Францын Худалдааны хуулийг батлахдаа хууль тогтоогч Худалдаачны эрх зүйн уламжлалыг хадгалсан субъектийн онолын байр суурь болон Францын хувьсгалаар ангийн нийгмийг үгүйсгэсэн үзэл баримтлалыг дэмжсэн объектийн онолын байр суурийг алийг нь сонгох вэ гэсэн сонголттой нүүр тулж эцэстээ аль алийг нь Худалдааны хуулийн суурь болгосон явдал юм.

Япон улсын хувьд одоогийн Худалдааны хууль нь 1807 оны Францын Худалдааны хуультай адилаар холимог тогтолцоог авсан. Өөрөөр хэлбэл худалдаачны тодорхойлолт болон худалдааны хэлцлийг аль алийг нь Худалдааны хуулийн үндэс болгож худалдаа эрхлэгч болон худалдааны хэлцлийн аль алийг нь хангаж байж Худалдааны хуулийн зохицуулалт үйлчилнэ. Худалдаачны ойлголт нь худалдааны хэлцлээс урган гарсан (хувь хүн худалдаа эрхлэгч) болон түүнтэй хамааралгүй зохицуулалт (хуурамч худалдаа эрхлэгч)¹⁸ байдаг.

Тус онолын давуу тал нь тодорхой этгээд буюу субъектийг шууд худалдаачин гэж зохицуулахаас гадна тодорхой төрлийн гэрээг нэрлэн зааж, тухайн гэрээг хийж буй ямар ч субъект худалдаачинд тооцогдох замаар Худалдааны хуулийн үйлчлэлд хамаардаг. Өөрөөр хэлбэл субъектив онол болон объектив онолын аль алины сул талыг нөхөх замаар өргөн хүрээтэй худалдааны эрх зүйн зохицуулалтыг бий болгодог.

Гэхдээ тус онолыг эрх зүйн хэм хэмжээ болгон хэрэглэхэд ямар тохиолдолд худалдаачин гэж үзэх, хуульд заасан гэрээг хийсэн л бол ашгийн төлөө бус шинжтэй байхаас үл хамааран худалдаачин гэж үзэх замаар зохицуулдаг нь хууль хэрэглээний явцад нэн төвөгтэй байдлыг үүсгэдэг. Хэдийгээр тус онолын дагуу Япон улс холимог тогтолцоотой гэгддэг ч судлаачдын дунд субъектив онолд шилжих ёстой гэсэн хүчтэй шүүмж өрнөж байгааг дурдах нь зүйтэй.

Иймд дээрх гурван хувилбараас орчин үеийн чиг хандлага болон гадаад орнуудын зохицуулалтыг харьцуулан үзэхэд субъектив онол илүү ойлгомжтой бөгөөд эрх зүйн тодорхой байдлыг хангадаг байна. Түүнчлэн манай улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хууль ч гэсэн Германы Иргэний кодексийн концепцийг агуулдаг тул судалгааны багийн зүгээс Хувилбар 1 буюу субъектив онол илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Зардал, үр өгөөжийн харьцааны тухайд дээрх 3 хувилбарт төдийлөн ялгаа гарахгүй болно.

¹⁸ 犠牲商人

ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

1. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

I. АЖ ҮЙЛДВЭРИЙН ӨМЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ПАРИСЫН КОНВЕНЦ

Тус конвенцид “Арилжааны нэр”-ийн талаар тодорхой зохицуулалтуудыг тусгасан байдаг. Үүний заримыг дурдвал:

8 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн нэр

Холбооны гишүүн бүх оронд аж ахуйн нэгжийн нэрийг барааны тэмдгийн бүрдэлд орсон эсэхээс үл хамааран түүнийг мэдүүлэг гаргахыг шаардахгүйгээр эсхүл бүртгэлгүйгээр хамгаална.

9 дүгээр зүйл. Тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр: Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашигласан барааг импортлоход хураах

(1) Холбооны гишүүн оронд хууль ёсны хамгаалалтын эрхтэй тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар хэрэглэж байгаа бүтээгдэхүүнийг гаднаас импортлоход хураана.

(2) Хууль бус тэмдэг хэрэглэж байгаа оронд эсхүл тийм барааг импортолж буй оронд ч барааг мөн хураана.

(3) Прокурор болон бусад эрх бүхий байгууллага, сонирхогч этгээд, хувь хүн, хуулийн этгээдийн шаардлагаар орон бүрийн дотоодын хуулийн дагуу барааг хураана.

(4) Эрх бүхий байгууллагууд бараа дамжин өнгөрөх тохиолдолд хураах үүрэг хүлээхгүй.

(5) Хэрэв тухайн орны хуулиар барааг импортлох үед хураах тухай заагаагүй бол импортлохыг хориглох буюу импортолсны дараа хураах үйлдлээр барааг хураах үйлдлийг сольж болно.

(6) Хэрэв тухайн орны хуулиар барааг импортлоход хураах, импортлохыг хориглох, импортолсны дараа нь хураах тухай заагаагүй бол тухайн хуульд тохирох өөрчлөлт оруулах хүртэл эдгээр арга хэмжээг тухайн орон өөрийн харьяатад ийм тохиолдолд авах арга хэмжээтэй адил нөхцөлөөр хуулийн үйлдэл, хэрэгслээр оруулна.

II. БАРАА ХУДАЛДАХ-ХУДАЛДАН АВАХ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ

35 дугаар зүйл

(1) Худалдагч гэрээний шаардлагад нийцсэн тоо, чанар, тодорхойлолт бүхий, мөн гэрээгээр шаардсаны дагуу савлаж, багласан барааг нийлүүлэх ёстой.

(2) Талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд, дараахь шаардлагыг хангаагүй барааг гэрээнд нийцээгүй гэж үзнэ:

(a) уг бараатай ижил тодорхойлолт бүхий барааг ердийн байдлаар ашиглах зориулалтад тохирч байх;

(b) худалдан авагч худалдагчийн ур чадвар болон үнэлгээнд найдаагүй буюу найдах нь ухаалаг бус байх байсныг нөхцөл байдал харуулахаас бусад тохиолдолд гэрээ байгуулах үед худалдагчид шууд болон шууд бус байдлаар ойлгуулсан аливаа тодорхой зориулалтад тохирч байх;

(с) худалдагчаас худалдан авагчид үлгэр буюу загвар болгон үзүүлсэн барааны чанарыг агуулсан байх;

(d) тухайн төрлийн бараанд нийтлэг хэрэглэдэг аргаар, хэрэв ийм арга байхгүй бол тухайн барааг хадгалж, хамгаалахад зохистой аргаар савлаж, багласан байх.

(3) Гэрээ байгуулах үед худалдан авагч тухайн бараа гэрээнд нийцээгүйг мэдэж байсан буюу мэдэхгүй байх ёсгүй байсан бол тийнхүү нийцээгүйн хариуцлагыг худалдагч дээрх хэсгийн (a)-(d) дэд хэсэгт заасан үндэслэлээр хүлээхгүй.

36 дугаар зүйл

(1) Барааны эрсдэл худалдан авагчид шилжих үед бараа гэрээнд нийцэхгүй байсан бол тийнхүү нийцээгүй нь тэр үеэс хойш илэрсэн ч худалдагч гэрээ болон энэхүү конвенцийн дагуу хариуцлага хүлээнэ.

(2) Худалдагч мөн дээрх (1) дэх хэсэгт заасан хугацаанаас хойш үүссэн бөгөөд худалдагч аль нэг үүргээ зөрчсөнөөс үүдсэн, түүний дотор тухайн бараа нь тодорхой хугацаанд ердийн болон зарим тодорхой зориулалтад тохирсон хэвээр байх эсхүл тусгайлан тогтоосон чанар буюу шинжээ алдахгүй байх аливаа баталгааг зөрчсөнөөс бараа гэрээнд нийцэхгүйн хариуцлагыг хүлээнэ.

2. БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2.1 ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ХУДАЛДАА (АРИЛЖАА)-НЫ ЭРХ ЗҮЙ

ХБНГУ-ын худалдааны эрх зүй нь худалдаа эрхлэгчдэд үйлчлэх хувийн эрх зүйн тусгай салбар эрх зүй юм. Худалдааны эрх зүй нь тэргүүн ээлжинд худалдаа эрхлэгчдийн хийх худалдааны хэлцлийн талаар зохицуулах ба үүний зэрэгцээ нийтийн эрх зүйн зарим зохицуулалтыг өөртөө агуулсан байдаг. Тухайлбал худалдааны бүртгэл (Худалдааны тухай хуулийн 8 ба түүний дараагийн зүйлүүд), фирм (Худалдааны тухай хуулийн 17 ба түүний дараагийн зүйлүүд) болон санхүүгийн бүртгэлийн (Худалдааны тухай хуулийн 238 ба түүний дараагийн зүйлүүд) тухай зохицуулалтыг дурдаж болох юм.

Худалдааны эрх зүйн зохицуулалтыг Иргэний хуулийн зэрэгцээ бие даасан Худалдааны тухай хуулиар бий болгосон. Худалдааны тухай хуулийн зохицуулалт нь Иргэний хуулийн зохицуулалтын (lex generalis) хувьд lex specialis буюу тусгайлсан зохицуулалт тул Иргэний хуулиас тэргүүн ээлжинд үйлчилнэ. Үйлчлэлийн эрэмбээс хамааран Иргэний хууль нь дийлэнхдээ нөхөх журмаар хэрэглэгддэг. Учир нь Худалдааны тухай хууль нь худалдаа эрхлэгчдэд зориулсан тусгайлсан зохицуулалтыг агуулдаг тул Иргэний хууль нь зөвхөн нийтлэг зохицуулалтын хувьд хэрэглэгдэх боломжтой. Итгэмжлэлийн талаар жишээлэн дурдвал энэ талаарх нийтлэг зохицуулалт төлөөллийн хүрээнд Иргэний хуулийн 164 ба түүний дараагийн зүйлүүдэд агуулагддаг бол үүнээс тэргүүн ээлжинд худалдааны төлөөлөх бүрэн эрх (прокура) эсвэл худалдааны итгэмжлэлийн¹⁹ талаарх тусгайлсан зохицуулалт үйлчлэх юм. Худалдааны тухай хуулиас гадна худалдаа эрхлэгчдэд холбогдох тусгайлсан зохицуулалт бусад хуульд тухайлбал Гэрээний стандарт нөхцлийн тухай хууль (AGBG 24-р зүйл), иргэний процессийн эрх зүйд (ZPO 38 Abs 1), Шүүхийн тухай хуульд (GVG 93 ба түүний дараагийн зүйлүүд) тусгагдсан байдаг.

¹⁹ Handlungsvollmacht

Худалдааны хуулийн эхний бүлгээр худалдаа эрхлэгчид тавигдах шаардлага (1-7-р зүйл), худалдааны бүртгэл (8-р зүйл), худалдааны фирм (17-24-р зүйл, 29-37а-р зүйл), аж ахуй эрхлэгч байгууллагын²⁰ эрх залгамжлагч (25-28-р зүйл), худалдаа эрхлэгчийн төлөөлөл (48-58-р зүйл)-ийн талаар зохицуулсан.

Хоёрдугаар бүлгээр (105-237-р зүйл) худалдаа эрхлэгч эрх зүйн этгээдүүдийн нэгдэл буюу худалдаа эрхлэгч хувийн эрх зүйн байгууллагын талаар зохицуулсан тул энэ бүлгийг худалдааны эрх зүйн бус харин хувийн эрх зүйн байгууллагын²¹ эрх зүйн нэг хэсэг гэж тодорхойлох нь зөв юм.

Гуравдугаар бүлгээр (238-342е-р зүйл) худалдааны санхүүгийн бүртгэл, санхүүгийн тайлан (санхүүгийн бүртгэл хөтлөх, худалдаа эрхлэгч санхүүгийн бүртгэл хөтлөх үүрэг)-ийн талаар зохицуулсан.

Дөрөвдүгээр бүлэг нь (343-475h-р зүйл) худалдааны хэлцлийн талаарх зохицуулалт буюу худалдаа эрхлэгчдэд зориулсан хувийн эрх зүйн сонгодог тусгайлсан эрх зүйг өөртөө агуулсан.

Тавдугаар бүлэг (476-619-р зүйл)-т тусгайлан далайн худалдааны талаар зохицуулсан.

ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН КОДИФИКАЦИЙН ТҮҮХ

ХБНГУ нь 1871 онд Герман Гүрэн байгуулагдахаас өмнө 38 бие даасан төрт улсад хуваагдаж, тэдгээр нь хамтдаа хууль тогтоох эрх хэмжээгүй Герман улсуудын Холбоо гэгчид хамаарч байжээ.

Тухайн үеийн Мюнхен хотоос Хамбург хот хүртэл бараа тээвэрлэхдээ багаар бодоход 4 улсын хил дамжиж нутаг дэвсгэрээр нь дайран өнгөрч байсан байна. Хэрэв улс бүхэн тус тусдаа гаалийн татвар хураах юм бол тээвэрлэлтийн өртөг өндөр болж улмаар худалдаа эрхлэгчдэд ямар ч ашиг гарахааргүй байх байжээ. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд 1836 онд герман улсууд “Германы гаалийн холбоо” гэх анхны хил гаалийн нэгдсэн холбоог байгуулсан байна.

Худалдааг хязгаарлаж байсан бас нэгэн саад тотгор бол тусгаар улс бүхэнд өөр өөр худалдааны эрх зүй үйлчилж байсан явдал юм. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд улсууд хамтын комисс томилж, нэгдсэн хууль боловсруулахыг энэхүү комисст даалгасан байна. Ийнхүү боловсруулсан хуулийн төслийг бараг бүх улсууд хүлээн авч үндэсний хууль тогтоомжоо баталжээ. Үүнийг өнөөгийн Европын Холбооны зөвлөмж боловсруулахтай адил төстэй гэж ойлгож болох бөгөөд мөн ялгаагүй дотоодын хууль тогтоомж болгох ажиллагаа хийгдэж байжээ. Зарчмын хувьд тухайн үеийн Германы тусгаар улсууд уг хуулийг хэрэгжүүлэх, батлах үүрэг хүлээгээгүй байсан ч дээр дурдсаны дагуу бараг бүх улс өөрийн болгосон нь тухайн үед нэгдсэн худалдааны эрх зүй ямар чухал байсны илрэл юм. Худалдааны эрх зүйн кодификаци нь энэ утгаараа Герман гүрний хэмжээнд хэрэгжсэн цорын ганц хуулийн төсөл болсон. Ийнхүү 1861 онд ADHGB буюу “Нийтлэг Германы Худалдааны эрх зүйн кодификац” хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлжээ.

²⁰ Unternehmen гэсэн нэр томъёог ийнхүү орчуулав.

²¹ Personenhandels-gesellschaft гэсэн нэр томъёог ийнхүү орчуулав.

1897 оны 5-р сарын 10-ны өдөр Худалдааны тухай хууль батлагдах хүртэл “Нийтлэг Германы Худалдааны эрх зүйн кодификац” үйлчилж байжээ. Тухайн үед нэгдсэн иргэний эрх зүйн кодификац байгаагүй бөгөөд тухайн үеийн үзэл баримтлалаар худалдаа нь үүнээс илүү ач холбогдолтой байжээ. Энэ нь эдийн засгийн шалтгаантай байсан ба үйлдвэржилтийн хүрээнд улс хоорондын зам харилцааг сайжруулах, ялангуяа төмөр зам бий болгох үндэс болсон. 1874 оноос зөвлөлдөн улмаар 1900 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Иргэний хуультай Худалдааны тухай хууль нь нэгэн зэрэг үйлчилж эхэлсэн байна.

ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ

Худалдааны эрх зүйг Худалдааны тухай хуультай адилтган ойлгож болохгүй. Худалдааны эрх зүйг зөвхөн Худалдааны тухай хуулиар зохицуулдаггүй, нөгөө талаас Худалдааны тухай хууль нь дан ганц худалдааны эрх зүйн зохицуулалтыг агуулдаггүй юм.

Худалдааны эрх зүйн эх сурвалжийг явцуу утгаар нь тодорхойлвол үүнд худалдаа эрхлэгчдэд зориулсан хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн хэм хэмжээ болон худалдааны заншил хамаарна.

- Хуульчилсан зохицуулалтад худалдаа эрхлэгчийн мөн чанарыг шууд ба шууд бусаар (тухайлбал Худалдааны тухай хуулийн 350-р зүйлийг 343.1 дэх хэсэгтэй хамтатган хэрэглэх) хэм хэмжээний бүрэлдэхүүн болгон заасан бүхий л зохицуулалт хамаарна.

Үүний зэрэгцээ худалдааны эрх зүйн хэм хэмжээ нь явцуу утгаараа худалдааны эрх зүйн дагавар хуулиудад агуулагддаг. Энэ хуулиудаар худалдааны эрх зүйн тодорхой материудыг тусгайлан зохицуулсан байдаг. Үүнд тухайлбал Агаарын хөдөлгөөны тухай хуулийг нэрлэж болох юм. Мөн Иргэний процессийн хуулийн тухайлсан зохицуулалтууд нь тусгайлан худалдаа эрхлэгчдэд хэрэглэгддэг (Иргэний процессийн хуулийн 29-р зүйлийн 2 дахь хэсэг, 38-р зүйлийн 1 дэх хэсэг).

Журам үүнд тухайлбал Төмөр замын хөдөлгөөний тухай журмыг нэрлэж болох юм.

Олон улсын хэлэлцээр тухайлбал үүнд 1980 оны Олон улсын төмөр замын хөдөлгөөний тухай хэлэлцээр (COTIF) хамаарна.

Худалдааны нийтээр дагаж мөрдөх зан суртахууны эрх зүй худалдааны эрхлэгчдийн харилцаанд удаан хугацаанд байнга хэрэглэгдэх замаар бий болдог. Худалдааны эрх зүйн олон заншил нь эрх зүйн хэм хэмжээний нэгэн адил үйлчилдэг ба ингэснээр нийтээр дагаж мөрдөх зан суртахууны хэм хэмжээнд тооцогдоно. Худалдааны эрх зүйн нийтээр дагаж мөрдөх зан суртахууны хэм хэмжээ нь заавал дагаж биелүүлэх эсвэл диспозитив шинжтэй байж болно. Тухайлбал нийтээр дагаж мөрдөх зан суртахууны хэм хэмжээнд дүр исгэсэн худалдаа эрхлэгчийн тухай онол, санхүүгийн бүртгэлийг зохих ёсоор хөтлөх талаарх зарим зарчмууд болон худалдаа эрхлэгчийн баталгаа гаргах албан бичгийн талаарх зохицуулалтууд хамаарна.

Худалдааны заншил нь худалдаа эрхлэгчийн харилцаанд удаан хугацааны туршид хэвшиж тогтсон заншил юм. Худалдааны нийтээр дагаж мөрдөх зан суртахууны эрх зүйтэй харьцуулахад эрх зүйн хэм хэмжээний нэгэн адил хүлээн зөвшөөрөгддөггүй. Гэсэн хэдий ч Худалдааны тухай хуулийн 346-р зүйлд заасны дагуу “худалдааны

харилцаанд үйлчилдэг нийтээр дагаж мөрдөх зан суртахуун болон заншлыг харгалзах” талаар заасан байдаг. Худалдааны заншил нь зөвхөн тайлбар хийхэд туслах чиг үүрэггүй (Иргэний хуулийн 157, 242-р зүйл) зарим тохиолдолд диспозитив хэм хэмжээний хувьд хэрэглэгддэг. Тухайн харилцаанд оролцогч аль нэг тал нь энэ талаар мэдээгүй бол худалдааны заншлыг зарчмын хувьд анхаарах ёстой. Тухайлбал Худалдааны тухай хуулийн 359-р зүйлийн 1 дэх хэсэг, 380-р зүйл болон 393-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан санхүүгийн бүртгэл зохих ёсоор хөтлөх зарим нэг зарчмууд болон худалдааны заншлын хүрээнд тогтсон товчилсон гэрээний нөхцөл нь (тухайлбал “Kasse gegen Dokumente”) худалдан авагч урьдчилгаа төлбөрийг бэлэн мөнгөөр төлөх үүргийн талаарх тохиролцоог илэрхийлдэг.

Гэрээний стандарт нөхцлийн тухай хуулийн 1-р зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэрээний стандарт нөхцөл гэдэгт олон тооны гэрээнд зориулж гэрээний нэг талаас урьдчилан тогтоосон нөхцлийг ойлгодог. Гэрээний стандарт нөхцөл нь худалдааны харилцаанд өргөн хэрэглэгддэг. Гэрээний стандарт нөхцөл нь зөвхөн гэрээнд тусгагдсан тохиолдолд үйлчилнэ. Гэрээний нэг тал нь тухайн харилцаанд аж ахуйн эсвэл бие даасан мэргэжлийн үйл ажиллагаа хэрэгжүүлж худалдаа эрхлэгчийн хувьд оролцож буй тохиолдолд талууд дуугүй байх хэлбэрээр хүсэл зоригийн иелрхийлэл харилцан зөвшилцсөнд тооцогдох боломжтой (Гэрээний стандарт нөхцлийн тухай хуулийн 24-р зүйлийн 1 дэх өгүүлбэр). Ийм хэлбэрээр гэрээний стандарт нөхцөл түгээмэл хэрэглэгддэг болохыг Германы тээвэрлэгчдийн стандарт нөхцөл (ADSp)-өөс харж болно.

Худалдааны эрх зүйн эх сурвалжийг өргөн утгаар нь тодорхойлвол:

Дан ганц худалдаа эрхлэгчдэд үйлчилдэг бус харин худалдааны эрх зүйд хамаарах бүхий л эрх зүйн хэмжээ болон худалдааны заншлыг ойлгоно. Энэхүү эрх зүйн эх сурвалжид хуулиудаас юуны түрүүнд Иргэний хууль болон худалдааны үйл ажиллагааг зохицуулсан зарим тусгайлсан хуулиуд (тухайлбал Векселийн тухай хууль, Чекийн тухай хууль), мөн эдийн засгийн эрх зүйд хамаарах зарим нэг хуулиуд (тухайлбал Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль, Өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг хууль) хамаарна.

ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ОНЦЛОГ

Худалдааны эрх зүй нь худалдаа эрхлэгчдэд зориулсан эрх зүй ба худалдаа эрхлэгч гэдгийг илүү хэмжээний мэргэшсэн этгээд гэж ойлгож болохын зэрэгцээ ийнхүү ойлгох ёстой гэж хэлэх нь зүйтэй. Энэ нь худалдаа эрхлэгч этгээдийг бусад хувь хүнтэй харьцуулахад түүнийг хамгаалах шаардлага бага буюу худалдаа эрхлэгчийн бие даан хариуцлага хүлээх асуудлыг түүнийг хамгаалах хамгаалалтаас түрүүнд тавихад хүргэдэг.

Худалдааны эрх зүйн онцлогийг дараахь байдлаар тухайлан тодорхойлж болох юм. Үүнд:

1. Худалдаа эрхлэгч бие даан хариуцлага хүлээх чадвар

Худалдаа эрхлэгчдийн чөлөөт өрсөлдөөний урьдчилсан нөхцөл нь тухайн худалдаа эрхлэгч нь үйлдэл хэрэгжүүлэгч аж ахуй эрхлэгчийн хувьд өөрийн ажиллагааг чөлөөтэй, хараат бусаар хэрэгжүүлсэн байх явдал юм. Иймээс эрх зүйн болон гэрээний харилцааны эрх чөлөө нь худалдааны эрх зүйд тэргүүн ээлжинд хэрэгжих зарчим юм. Худалдаа эрхлэгч нь өөрийн үйлдлийн төлөө бие даан хариуцлага хүлээх талаарх заавал дагаж биелүүлэх хэм хэмжээ Худалдааны тухай хуульд байдаг тул худалдаа

эрхлэгчид эрсдлээс гадна мөн үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх боломж зэрэгцээ олгогдсон байх ёстой гэж үздэг.

Тухайлбал Худалдааны тухай хуулийн 350-р зүйлд заасны дагуу батлан даалтад хэлбэрийн шаардлага тавигддаггүй бол Худалдааны тухай хуулийн 348-р зүйлд заасны дагуу худалдаа эрхлэгч худалдааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа амласан хариуцлагыг Иргэний хуулийн 343-р зүйлд заасныг үндэслэн багасгах боломжгүй байна.

2. Хялбар, түргэн шуурхай байх

Худалдааны эрх зүйг хялбар болоод түргэн шуурхай байх шинж тодорхойлдог. Иймээс аль болох хэлбэрийн шаардлагаас татгалздаг. Тухайлбал батлан даалт (Худалдааны тухай хуулийн 350-р зүйл), худалдаа эрхлэгчийн баталгааны албан бичигт (Худалдааны тухай хуулийн 377-р зүйл) хэлбэрийн шаардлага тавигддаггүй.

3. Нийтэд нээлттэй байх, итгэлцлийг хамгаалах

Худалдаа эрхлэгчдэд гэрээний нөгөө тал болох этгээдийн талаарх худалдааны бүртгэлээр олж авах мэдээлэл нь найдвартай байх нь чухал. Мөн үүний нэгэн адил худалдаа эрхлэгчдэд бүртгэлийн агуулгад итгэх явдал чухал юм. Тухайлбал худалдаа эрхлэгч нь гэрээний нөгөө тал болох этгээд нь ХХК-ийн нэгэн адил хариуцлагаа хязгаарласан эсэхийг мэдэх явдал чухал байх юм.

4. Практикт ойр байх, олон улсын шинжтэй байх

Худалдааны эрх зүй нь худалдаа эрхлэгчийн практикт суурилж хөгждөг. Иймээс худалдааны эрх зүйд худалдааны зан заншил болон нийтээр дагаж мөрдөх зан суртахууны хэм хэмжээ болон арбитра хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа онцгой үүрэгтэй байдаг.

Эдийн засгийн хамтын ажиллагааны улам бүр олон улсын шинжтэй болж байгаа нь нэг талаас улс оронуудын эрх зүйн нэгдмэл байдлыг бий болгох шаардлагыг нэмэгдүүлсэн. Нөгөө талаас худалдаа эрхлэгчид болоод тэдгээрийн зөвлөхөд олон улсын худалдааны эрх зүйн мэдлэг улам бүр чухал болсон. Учир нь олон улсын гэрээний эрх зүйн харилцаанд гадаад улсын шүүхийн харьяаллыг мөн гадаадын улсын эрх зүйн сонгон тохиролцох боломжтой юм.

2.2 ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХУДАЛДАА (АРИЛЖАА)-НЫ ЭРХ ЗҮЙ²²

ОХУ-ЫН ХУДАЛДААНЫ ШҮҮХИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ШҮҮХИЙН ХАРЬЯАЛАЛ

ОХУ-ын иргэний эрх зүй, худалдааны эрх зүйн үүсэл хөгжил, түүхэн тоймыг авч үзэхийн тулд тухайн улсын хувийн эрх зүйн эх сурвалж, шүүх засаглалын хөгжил, тогтолцооны онцлогийг эн тэргүүнд судлах нь зүйтэй.

1864 онд Орос улсад өрнөсөн шүүхийн шинэтгэлийн үр дүнд ОХУ-ын орчин үеийн шүүхийн тогтолцоо бий болсон гэж зарим судлаачид үздэг. Орос улсад 1864 онд гурван томоохон эрх зүйн акт батлагдсан нь Шүүхийн тухай хууль болон Эрүү, Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиуд юм. Судлаачдын үзэж байгаагаар энэхүү шинэтгэлийн үр дүнд туйлын тодорхой болсон зүйл нь Орос улс энэ үеэс эхлэн хуучин

²²“Харьцуулсан Худалдааны эрх зүй” номын хэсэг болох Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Баярмаа нарын бичсэн хэсгээс ишлэв.

буюу Оросын уламжлалт системийг үргэлжлүүлэхээс татгалзаж, Франц, Швейцарь, Белги, Герман, Австри, Англи зэрэг баруун европын орнуудад зонхилон тогтсон системийг хүлээн зөвшөөрсөн явдал байжээ.²³ Орос улсын шүүх байгууллагын тогтолцооны энэ үеийг Хаант засгийн үеийн шүүх тогтолцоо (judicial system in Tsarist period) хэмээн нэрлэнэ. Тухайн үед бусад аль ч улсаас илүүтэйгээр Францын эрх зүйн нөлөө хүчтэй байсантай Европын эрх зүйн хөгжлийг судлагч хэнбээр ч үл маргах буйзаа. Герман улс ч энэ үед Франц улсын шүүхийн тогтолцоог судлан өөрчлөгдөж байсан гэдэг.

Гэвч Орос улсын худалдааны шүүхийн тогтолцоо нь харьцангуй уламжлалт хандлагаа хадгалж 1864 оны шүүхийн их шинэтгэлээр төдийлөн өөрчлөгдөөгүй. Орос улсын худалдааны шүүх буюу өнөөгийн нэршлээр арбитражный суд (энэ нь манайд нэрлэж заншсан арбитр биш, шүүх байгууллага²⁴) нь хаант засаглалын үед буюу 1830 оны үед Санктпетербург, Москва болон бусад хэд хэдэн хотод байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан эдийн засгийн хэргийн шүүх (economic courts)-ийн түүхэн үргэлжлэл бөгөөд 1864 оны шинэтгэлээс ч өмнө Германы тогтолцоотой төсөөтэй байсан гэдэг.²⁵ Тухайн үед Арилжааны банкны дампуурлын тухай хураангуй дүрэм, Худалдааны шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль үйлчилж байснаас гадна Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль худалдааны шүүхийн үйл ажиллагаанд давхар үйлчлэх зохицуулалттай байжээ.

Гэвч 300 орчим жил тогтсон энэхүү систем 1917 оны Октябрийн хувьсгалын нөлөөгөөр өөрчлөгдөж, 1920-иод оны сүүл үеэс буюу Сталин засгийн эрх барих үеэс эхлэн социалист дэглэмийн онцлог бүхий шүүх байгууллагын тогтолцоо бий болсон. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоотой болох эдийн засгийн шинэ бодлогыг хэрэгжүүлж, улсын өмчит хуулийн этгээдүүдийн хооронд үүсэх эдийн засгийн шинжтэй маргааныг таслах тусгай байгууллагыг 1931 онд бий болгосныг Госарбитраж гэж нэрлэх болсон байна. Госарбитраж нь ЗХУ-ын Сайд нарын зөвлөлд шууд харьяалагдан төрийн өмчит хуулийн этгээдүүд нь төвлөрсөн төлөвлөгөө болон түүний дагуу байгуулагдсан гэрээний үүргээ биелүүлэхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэдэг байсан бөгөөд энэ байгууллагад өгсөн нэхэмжлэлээсээ талууд татгалзах, нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх эрхгүй байжээ. Госарбитражийг олонх судлаачид захиргааны байгууллага гэж хүлээн зөвшөөрдөг бол зарим судлаачид төрөлжсөн шүүх байсан хэмээн үздэг байжээ.²⁶ Госарбитражийг төрөлжсөн шүүх биш гэж үзэх гол үндэслэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа *ex officio*²⁷ зарчмыг баримталдагтай холбоотой.

Социалист дэглэм нуран унаснаас хойш нэг жилийн дараа буюу 1991 онд Худалдааны шүүхийн тухай хууль, 1992 онд Худалдааны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг тус тус баталсан байна. 1993 онд баталсан ОХУ-ын Үндсэн хуулийн 127 дугаар зүйлд Худалдааны хэргийн дээд шүүх нь эдийн засгийн хэрэг

²³Hiroshi Oda, Russian Commercial law, Second revised edition, Boston 2007, Martinuss Nijhoff publisher, p 23.

²⁴Зохиогчийн тайлбар: ОХУ-д ОХУ-ын худалдааны танхимын олон улсын арбитрын шүүх гэж байдаг бөгөөд тэр нь сонгодог арбитрын тогтолцооны институт юм. ОХУ-д арбитрын бусад байгууллагуудаа Trade court гэж нэрлэдэг байна. Энэ нь шүүх тогтолцооны байгууллагад хамаарах худалдааны шүүх буюу Арбитражны суд-ээс ялгаатай институт бөгөөд шүүх биш юм.

²⁵L.Schultz, Russische Rechtsgeschichte, Lahr 1957, s.217.

²⁶S.Kuchеров, "The Organ of Soviet Administration of Justice: Their History and Operation" Leiden 1970, pp. 140-153

²⁷Зохиогчийн тайлбар: Тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ талуудын зарчимд үндэслэхгүй, хэргийг хянан шийдвэрлэж буй этгээдийн санаачилгад суурилах зарчим

маргаан ба худалдааны шүүхэд харьяалуулсан бусад хэргийг хянан шийдвэрлэх дээд шатны шүүх болохыг хуульчилсан бол 1996 онд баталсан Шүүх тогтолцооны тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлд худалдааны шүүх нь ОХУ-ын шүүхийн нэгдсэн тогтолцооны нэг хэсэг мөн болохыг хуульчилжээ. ОХУ-ын Худалдааны шүүхийн болон Худалдааны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг 1995 онд дахин шинэчлэн баталж, улмаар 2002 онд Худалдааны хэрэг хянан шийдвэрлэх тухай төрөлжсөн хууль (код)-ийг шинээр мөрдүүлж эхэлсэн байна.

ОХУ-ын худалдааны хэргийн шүүхийн тогтолцоонд Холбооны худалдааны шүүх, Муж улсын худалдааны шүүх, Холбооны статус бүхий хотын шүүх, Автономит муж улс, бүсийн шүүхүүдээс бүрдэх бөгөөд нийт 81 анхан шатны худалдааны шүүх, 20 давж заалдах шатны шүүх, Холбооны нутаг дэвсгэрийн худалдааны шүүх гэж нэрлэгдэх гуравдах түвшний 10 шүүх (2007 оны байдлаар) багтдаг байна. ОХУ-д худалдааны хэргийг хянан шийдвэрлэх дээд шатны шүүх нь ОХУ-ын Худалдааны дээд шүүх байх ба энэ нь бүгд хурал (Plenum), зөвлөлийн хурал (Presidium), Иргэний хэргийн танхим (department of civil cases), Захиргааны хэргийн танхим (department of administrative cases) гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулдаг байна. Plenum буюу бүгд хуралд Захиргааны хэргийн дээд шүүхийн бүх шүүгчид, парламентын төлөөлөл, Дээд шүүхийн Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Ерөнхий прокурор оролцох эрхтэй. Бүгд Хурлын гол чиг үүргийн нэг нь доод шатны шүүхүүдэд чиглэсэн асуудлаар шийдвэр буюу хуучнаар зөвлөмжийн шинжтэй тайлбар (explanatory guidelines) гаргах явдал юм.

ОХУ-ын худалдааны шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэргийг үндсэнд нь иргэний хууль тогтоомжтой холбоотой хэргүүд, дампуурлын хэргүүд, захиргааны хууль тогтоомжтой холбоотой хэргүүд гэж ангилах боломжтой. Судалгааны байгууллагуудаас 2006 онд ОХУ-ын Худалдааны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн байдалд хийсэн судалгааны дүнгээс харвал 2005 онд нийт 1,467,368 хэрэг хянан шийдвэрлэгдсэнээс захиргааны хууль тогтоомжтой холбоотой 1,080,559 хэрэг (гол төлөв татварын хэрэг), иргэний хууль тогтоомжтой холбоотой 360,812 хэрэг шийдвэрлэгдсэн байна.²⁸ Үүнээс манай улсын хувьд хамгийн сонирхол татаж буй асуудлын нэг болох иргэний болон захиргааны хууль тогтоомжтой холбоотой хэрэг маргаануудыг төрлөөр нь авч задалбал: гэрээ байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах тухай, гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох тухай, гэрээний үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйтэй холбоотой маргаан, өмчлөх эрхийг хүчингүйд тооцох тухай, хууль бус эзэмшлээс хөрөнгөө буцаан гаргуулах тухай, хуулийн этгээдийг татан буулгах, өөрчлөн байгуулахтай холбоотой маргаан, үнэт цаасны маргаан, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах тухай, оюуны өмчийг хамгаалах тухай, байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөн тухай, гэрээнээс учирсан хохирлыг арилгуулахтай холбоотой маргаан, газар ашиглалт, татварын хууль тогтоомжтой холбоотой маргаанууд байна.²⁹

Худалдааны шүүхийн тогтолцооны асуудлыг авч үзэхэд хөндөх шаардлагатай чухал сэдэв бол худалдааны ба ердийн шүүхээр шийдвэрлэгдэх хэргүүдийн ялгаа заагийг тогтоох асуудал буюу шүүхийн харьяаллын асуудал юм. Учир нь ОХУ-д тодорхой төрлийн хэрэг маргааны хувьд эдгээр шүүхийн харьяалал давхцаж, харьяаллын ялгаа заагийг тогтооход бэрхшээлтэй байдал орчин үеийн худалдааны

²⁸ Hiroshi Oda, Russian Commercial law, Second revised edition, Boston 2007, Martinuss Nijhoff publisher, p 23-37

²⁹ VVAS RF, 2006, No 5, pp 22-39

шүүх үүсгэн байгуулагдсан цагаас өнөөг хүртэл олонтаа тохиолдож байгааг судлаачид тэмдэглэж санал бодлоо дэвшүүлсээр байна. Худалдааны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай 1995 оны хуульд заасны дагуу худалдааны шүүх нь “Хуулийн этгээд, хуулийн этгээдийн хэлбэрээр байгуулагдаагүй боловч хувиараа аж ахуй эрхлэгчийн зөвшөөрөл бүхий хувь хүмүүсийн хооронд иргэний, захиргааны, хууль зүйн бусад харилцаанаас үүссэн эдийн засгийн шинжтэй маргаан”-ыг хянан шийдвэрлэхээр заасан бол 2002 онд баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд ердийн харьяаллын шүүхэд “иргэн, гэр бүл, хөдөлмөрийн болон хамтралтай холбоотой хэрэг”-үүдийг харьяалуулсан байна.

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, олон улсын байгууллагын маргааныг аль шүүх хянан шийдвэрлэх вэ гэдэг нь ОХУ-ын судлаачдын анхаарлыг татаж буй асуудлын нэг юм. Учир нь 1995, 1996 оны процессын хуулиудад энэ нь худалдааны болон ердийн харьяаллын шүүхийн аль алины бүрэн эрхэд хамаарахаар заажээ. Энэ нь 2002 онд Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийг батлах үед энэ тэргүүнд шийдвэрлэхийг зорьсон асуудал байв. Худалдааны процессын шинэ төрөлжсөн хууль (код)-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д “аж ахуй эрхлэгчийн эрхэлж буй аж ахуйн үйл ажиллагаа, эдийн засгийн үйл ажиллагаанаас үүссэн эдийн засгийн болон бусад маргааныг худалдааны шүүх харьяалан шийдвэрлэхээр заажээ. Түүнчлэн дээрх зүйлд худалдааны шүүх нь Холбооны хууль тогтоомжид тухайлан заасан бол Холбооны болон мужийн, орон нутгийн агентлаг, намуудтай холбоотой хэрэг, гадаадын болон олон улсын байгууллага, гадаадын иргэн хувь хүнтэй холбоотой хэргийг ч хянан шийдвэрлэх боломжтой байна.

Энэ зохицуулалтаас үзвэл ОХУ-ын худалдааны шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааныг тодорхойлоход тухайн хэрэг маргаанд оролцогч талуудын шинж нь төдийлөн шийдвэрлэх хүчин зүйл болж чадахгүй байна. Учир нь иргэний эрх зүйн шинжтэй хэрэг маргаан буюу ердийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаанд ч дээрх этгээдүүд оролцох боломжтой. Иймд тус хуулийн 33 дугаар зүйлд худалдааны шүүхийн харьяалалд хамаарах маргааны төрлийг дараах байдлаар жагсаажээ. Үүнд:

- i. Дампуурлын хэрэг маргаан
- ii. Байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой маргаан
- iii. Хувиараа аж ахуй эрхлэгч, хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзсантай холбоотой маргаан
- iv. Хувьцаа эзэмшигч болон хувьцаат компанийн хооронд үүссэн маргаан, худалдааны буюу бизнес эрхлэгч компани, нөхөрлөл болон тэдгээрийн гишүүдийн хооронд үүссэн компани болон нөхөрлөлийн үйл ажиллагаатай холбоотой хөдөлмөрийн эрх зүйн шинжтэйгээс бусад маргаан
- v. Ажил хэргийн нэр хүндийг хамгаалахтай холбоотой маргаан
- vi. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэн явуулахтай холбоотой үүссэн болон Холбооны хуульд заасан эдийн засгийн шинжтэй үйл ажиллагаанаас үүссэн маргаан

Эдгээр төрлийн маргаан ямар этгээдийн хооронд үүссэнээс үл хамааран худалдааны шүүхийн бүрэн эрхэд хамаарах юм. Судлаачдын үзэж байгаагаар энэ нь шүүхийн харьяалалтай холбоотой ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг нэг мөр болгоход ихээхэн дөхөм болжээ. Тодруулбал маргаанд оролцогч субъектын байдлаас үл

шалтгаалан дээр дурдсан төрлийн хэрэг маргаан гарсан тохиолдолд ОХУ-ын хувьд энэ нь худалдааны шүүхийн онцгой харьяалалд хамаарах юм. Үүний зэрэгцээ ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т “Худалдааны болон ердийн шүүхийн аль алиных нь бүрэн эрхэд хамаарах хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлага бүхий маргаан нь тусдаа шийдэгдэх боломжгүй бол уг хэрэг маргааныг ердийн шүүх харьяалан шийдвэрлэх”-ээр заасан байна.

ОХУ-ын шүүхийн тогтолцоо, тэр дундаа худалдааны шүүхийн үүсэл хөгжлөөс тус улсын худалдааны эрх зүй нь урт удаан хугацааны баялаг уламжлал бүхий сонирхол татахуйц салбар болохыг ажиглаж болно. Иргэний болон худалдааны процессын эрх зүйн хувьд дуалист буюу хоёрдмол систем хөгжсөн хэдий ч материаллаг эрх зүйн хувьд иргэний болон худалдааны эрх зүйн нэгдмэл зохицуулалтыг эрхэмлэж ирснийг ОХУ-ын хувийн эрх зүйн хөгжлийн түүхэн замналаас нь анзаарч болно.

ОРОС УЛСЫН ХУДАЛДААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХӨГЖИЛ, ИРГЭНИЙ БА ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН НЭГДМЭЛ БАЙДАЛ, ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ

Иргэний хууль нь ОХУ-ын хувийн эрх зүйн суурь эх сурвалж бөгөөд иргэний болон худалдааны хуулийн шинжийг агуулсан, хувийн эрх зүйн салбарын бусад хууль тогтоомжоос давуу хүчин чадалтай хууль болно. ОХУ-ын Иргэний хууль бүтцийн хувьд пандектын системд хамаарна. Энэ хууль нь ерөнхий анги, хөрөнгийн эрх болон бусад өмчийн эрх, үүргийн ба гэрээний эрх зүйн ерөнхий ангийн зохицуулалт бүхий нэгдүгээр хэсэг, гэрээний тусгай төрлүүд, хууль бус үйлдэл, эс үйлдлээс үүсэх үүрэг, үндэслэлгүй хөрөнгөжих харилцааг зохицуулсан хоёрдугаар хэсэг, өв залгамжлал, олон улсын хувийн эрх зүй гэх гуравдугаар хэсэг, оюуны өмчийн эрх зүй гэсэн дөрөвдүгээр хэсгээс бүрдэнэ. Дээрх бүтцээс харахад Орос улсын Иргэний хууль нь Германы Иргэний хуультай ихээхэн төстэй боловч ялгагдах гол онцлог нь худалдааны эрх зүйн зохицуулалтыг Иргэний хууль өөртөө агуулсан байдагт оршино.

Оросын нэрт хуульч Г.Ф.Шершеневич худалдааны эрх зүйн түүхэн хөгжлийг Италийн, Францын, Германы гэсэн 3 үе шатанд хувааж үзсэн байна.

1. XI-XIV зууны үед Итали Улс өөрийн газар зүйн оновчтой байршлаас хамааран хамгийн хөгжингүй улсын нэг байсан. Дундад зуунд Италид усан болон хуурай замын худалдаа амжилттай хөгжсөн байна. Иргэний эрх зүй нь нарийн төвөгтэй, хэлбэрийн төдий олон шаардлага хангахыг шаарддаг учир худалдааны хэлцлийг түргэн шуурхай, найдвартай хийх хэрэгцээг хангахгүй болсон. Түүнчлэн иргэний эрх зүйн үндэсний өвөрмөц онцлог байдлыг харгалзсан шинж нь худалдааны олон улсын шинжид тохирохгүй болсон. Тийм учраас худалдааны зан заншилд суурилан худалдааны эрх зүй хөгжиж эхэлсэн. Италичууд буюу ломбардчууд (тэр үеийн нэршлээр) Европын худалдааны төвүүд, зах зээлүүд (ярмарки)-д худалдааны заншлийг түгээж байжээ.

2. Францын үе шатанд Франц Улс нь худалдааны тэргүүлэх гүрэн болж хөгжсөн бөгөөд худалдааны төрөлжсөн хууль гаргах анхны оролдлогыг хийж байжээ. 1673 онд “Торговый Ордонанс” буюу Худалдааны хууль, 1681 онд “Морской Ордонанс” буюу Далайн хууль гэгчийг батлан гаргаж байсан нь түүхэн үүрэг гүйцэтгэж, хожим нь Францын Худалдааны төрөлжсөн хууль (кодекс)-ийн үндэс нь болсон.

Францын Худалдааны төрөлжсөн хууль (кодекс) нь (1807 он) Итали, Швейцарь, Бельги болон бусад хэд хэдэн улсад шууд хэрэглэгдэж байжээ. 1807 оны хууль нь 4 дэвтэр 648 зүйлтэй байсан бөгөөд 2000 онд олон тооны нэмэлт, өөрчлөлт оруулж,

шинэчлэн боловсруулсан Худалдааны төрөлжсөн хууль (Коммерческий Кодекс) эдүгээ хүртэл үйлчилж байна.

3. Немецкий буюу Германы үе шат нь түүхэн үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг.

XIX зууны эхэн үед Герман Улс нь бие даасан олон тооны Вант улс, хотуудаас бүрдсэн байсан бөгөөд феодалын нийгмийн харилцааг зохицуулсан хэм хэмжээний янз бүрийн актууд үйлчилж байсан нь капиталист нийгмийн харилцааг зохицуулахад тохирохгүй болсон учир Германы хөрөнгөтнүүд худалдааны харилцааг нэгдмэл зохицуулалттай болгохыг эрмэлзэж байв. 1847 онд Векселийн Дүрэм (Вексельный устав), 1861 онд Худалдааны хууль (Торговое уложение)-ийг баталсан бөгөөд 1896 онд батлагдсан Иргэний хууль (Гражданское уложение) нь Худалдааны хуультай зарим талаараа зөрчилдөж байсан тул 1897 онд Германы Худалдааны хууль (Германское Торговое уложение)-ийг баталж 1900 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон байна.

Герман, Франц Улсад Худалдааны болон Иргэний төрөлжсөн хууль бий болсон нь хувийн эрх зүйд дуализм үүсэх үндэс болсон. Улмаар Испани, Грек, Португаль, Япон зэрэг улс худалдааны төрөлжсөн хуультай болсон.

Хувьсгалаас өмнөх үеийн худалдааны эрх зүйн үүсэл хөгжлийн түүхийг судалсан судлаач И.В.Архипев Орос Улсын худалдааны эрх зүйн хөгжлийг 3 үе шатанд хувааж үзжээ. Эхний үе шат нь 1804-1825 оныг хамрах бөгөөд энэ үед худалдааны төрөлжсөн хуулийн төслийг боловсруулахаар шийдвэрлэж анхны оролдлого хийсэн байна.

Хоёрдахь үе шат нь 1847 оноос эхлэх бөгөөд энэ үеэс худалдааны эрх зүйн суурь ойлголтуудын иргэний эрх зүйгээс ялгагдах онцлогийг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, тэдгээр онцлогийг Оросын хуулиудад тусгах оролдлого хийсэн үе байв.

Сүүлийн үе шат нь XIX зууны сүүл XX зууны эхэн үе юм. Тэр үеийн хөрөнгөтнүүд нийгэм эдийн засгийн нөхцөл өөрчлөгдсөнтэй холбоотой шинэчлэл хийх гэсэн оролдлого хийсэн боловч түүнийгээ гүйцэлдүүлж чадаагүй учраас Худалдааны төрөлжсөн хуулийг баталж чадаагүй. Тухайн үед худалдааны эргэлтийг зохицуулж байсан гол эх сурвалж нь 1857 оны Худалдааны Дүрэм (Устав Торговый) байсан бөгөөд 1903 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Уг худалдааны Дүрэм нь 3 дэвтэрээс бүрдэх ба Нэгдүгээр дэвтэрт худалдаанд хамаарах гэрээ, үүргийн харилцааг, Хоёрдугаар дэвтэр нь далайн эрх зүй, харин гуравдугаар дэвтэрт худалдааны хэргийг Хаант Улсын дотоодод төдийгүй гадаадад амжилттай эрхлэх арга хэрэгслийг хамааран зохицуулсан байв. Харин Гуравдугаар дэвтэрт голдуу худалдаанд хамаарах нийтийн эрх зүйн шинжтэй шаардлагуудыг багтаасан байв.

Мөн тэр үед худалдааны заншил эрх зүйн гол эх сурвалж болж байсан ба Зээлийн дүрэм (Устав кредитный), Векселийн дүрэм (Устав векселя) зэрэг хэм хэмжээний акт үйлчилж байжээ. Түүнчлэн дээр дурдсанаар худалдааны шүүхүүд тэдгээрийн шийдвэр чухал үүрэг гүйцэтгэсэн.

1873-1874 онд П.П.Цитович Худалдааны бүрэн курс (сурах бичиг)-ийг боловсруулсан ба 1884 онд Их сургуулийн дүрэмд хуулийн бүх факультет-д худалдааны эрх зүйн тэнхим бий болгохоор зааж, худалдааны эрх зүйн хичээлийг оюутнууд системтэй судлах болсон. Энэ үеэс худалдааны эрх зүйн шинжлэх ухааны үзэл

баримтлал, үндсэн категориуд, институтуудыг томъёолох, боловсруулах явдал идэвхижиж иржээ.

Оросын иргэний хууль нь түүхэн хөгжлийнхөө туршид худалдааны хэм хэмжээг агуулж байсан уламжлалт хандлагатай байсан бөгөөд Хаант засгийн үеийн Худалдааны эрх зүйн томоохон судлаач, эрдэмтдийн нэг Г.Ф.Шершеневич “Орос хэзээд хувийн эрх зүйн нэгдмэл тогтолцоотой улс байсан” гэж хэлжээ.³⁰ Харин “Хуулийн эмхтгэл” (Свод законов)-д 1887 онд оруулсан өөрчлөлтөөр иргэний эрх зүйн зохицуулалтыг 10 дугаар дэвтэрт байхаар зааснаас гадна 11 дүгээр дэвтрийн 2 дугаар хэсэгт арилжааны буюу худалдааны эрх зүйн зохицуулалтыг давхар тусгаж Хаант засгийн сүүлийн жилүүдэд худалдагчийн тээвэрлэлтийн гэрээ, компанийн янз бүрийн төрлийг зохицуулсан зарим зүйл заалтыг нэмсэн байдаг. Гэсэн хэдий ч хуулийн үзэл баримтлал мөн л тодорхой биш байсан бөгөөд учир нь 10 дугаар дэвтэрт ашгийн төлөө компанийн харилцаа, даатгалын гэрээний зохицуулалтууд давхар багтсан байжээ.³¹

Орос Улсын дараа дараагийн иргэний хуулиуд буюу хаант засгийн үеийн иргэний хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 1922 оны Иргэний хууль, 1991 оны Иргэний хууль, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиуд аль аль нь хувийн эрх зүйн нэгдмэл тогтолцоог баримталсан байна.

1917 оны Октябрын хувьсгалын дараа Шинэ эдийн засгийн бодлого (Новая экономическая политика буюу НЭП)-ын үед иргэний болон худалдааны эрх зүйн харилцааны талаар маргаан үргэлжилсээр байсан юм. Худалдааны эрх зүй бие даасан салбар болохыг худалдааны харилцаа, худалдааны хууль тогтоомжийн өвөрмөц онцлогтой холбон тайлбарладаг байсан бол социалист нийгмийн үед нийтийн шинжийг илэрхийлсэн худалдааны механизм, харилцаанд нийцсэн худалдааны эрх зүйн онцгой хэм хэмжээг бүрдүүлэх шинэ үзэл баримтлалыг илэрхийлэх болсон.

Зарим хуульчид, тухайлбал, В.Гордон, Д.Иваницкий, С.Драбкин нар бие даасан худалдааны хууль боловсруулах, эсвэл худалдааны эрх зүйг иргэний эрх зүйн бие даасан хэсэг болгох үзэл санааг дэвшүүлж байжээ.

Зах зээлд шилжих шилжилтийн үе буюу 1990 оны эхээр шинээр Иргэний хуулийн төслийг боловсруулж байх үед ч зарим судлаачид иргэний ба худалдааны хууль тогтоомжийг салгах санал гаргаж байжээ.³² ОХУ-ын Иргэний хуулийн 2 дугаар зүйлд тус хуулийн зохицуулах зүйл, зарчмыг тусгаснаас гадна “Иргэний хууль нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй аливаа этгээдийн хооронд үүссэн харилцаа, эсхүл тусгай хууль тогтоомжийн дагуу бүртгүүлж үйлчилгээ үзүүлэх, ажил гүйцэтгэх, бараа бүтээгдэхүүн худалдах, хөрөнгө ашиглах замаар байнгын ашиг орлого системтэй бий болгох зорилготой, үйл ажиллагаанаасаа бий болсон эрсдлийг өөрөө бие даан хариуцах аж ахуйн үйл ажиллагаанд оролцогч этдээдийн дотоодод үүссэн харилцааг зохицуулна” гэж заасан байна. Энэхүү төрөлжсөн хууль нь “торговый” (commercial) буюу “худалдаа” гэх томъёоллыг хэрэглээгүй “предпринимательский” (entrepreneurial) буюу “аж ахуйн үйл ажиллагаа” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байх боловч дээрх заалтаар ОХУ нь хувийн эрх зүйн нэгдмэл тогтолцоотой болохыг тодорхой илтгэж байна.

³⁰ Hiroshi Oda, Russian Commercial law, Second revised edition, Boston 2007, Martinuss Nijhoff publisher, p 68

³¹ D.A.Nosenko ed. Ustav torgovyi. St. Petersburg 1909.

³² V.V.Chankin, Torgovoe pravo: sovremennyye tendentsii, GiP 1993, No.2, pp 57-64

Иргэний эрх зүйн зарим сурах бичгүүдэд худалдааны эрх зүй нь иргэний эрх зүйн нэг хэсэг гэж үздэг бөгөөд ашгийн төлөөх аж ахуйн үйл ажиллагаанд худалдааг хамааруулан гүнзгийрүүлэн судлах шаардлагатай гэж тэмдэглэсэн байдаг. Тийм ч учраас дээд боловсролын улсын стандартад “Худалдааны эрх зүй” (Коммерческое право) хичээлийг бие даасан хичээл болгон тусгасан байна.

Орос улс ийнхүү түүхэн хөгжлийн бүхий л үед хувийн эрх зүйн нэгдмэл байдлыг хадгалж үлдсэн үндсэн шалтгаан нь нэгдүгээрт, хувийн эрх зүйн уламжлалт хандлага үргэлж нэгдмэл байсан, хоёрдугаарт, Европын орнуудын сүүлийн үеийн төрөлжсөн хуулиуд болох Голланд, Италийн хуулиуд нэгдмэл тогтолцоог баримталсан, гуравдугаарт социализмын үеийн иргэний эрх зүйн салбарын зөрчил буюу иргэний хуулиас салангид эдийн засгийн тусдаа хуультай байх үзэл баримтлалын эсрэг хүчтэй эсэргүүцэл байсан зэргийг нэрлэж болох юм.³³

Худалдааны харилцааны эрх зүйн зохицуулалт нь юуны өмнө ОХУ-ын Үндсэн хуулийн суурь зарчмуудад үндэслэгдсэн байна. Үүнд:

1. Хүн бүр өөрийн мэдлэг чадвар, хөрөнгөө аж ахуйн болон хуулиар хориглоогүй эдийн засгийн бусад үйл ажиллагаанд чөлөөтэй ашиглах;
2. Өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийг адил тэгш хамгаалах;
3. Хууль ёсыг дээдлэх;
4. Өрсөлдөөнийг дэмжиж, монополчлол, шударга бус өрсөлдөөнд чиглэсэн эдийн засгийн үйл ажиллагааг эс зөвшөөрөх;
5. Аж ахуйн үйл ажиллагаанд хувийн болон нийтийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлж, хослуулах;
6. Үндсэн хуулийн байгууламжийн үндэс, бусад этгээдийн зан суртахуун, эрүүл мэнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үүднээс гагцхүү холбооны хуульд заасан тохиолдолд хувь хүн, иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлах зэргийг нэрлэж болно.

Түүнчлэн ОХУ-ын Иргэний хуулийн нэгдүгээр хэсгийн ерөнхий анги, нэгдүгээр зүйлд иргэний ба худалдааны эрх зүйн үндсэн зарчмыг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

- i. Иргэний эрх зүйн харилцаанд тэгш эрхтэй оролцох
- ii. Өмчийн халдашгүй байдал
- iii. Гэрээний чөлөөт байдал
- iv. Хувь хүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглох
- v. Иргэний эрх зүйн эрхээ саадгүй хэрэгжүүлэх
- vi. Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах

Иргэний гүйлгээнд талууд тэгш эрхтэй оролцох, өмчлөлийн хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө адил тэгш эрхтэй байх тухай эхний зарчим, түүнчлэн хэний ч өмчийн эрхийг хуулиар хамгаалах, өмчлөх эрхэд халдахгүй байх агуулга бүхий өмчийн халдашгүй байдлын тухай дараагийн зарчим, иргэний эрхээ чөлөөтэй, саадгүй хэрэгжүүлэх зарчмууд нь Үндсэн хуулийн суурь зарчимд тооцогдоно. Гэвч дээрх эрхүүд хуульд тодорхой заасан тусгай тохиолдлуудаар хязгаарлагдаж болох ба тухайлбал Иргэний эрх зүйн гэрээний чөлөөт байдлын зарчим, иргэний эрх зүйн эрхээ чөлөөтэй, саадгүй хэрэгжүүлэх зарчмуудыг өрсөлдөөнийг хамгаалах зэрэг зорилгоор хязгаарлах

³³ Hiroshi Oda, Russian Commercial law, Second revised edition, Boston 2007, Martinuss Nijhoff publisher, p 69

тохиолдол бий. Энэ талаар ОХУ-ын Иргэний хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т дараах байдлаар тусгажээ.

Иргэн, хуулийн этгээд иргэний эрх зүйн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдад хохирол учруулах, бусдын эрхийг хязгаарлахыг хориглоно. Иргэний эрх зүйн эрхээ өрсөлдөөнийг хязгаарлах, зах зээлд давамгайлах байдлаа хууль бусаар ашиглах хэлбэрээр хэрэгжүүлж болохгүй.

Дээрхээс гадна худалдааны эрх зүйн тусгай зарчимд:

1. Үндэсий бараа таваарын зах зээлийг хамгаалах зарчим. (Принцип защиты национального товарного рынка.) Зарим бараа таваарын борлуулалтанд квот тогтоох, лицензтэй болгох, үнэ, тарифыг зохицуулах, импорт, экспортын бараанд түр хугацааны хязгаарлалт, хориг тогтоох зэрэг Засгийн газраас дотоодын зах зээлийг хамгаалахад чиглэсэн олон арга хэмжээ авдаг.

2. Хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэх зарчим. (принцип приоритета интересов потребителей) Худалдааны үйл ажиллагааны зорилго нь зөвхөн ашиг олох бус харин нийтийн эрэлт хэрэгцээг хангахад орших ёстой. Тиймээс хэрэглэгчид өндөр чанар, тоо хэмжээний зохих нэрийн барааг боломжийн үнээр худалдах замаар хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангаж, ингэснээрээ ашиг орлогоо нэмэгдүүлж харилцан ашигтай байх явдалд үндэслэгдэнэ.

ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАХ ЗҮЙЛ, ОНЦЛОГ

“Commercium” гэдэг үгийг латин хэлнээс орчуулбал “торговля” буюу “худалдаа” гэсэн үг. Худалдааны эрх зүй гэсэн нэр томъёог орос хэлнээ “коммерческое право”, эсхүл “торговое право” хэмээн хэрэглэж нэршсэн болохыг эх сурвалжуудаас харж болно. Зарим судлаачдын үзэж байгаагаар “коммерческая деятельность” гэдэг нь “торговая деятельность” гэдгийг бодвол илүү өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд бараа таваарыг худалдах-худалдан авахтай холбоотой олон үйлдлээс гадна бараа үйлдвэрлэгч болон худалдан авагчид үзүүлдэг олон төрлийн үйлчилгээг өөртөө багтаасан байдгаараа онцлог, өргөн хүрээтэй гэжээ.

Оросын Холбооны Улсын Иргэний хуулийн 50 дугаар зүйлд хуулийн этгээдийг “коммерческое” буюу “ашгийн төлөө”, “не коммерческое” буюу “ашгийн төлөө бус” гэж ангилсан байна.

Гэтэл ашиг орлого олох зорилготой аж ахуйн үйл ажиллагаа буюу “предпринимательская деятельность” гэсэн нэр томъёо байдаг бөгөөд “коммерческая деятельность” гэдэг нь “предпринимательская деятельность” гэдгийн нэг төрөл нь байж байнгын ашиг орлого олоход чиглэгдсэн аливаа үйл ажиллагааг ойлгодог байна. Нэр томъёог буруу хэрэглэснээс болж агуулгын хувьд өөр өөр ойлголтуудыг хооронд нь хольж хутгах явдал гарч болохыг үгүйсгэхгүй. Манайд “Предпринимательское право” гэдгийг “Аж ахуйн эрх зүй” гэж нэрлэдэг байсныг та бид санаж байгаа биз ээ.

Худалдааны эрх зүйн зохицуулах зүйлийг тодруулахын тулд юуны өмнө худалдааны үйл ажиллагааны (“коммерческая деятельность”) эдийн засгийн ойлголтод анхаарлаа хандуулах шаардлагатай.

Орчин үед материаллаг нөөц баялгийн хөдөлгөөн гурван орчны хүрээнд оршиж харилцан нөхцөлдсөн байна. Үүнд: Бараа таваарын үйлдвэрлэлийн орчин, бараа таваарын гүйлгээ, эргэлтийн орчин, бараа таваар, үйлчилгээний хэрэглээний орчин.

Үйлдвэрлэлийн хөгжил, өсөн нэмэгдэж байгаа олон янзын шинэ эрэлт хэрэгцээ нь үйлдвэрлэгч, хэрэглэгч хоёрын хооронд олон тооны зуучлалын болон дамжуулагч байгууллага бий болгох шаардлага үүсгэж байна.

Бараа таваарын эргэлтийг салбарын бүтцээр нь авч үзвэл бөөний худалдааны салбар, жижиглэнгийн худалдааны салбар, нийтийн хоолны салбар, ачаа тээвэрлэлтийн үйлчилгээний салбар, агуулахын аж ахуйн салбар гэх мэт ангилж авч үзэж болно.

Бөөний худалдаа нь байнгын ашиг орлого олох, аж ахуйн үйл ажиллагаанд зориулж бараа таваарыг олж авах, худалдах зорилгод чиглэгдсэн байдаг бол жижиглэнгийн худалдаа нь бараа таваарыг амин хувийн, гэр бүлийн, ахуйн хэрэгцээнд зориулан олж авах, худалдахад чиглэгдсэн байдаг.

Тиймээс бөөний болон жижиглэнгийн худалдаа нь бараа таваарыг олж авах, хэрэглэх зорилгоороо ялгаатай.

Худалдааны эрх зүйн зохицуулах зүйл нь бөөний худалдааны орчинд үүсдэг худалдааны үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой олон төрлийн нийгмийн харилцаа байдаг. Жижиглэнгийн худалдаанд иргэний эрх зүйн субъект болох иргэн оролцдог бөгөөд тэдгээр нь мэргэжлийн мэргэшсэн худалдаачидтай харьцуулахад иргэний эрх зүйгээр зохицуулагдсан эрх зүйн хамгаалалтын онцгой хэрэгслээр хамгаалуулах шаардлагатай байдаг.

Харин аж ахуй эрхлэх субъектүүдийн худалдааны болон худалдаа зуучлалын үйл ажиллагааг аж ахуйн үйл ажиллагааны тусгай бие даасан төрөл болгон авч үзэж болох бөгөөд эрх зүйн хамгаалалтын хувьд онцлог зохицуулалт шаардагдана.

Худалдааны үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх явцад олон төрлийн эрх зүйн харилцаа үүсч байдаг. Тухайлбал,

1. Худалдааны эрх зүйн харилцааны үндсэн төрөл бол үйлдвэрлэгчид шаардлагатай түүхий эд, материал, тоног төхөөрөмж нийлүүлэхтэй холбогдсон үйлдвэрлэгч болон бөөний худалдаачид буюу зуучлалын салбарынхны хооронд үүссэн гэрээний үүргүүд, түүнчлэн үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн бараа таваарыг борлуулах явцад бөөний болон жижиглэнгийн худалдаачдын хооронд үүссэн гэрээний үүргийн харилцаа хамаардаг.

Өөрөөр хэлбэл, бараа таваарыг хүргэх, тээвэрлэх, хадгалах, түүнчлэн маркетингийн болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой олон төрлийн гэрээний үүргийг хамааруулан авч үзэж болно.

2. Худалдааны үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх, худалдаа зохион байгуулахтай холбоотой орон нутгийн өөрийн удирдлагын болон төрийн захиргааны бусад байгууллагууд, түүнчлэн худалдаа эрхлэгчдийн хооронд байгуулсан гэрээний үүрэгтэй холбоотой харилцаанууд чухал үүрэгтэй байдаг. Тухайлбал, нийтийн ашиг сонирхлын үүднээс шударга өрсөлдөөнийг зохицуулах, зах зээлд давуу байдал бий болгохгүй байх, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор зарим нэр төрлийн бараанд (согтууруулах ундаа, эмийн төрлийн бараа,

хүнсний бүтээгдэхүүн гэх мэт) тусгай шаардлага, шалгуур тавьж үүрэг хүлээлгэсэн гэрээнүүдийг нэрлэж болно.

3. Дээрхээс гадна худалдааны үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой байгууллагын дотоод зохион байгуулалтын олон талт харилцаа (бизнесийн үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн стандарт боловсруулах, төлөвлөлт, прогнозчлол, хяналт гэх мэт) нэгэн адил хамаарна.

Худалдааны эрх зүй нь бусад салбар эрх зүйтэй холбоотой:

➤ Юуны өмнө иргэний эрх зүйтэй салшгүй холбоотой иргэний хуулийн өмчийн болон эд юмсын бусад эрх, хэлцэл, гэрээ, үүргийн институтууд нь аж ахуйн бүхий л харилцааг зохицуулахад ашиглагддаг ба иргэний эрх зүйн үндсэн зарчмыг худалдааны эрх зүйд нэгэн адил удирдлага болгодог.

Худалдааны эрх зүй нь хариу төлбөртэй, нэг төрлийн явцуу хүрээний харилцааг зохицуулдаг бол иргэний эрх зүй нь хариу төлбөртэй буюу төлбөргүй, худалдааны буюу бусад субъектүүдийн хооронд үүсдэг бусад олон төрлийн харилцааг зохицуулдаг онцлогтой.

➤ Аж ахуйн эрх зүй (Предпринимательское право) нь аж ахуйн үйл ажиллагааг зохион байгуулах болон хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг асуудлыг судлахын зэрэгцээ нийтийн эрх зүйн болон хувийн эрх зүйн ашиг сонирхлын зохист харьцааг хангахад чиглэгдсэн зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх зорилгоор зах зээлийн харилцааны төрийн зохицуулалтын арга, хэрэгслийг мөн судалдаг.

Тэгвэл худалдааны үйл ажиллагаанд худалдааны субъектүүдийн чиг үүргийн онцлогийг харгалзсан зохицуулалтын тусгайлсан дүрэм журам шаардлагатай байдаг онцлогтой.

➤ Худалдааны үйл ажиллагааны явцад бараа таваар үйлдвэрлэгч болон худалдаачид татвар төлөхтэй холбоотой санхүүгийн эрх зүйн харилцааны субъект болдог.

Худалдааны аливаа гэрээ нь хувийн эрх зүй төдийгүй нийтийн эрх зүйн үүрэг үүсгэдэг.

➤ Худалдааны эрх зүй нь захиргааны эрх зүй болон эрүүгийн эрх зүйтэй нягт холбоотой худалдааны олон талт үйл ажиллагааны хүрээнд бий болох зөрчлүүдэд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байдаг. Тухайлбал, иргэний гүйлгээнд хязгаарлалттай оролцдог барааг хууль бусаар худалдаалах, техникийн болон эрүүл ахуйн шаардлага хангаагүй барааг худалдах, аюулгүй байдлын шаардлага хангаагүй үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт хийх гэх мэт зөрчлүүдийг нэрлэж болно.

➤ Түүнчлэн худалдааны эрх зүй нь эдийн засгийн шинжлэх ухаантай салшгүй холбоотой. Тухайлбал, менежмент, маркетинг, логистик гэх мэт.

2.3 ЯПОН УЛСЫН ХУДАЛДАА (АРИЛЖАА)-НЫ ЭРХ ЗҮЙ³⁴

ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

1. Нийтлэг тайлбар

Иргэний хуулиас тусдаа бие даасан ба Иргэний хуулийн үргэлжлэл гэсэн ойлголтод суурилж үүссэн нэгдмэл эрх зүйн тогтолцоо бол Худалдааны эрх зүйн онолын суурин дээр 19-р зуунаас эхлэн Эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улсуудад анх Худалдааны хуулийг баталснаар үүссэн гэж үздэг. Гэсэн хэдий ч Европын эрх зүйн хөгжилд томоохон нөлөө үзүүлсэн Ромын эрх зүйд Худалдааны эрх зүй байгаагүй. Худалдааны хуультай болохын тулд Худалдааны хуулиар зохицуулах олон төрлийн эрх зүйн хэм хэмжээ тодорхой хэмжээнд хуримтлагдсан байх ёстой боловч тэр нь дундад зууны үед худалдааны төв хотуудад ГҮЙЛД буюу худалдаа эрхлэгчдийн нийгэмлэгийг байгуулж, өөрөө удирдах ёсны дүрэм журмыг баталж мөрдүүлснээр худалдаа эрхлэгч хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх шүүхийг бий болгож худалдааны хэлцэлтэй холбоотой заншлын хэм хэмжээг өргөн хэмжээнд хэлбэржүүлсэн Худалдаачны хууль (Lex Mercatoria)-иас эх үүсэлтэй гэж үздэг байна.

Худалдаачны хууль нь үндсэндээ ангийн эрх зүй, өөрөөр хэлбэл худалдаа эрхлэгчдэд л зориулагдсан хууль бөгөөд худалдаа эрхлэгчдээс гадна аль ч улсын худалдаа эрхлэгчид үйлчлэх нийтлэг шинжтэй байсны дараагаар төрийн оролцоо нэмэгдэхтэй зэрэгцээд Худалдаачны хуулийг “Төржүүлэх” чиглэлрүү хөгжсөн. Үүний жишээ нь Францын Колберт хааны 1673 онд баталсан “Эх газрын худалдааны зарлиг” (Ordonnance sur le de terre) болон 1681 оны “Далайн худалдааны зарлиг” (Ordonnance sur le de mer) юм. Энэмэтчилэн төрөөс бичмэл хууль хэлбэрээр батлах хандлагыг дагалдаад 19-р зууны эхэн үеэс Эх газрын эрх зүйн системтэй улсууд дахь Худалдааны төрөлжсөн хуулийг батлах явц эрчимжсэн билээ.

Гэвч нөгөө талаараа Англи-Америкийн эрх зүйн тогтолцооны гол төлөөлөгч болох Англи улсад худалдааны хэм хэмжээг төржүүлэх буюу бие даасан хууль болгох үйл явц эх газрын эрх зүйн системтэй улсуудаас тэс өөр хэлбэрээр явагдсан. Өөрөөр хэлбэл нийтлэг эрх зүйд Худалдаачны эрх зүй дэлгэрч нийтлэг эрх зүйн нэг үндсэн суурь тогтолцоо болсон. Энэ үйл явдал нь 17-р зууны Нийтлэг эрх зүйн шүүхээс Худалдааны шүүхийн харьяалалд (Худалдаатай холбоотой эх газрын болон далайн худалдааг хамааруулсан иргэний болон эрүүгийн хэргийг харьяалан шийдвэрлэх эрхтэй байсан) маш өргөн хэмжээний эрхийг олгож дараагаар нь 18-р зууны Мансфельд шүүгч (Lord Mansfield)-ээр төлөөлүүлсэн шүүхийн жишгээр дамжин худалдааны эрх зүй нь нийтлэг эрх зүйд дэлгэрч бодит биелэлээ олсон. Энэхүү явдал нь Англи-Америкийн эрх зүйн тогтолцоотой улсуудад Материаллаг худалдааны эрх зүй- Худалдааны эрх зүй нь бие даасан эрх зүй гэсэн ойлголтыг хүлээн зөвшөөрөхгүй байх нэг шалтгаан болсон юм.

2. Япон улсын Худалдааны хуулийн бүтэц

Япон улсын Худалдааны хууль нь эхлээд Мэйжигийн 23 (1890) онд Германы эрдэмтэн Херман Лислерийн төсөлд үндэслэн батлагдсан байдаг. Гэвч хэрэгжих хугацааг нь сунгасаар түүний нэг хэсэг (компани, вексел, дампууралтай холбоотой зохицуулалтууд) нь л Мэйжигийн 26 (1893) онд хэрэгжиж эхэлсэн. Түүний дараагаар

³⁴ “Харьцуулсан Худалдааны эрх зүй” номын хэсэг болох МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш С.Батбаяр, Н.Норовсамбуу нарын бичсэн хэсгээс ишлэв.

Мэйжигийн 32 (1899) дугаар онд хуучин Худалдааны хуулийг хүчингүй болгож шинэ Худалдааны хуулийг баталж мөрдүүлсэн байна. Тус Худалдааны хууль нь хэд хэдэн удаа өөрчлөлт орсон боловч одоог хүртэл хүлээн зөвшөөрөгдсөн хэвээр хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Хамгийн гол анхаарах зүйл нь Хэйсэй 17 (2005) оны 6 сард Компанийн тухай хууль батлагдсанаар Худалдааны хуулийн компанитай холбоотой зохицуулалтууд хүчингүй болсон. Түүнтэй нийцүүлэн Худалдааны хуулийн 1-р бүлэг Ерөнхий анги, 2-р бүлэг Худалдааны хэлцлийн 1-4 дүгээр бүлэг хүртэлх зохицуулалтыг орчин цагийн япон хэлэнд хөрвүүлсэнтэй хамт бага зэргийн өөрчлөлтийг оруулсан байна. Тухайлбал Хэйсэй 20 (2008) онд Даатгалын хуулийг Худалдааны хуулиас тусгаарлаж бие даасан хууль болгосон. Цаашид ч орчин үеийн нийгмийн харилцаанд нийцүүлэн Худалдааны хуулиас тусгаарласан хуулиудыг батлах төлөвтэй байна.

Одоогийн Худалдааны хууль нь 1807 оны Францын Худалдааны хуультай адилаар холимог тогтолцоог авсан. Өөрөөр хэлбэл худалдаачны тодорхойлолт болон худалдааны хэлцлийг аль алийг нь Худалдааны хуулийн үндэс болгож худалдаа эрхлэгч болон худалдааны хэлцлийн аль алийг нь хангаж байж Худалдааны хуулийн зохицуулалт үйлчилнэ. Худалдаачны ойлголт нь худалдааны хэлцлээс урган гарсан (хувь хүн худалдаа эрхлэгч) болон түүнтэй хамааралгүй зохицуулалт (хуурамч худалдаа эрхлэгч) байдаг.

Энэ талаар Худалдааны хуулийн тодорхой зүйл, заалтыг судлан үзвэл Худалдааны хуулийн 4-р зүйлд худалдааны этгээдийн тодорхойлолтыг тусгасан байдаг бөгөөд түүний 1-р заалтад “Тус хууль дахь “худалдаа эрхлэгч” гэдэг нь өөрийн нэрээр, худалдааны хэлцэл хийх үйлдлийг өөрийн үйл ажиллагаагаа болгосон этгээдийг ойлгоно” гэж заасан байдаг (Энэ хэлбэрийн худалдаа эрхлэгчийг “Ерөнхий худалдаа эрхлэгч” гэж нэрлэдэг). Өөрөөр хэлбэл, худалдаа эрхлэгч гэх ойлголт нь худалдааны хэлцэл гэх ойлголтод тулгуурлан тодорхойлогдсон байгааг буюу худалдааны хэлцлийн зарчмыг баримталсан болохыг харж болно.

3.Худалдааны эрх зүйн мөн чанар ба эрх зүйн салбарт эзлэх байр суурь

3.1. Худалдааны эрх зүйн мөн чанар

Япон улсад “Роппо” буюу “Зургаан хууль” гэсэн ойлголт байдаг. Энэ нь нийгмийн амьдралыг зохицуулахад хамгийн гол үүргийг гүйцэтгэдэг зургаан хуулийг багтаан ойлгох бөгөөд үүнд Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Худалдааны хууль хамаардаг. Бие даасан тусгаар улсын хувьд төрийн байгууламж, иргэний үндсэн эрхийг суурь харилцааг зохицуулдаг хамгийн дээд хүчин чадал бүхий Үндсэн хууль, иргэдийн нийгмийн өдөр тутмын амьдралын харицааг зохицуулах Иргэний хууль, нийгмийн дэг журмыг тогтоож түүнийг зөрчсөн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага тооцох замаар нийгмийн аюулгүй байдлыг сахин хамгаалж байдаг Эрүүгийн хууль, дээрх хуулиудыг амьдрал дээр бодитоор хэрэгжүүлэх журмыг тогтоодог процессын хуулиуд заавал шаардлагатай байдаг.

Гэтэл яагаад Худалдааны хуулийг дээрх гол хуулиудтай зэрэгцүүлэн авч үзэх ёстой талаар олон талын байр суурь байдаг боловч иргэдийн өдөр тутмын харилцаатай холбогдох хувийн эрх зүйн салбарт хамаарах чөлөөт зах зээлийн нийгэмд улам бүр өргөжин тэлж буй бизнес эрхлэгчдийн хоорондох харилцааг тусгайлан зохицуулах шаардлагын үүднээс Худалдааны хуулийг онцгой ач холбогдолтой гэж үздэг ч

эсэргээрээ Худалдааны хуульгүй улсууд ч байдаг. Тиймээс Япон улсад чухам яагаад Худалдааны хуулийг чухлаар авч үздэг талаар авч үзье.

Худалдааны эрх зүйг онолын хувьд Формал худалдааны эрх зүй ба Материаллаг (материаллаг) худалдааны эрх зүй гэж ангиладаг. Формал худалдааны эрх зүй гэдэг нь Худалдааны хууль хэмээн нэрлэгдсэн бие даасан хуулийг илэрхийлэх бөгөөд Япон улсын хувьд 1899 онд батлагдан одоо ч хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Худалдааны хуулийг илэрхийлж буй юм. Нөгөө талаар Материаллаг худалдааны эрх зүй гэдэг нь худалдааны эрх зүйд хамааруулан авч үзэх тусгай хуулиудын нийлбэр цогц юм. Хувийн эрх зүйд Иргэний хуулийг ерөнхий эрх зүйн хэм хэмжээ гэж үздэг бол Худалдааны эрх зүй нь бие даасан тусгай хуулиудын нийлбэр цогцоос бүрддэг гэж тайлбарладаг.

Худалдааны эрх зүй нь ямар ямар салбарыг хамрах вэ гэдэгт эртнээс одоог хүртэл эцсийн нэг ойлголтод хүрээгүй байгаа ч орчин үед Худалдааны эрх зүй гэдэгт аж ахуйн нэгжийн бүтэц, үйл ажиллагаа гэсэн талаас нь аж ахуйн нэгжийн эрх зүйг хамааруулан авч үзэх Аж ахуйн нэгжийн эрх зүйн тайлбарын онол давамгайлж байна. Дээрх тайлбарын онолоос үзэхэд аж ахуйн нэгж гэдэг нь “үргэлжилсэн шинжтэй, тодорхой төлөвлөгөөний үндсэн дээр ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн бие даасан нэгж” гэж тайлбарладаг бөгөөд аж ахуйн нэгж дээр төвлөрч тэдгээрийн хоорондох харилцаа, эдийн засгийн ашиг, эрсдэлийг зохицуулах зорилгоор Худалдааны хууль оршдог гэж үздэг.

Энэ утгаараа Худалдааны хуулиас гадна Компанийн хууль, Даатгалын хууль, Чек векселийн тухай хууль, Далайн тээврийн тухай хууль зэрэг тусгай хуулиуд ч Материаллаг худалдааны эрх зүй гэдэгт хамаарч байдаг. Аж ахуй эрхлэгчдийн хоорондын харилцааг жирийн иргэдийн харилцаатай хамтад нь Иргэний хуулиар хангалттай зохицуулж болох ч аж ахуйн эрх зүй гэдэг утгаараа тусгай онцлог шинжүүдтэй байдаг тул дан ганц Иргэний хуулиар зохицуулах нь хангалтгүй бөгөөд тохиромжгүй.

3.2. Худалдааны эрх зүйн байр суурь

Иргэний хууль нь иргэдийн өдөр тутмын амьдрал, эдийн засагтай холбоотой харилцааг зохицуулдаг хувийн эрх зүйн салбарын гол хууль бөгөөд Худалдааны хууль нь аж ахуй эрхлэгчдийн харилцааг тусгайлан зохицуулдаг гэдэг утгаараа аж ахуй эрхлэгчтэй холбоотой асуудлыг зохицуулахад Худалдааны хууль давуу эрхтэйгээр үйлчилдэг ба Худалдааны хуулиар зохицуулагдаагүй харилцааг нөхөх байдлаар Иргэний хууль зохицуулдаг. Тухайлбал зээлийн харилцаанд Иргэний хуульд хуулиар тогтоосон зээлийн жилийн хүү 5 хувь (Иргэний хуулийн 404 дүгээр зүйл) байхаар заасан бол Худалдааны хуульд жилийн 6 хувь (Худалдааны хууль 514 дүгээр зүйл) байх ба тус зээлийн харилцаа нь аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой байсан бол Худалдааны хуулиар зохицуулагдана. Энэ утгаараа Иргэний хууль болон Худалдааны хууль нь ерөнхий ба тусгай хуулийн харилцан хамаарлаар оршдог.

Нөгөө талаар аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хувийн эрх зүйн дэг журам болон харилцан хамаарлыг хадгалах, иргэдийн эдийн засгийн байр суурт талаас нь аж ахуй эрхлэгчтэй хэрхэн харилцах харилцааг зохицуулах, Шударга бус өрсөлдөөнийг хориглох хууль болон сүүлийн үед олноор нэмэгдэж буй Банкны тухай хууль, Даатгалын үйл ажиллагааны тухай хууль зэрэг бизнесийн үйл ажиллагаа тус бүрийг зохицуулсан эдийн засгийн эрх зүйд хамаарах хуулиуд, аж ахуйн нэгжид ажиллах ажиллах хүч буюу

ажилтны хамгаалах зорилго бүхий Хөдөлмөрийн хууль зэрэг олон салбарын хуулиуд нь Материаллаг худалдааны эрх зүйтэй хэрхэн системчлэгдэх вэ гэдэг нь ирээдүйд анхаарлаа хандуулах шаардлагатай асуудал юм.

3.3. Худалдааны эрх зүйн онцлог

Өмнө нь дурдсанчлан аж ахуй эрхлэгчийн харилцааг Иргэний хуулиар зохицуулах нь хангалтгүй бөгөөд тохиромжгүй гэсний учир нь Худалдааны эрх зүй нь дараах гол онцлог шинжүүдтэй холбоотой юм.

А. Аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой онцлог

1. Аж ахуйн үйл ажиллагаа гэдэг нь аль болох боломжит дээд хэмжээний ашиг олох зорилготой тул аж ахуй эрхэлж буй худалдаачны үйл ажиллагаа нь зарчмын хувьд нэмэлт орлого олоход чиглэдэг (Худалдааны хуулийн 512 дугаар зүйл) ба дээр дурдсан Худалдааны хуульд заасан хүүгийн хэмжээ Иргэний хуульд заасан хүүгээс илүү байгаа зэрэг нь аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөө гэсэн зарчимд үндэслэгддэг.

2. Аж ахуйн үйл ажиллагааг зохистой явуулахад худалдааг түргэн шуурхай явуулах шаардлагаар Худалдааны хуулиар гэрээ байгуулах санал, түүнийг хүлээн зөвшөөрөх саналыг түргэн шуурхай зохицуулах (Худалдааны хуулийн 507 дугаар зүйл хүртэл), хөөн хэлэлцэх хугацааг Иргэний хуульд 10 жил (Иргэний хуулийн 167 дугаар зүйл) байхаар заасан бол Худалдааны хуульд 5 жил (Худалдааны хуулийн 522 дугаар зүйл) байхаар тогтоосон зэрэг бизнес эрхлэгчдийн харилцааг хялбар бөгөөд түргэн шуурхай байлгах тусгай зохицуулалтыг тусгадаг.

3. Их хэмжээний худалдааны ажиллагааг үр дүнтэй удирдахын тулд аж ахуйн холбоотой харилцааг хэлбэршүүлэх нь оновчтой байдаг. Тухайлбал хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн нэрсийг бүртгэдэг, жагсаалт хөтөлдөг зэрэг хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн тогтолцоо зэрэг нь үүний илрэл юм. Мөн цаашид авч үзэх ердийн гэрээний стандарт нөхцөлийг мөн хэлбэршүүлэхийг шаарддаг.

4. Худалдааны хуулиар аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой нөхцөлүүдийг бүртгэх, түүнийг нийтэд нээлттэй мэдээлэх зэргээр худалдааны нөгөө талыг хохирол учрахаас сэргийлдэг (Нээлттэй байх зарчим). Мөн гадаад ирэлхийлэл, хэлбэр нь бодит агуулгатай нийцэхгүй тохиолдолд гадаад хэлбэрт итгэсэн этгээдийг хамгаалах зохицуулалтыг тусгадаг (Итгэлийг хамгаалах зарчим).

5. Аж ахуйн үйл ажиллагаа нь зохистой шаардлагыг хангасан санхүүгийн тооцоонд үндэслэж явагдах учраас талууд өөрсдийн чөлөөт хүсэл зоригт үндэслэж гэрээ байгуулах боловч талуудын хоорондын ашиг алдагдлын харьцаа зохистой байх ёстой. Тиймээс худалдаатай холбоотой Худалдааны эрх зүйн зохицуулалт нь талуудын хоорондын хүсэл зориг байхгүй тохиолдолд нөхөж зохицуулах замаар үйлчилдэг ба өөрөөр хэлбэл сайн дурын зохицуулалт олон байдаг.

6. Худалдаа хийж буй аль нэг тал нь өөрсдийн олохоор тооцсон эдийн засгийн үр өгөөжийг эрсдэлээс хамгаалахын тулд Худалдааны хуулиар аж ахуй эрхлэгчийн хариуцлагыг чангатгах зохицуулалтыг тусгадаг.

Б. Аж ахуйн нэгжтэй холбоотой онцлог

1. Аж ахуйн үйл ажиллагаа нь эдийн засгийн харилцаанд амжилттай оролцоход тулд зайлшгүй хөрөнгө оруулалт шаардлагатай учир Худалдааны хуулиар компанийн

тогтолцоо, бүртгэгдээгүй холбооны тогтолцоо зэргийг ашиглаж аж ахуй эрхлэхэд шаардлагатай хөрөнгийг бусдаас татан төвлөрүүлэх боломжийг олгодог.

2. Аж ахуйн үйл ажиллагаа нь алдагдал хүлээх эрсдэл ихтэй байдаг тул хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын тогтолцоо, хохирлын даатгалын тогтолцоо зэрэг эрсдлийг сарниулах олон тогтолцоог тусгасан байдаг.

3. Аж ахуйн үйл ажиллагаа явуулахад түүнийг гүйцэтгэх хөдөлмөрлөх хүч зайлшгүй шаардлагатай тул тэдгээрийг зохицуулсан худалдааны ажилтан, төлөөлөгч, зуучлагч, усан онгоцны ахмад зэрэг тогтолцоог хамааруулан зохицуулдаг.

4. Эцэст нь нэгэнт бүрэлдэн бий болсон аж ахуйн нэгжийг тарж бутрахаас сэргийлэх, менежментийг үр дүнтэй явуулж аж ахуйн нэгжийг бэхжүүлэх, үйл ажиллагаагаа шилжүүлэх, компаниуд нэгдэх, хуваагдах, хувьцаа солилцох, шилжүүлэх зэрэг олон тогтолцоог Худалдааны хуулиар зохицуулдаг.

Дээр дурдсанчлан Япон улсын хувьд Худалдааны хууль нь хувийн эрх зүйн салбарт хамаарах тусгай хууль тул түүнийг хэрэгжүүлэх, үүссэн хэрэг маргааныг шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна.

Хоёр. Худалдааны эрх зүйн эх сурвалж, хуулийн үйлчлэх эрэмбэ

1. Аж ахуйн харилцаанд үйлчлэх хууль

Бидний өдөр тутмын амьдралд маргаан үүсч шүүхээр шийдвэрлэгдэх тохиолдолд талуудын хооронд ямар нэгэн тохиролцоо байхгүй байсан ч шүүх хэргийг шийдвэрлэхийн тулд ашиглах хэм хэмжээг эрх зүйн эх сурвалж гэдэг. Аж ахуй эрхлэгчдийн хоорондын харилцааны эрх зүйн эх сурвалж нь Худалдааны хууль ба олон улсын гэрээ, худалдааны заншлын хэм хэмжээ байдаг.

1.1. Төрөлжсөн Худалдааны хууль

Япон улсын Худалдааны хууль нь ерөнхий анги, худалдааны хэлцэл, далайн худалдаа гэсэн 3 үндсэн хэгээс бүрдэнэ. Худалдааны хуулийг батлах үед Худалдааны хуульд компани, векселтэй холбоотой зохицуулалтыг нэг үндсэн бүлэг болгон хуульчилсан байсан ч Женевийн конвенцид нэгдэн орсонтой холбоотойгоор Шёвагийн 7 (1932) дугаар онд Векселийн тухай хууль, Чекийн тухай бие даасан төрөлжсөн хууль баталснаар Худалдааны хууль дахь чек, векселтэй холбоотой бүлгүүд хүчингүй болсон. Дараагаар нь Хэйсэй 17 (2005) дугаар онд компанийн зохицуулалтыг салгаж бие даасан хууль болгосноор мөн Худалдааны хууль дахь Компанийн эрх зүйн бүлгийг хүчингүй болгосон. Хэйсэй 20 (2008) дугаар онд Даатгалын тухай бие даасан хуулийг баталж хэрэгжүүлснээр Худалдааны хууль дахь даатгалын бүлгийг хүчингүй болгосон. Энэ мэтчилэн Худалдааны хууль, Компанийн хууль, Векселийн тухай хууль, Чекийн тухай хуулиас гадна Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн хууль, Өрийн бичиг, компанийн хувьцааг солих тухай хууль, Өрийн бичгийн барьцааны итгэмжлэлийн тухай хууль, Олон улсын далайгаар бараа бүтээгдэхүүн тээвэрлэх тухай хууль зэрэг олон тусгай хуулиудыг баталсан байна.

1.2. Худалдааны заншлын эрх зүй

Нийгмийн амьдрал дунд удаан хугацаанд үргэлжлэн тогтсон тодорхой хэмжээнд хүмүүс түүнийг даган мөрдөх шинжтэй болсон хэм хэмжээг заншил гэх ба заншил нь өргөн хүрээнд нийгмийн оролцогчдоор хүлээн зөвшөөрөгдснөөр заншлын хэм хэмжээ

бий болдог. Ялангуяа аж ахуйн нэгжийн харилцаанд тус заншлын хэм хэмжээ олноор бүрэлдэн бий болж, эрх зүйн эх сурвалжийн хувьд чухал үүргийг гүйцэтгэдэг.

1.3. Нийтлэг худалдааны стандарт нөхцөл

Худалдаа хэлбэржих шаардлагаас үүдэн банкны худалдаа, даатгалын худалдаа, тээвэрлэлт зэрэг салбарт аж ахуйн нэгжийн зүгээс гэрээний агуулгыг маш тодорхой тодорхойлсон стандарт нөхцөлийг боловсруулж, аж ахуйн нэгжтэй худалдааны харилцаанд орж буй хэнтэй ч тус нөхцөлөөр гэрээ байгуулахыг шаарддаг. Иргэдийн хувьд тус харилцаанд орохдоо тэр бүр түүний агуулгыг хайхардаггүй худалдаа хийдэг. Угтаа гэрээ нь талуудын хоорондын хүсэл зориг нэгдээгүй нөхцөлүүд нь эрх зүйн үр дагавар үүсгэхгүй байх ёстой боловч ямар нэгэн маргаан гарсан бол шүүх зарчмын хувьд гэрээний стандарт нөхцөлийг хэрэглэдэг. Гэрээний стандарт нөхцөлийг мэдээгүй талд ч тус нөхцөл үйлчлэх эсэх тухайд тухайн салбарын худалдаанд нийтлэг стандарт нөхцөлийг ашигласан тохиолдолд тухайн салбарын худалдаанд стандарт нөхцөлөөр гэрээ байгуулагдсан гэж үзэх хандага байдаг ч аль ч тохиолдолд гэрээний стандарт нөхцөл нь өөрөө гэрээ болох тул эрх зүйн эх сурвалж гэж үзэхгүй.

Өнөөгийн нийгэмд ердийн худалдааны стандарт нөхцөлийн агуулга нь шударга бөгөөд хэрэглэгчид ямар нэгэн хор уршиг учруулахгүй байх зэргийг шалгах нь чухал сэдэв болж байна.

2. Худалдааны хуулийн үйлчлэлийн эрэмбэ

Худалдааны хууль нь аж ахуй эрхлэгчдийн харицлааг зохицуулсан хууль болохын хувьд худалдааны эрх зүй дэх олон систем нь аж ахуйн харилцаанд зориулагдсан байдаг ч яг ямар харилцаанд Худалдааны хууль үйлчлэх тухайд эрх зүйн зөрчилдөөнтэй асуудал байдаг.

Тухайлбал А нь Б-ээс мөнгө зээлсэн тохиолдолд хууиар тогтоосон хүү болон хөөн хэлэлцэх хугацааны хувьд Иргэний хууль Худалдааны хуулиуд ялгаатай байдаг тул аль зохицуулалт нь үйлчлэх вэ? эсхүл нэгэн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг С-д худалдааны үйлажиллагааны бүртгэл, худалдааны нэр, худалдааны ажилтан зэрэг Иргэний хуулийн бус зөвхөн Худалдааны хуулийн бие даасан систем үйлчлэх үү гэх зэрэг нь талуудын хооронд чухал асуудал болдог. Худалдааны хуулиар аж ахуй эрхлэгч субъектийг худалдаа эрхлэгч, аж ахуй эрхлэгчдийн хоорондын худалдааг худалдааны хэлцэл гэж тодрохойлж, худалдаа эрхлэгч ба худалдааны хэлцэл гэх хоёр үндсэн ойлголтыг Худалдааны хуулийн зохицуулах зүйл гэж үздэг. Өөрөөр хэлбэл, Худалдааны хууль нь худалдаа эрхлэгч хоорондын харицлаа болон худалдааны хэлцэлтэй холбоотой харилцаагаар Иргэний хуулиас ялгарах, мөн Иргэний хуульд байхгүй тусгай зохицуулалтыг тусгасан байдаг. Дээрх жишээнд А Б-ийн хооронд мөнгө зээлэх нь А мөн Б-ийн аль нэгний хувьд худалдааны хэлцэл байвал хуулиар тогтоосон хүү, хөөн хэлэлцэх хугацаа зэрэгт Худалдааны хуулийн зохицуулалтыг дагах ёстой. С нь худалдаа эрхлэгч бол худалдааны үйл ажиллагааны бүртгэл зэргийг шаардана.

Тусгай хууль нь ерөнхий хуулиас давуу үйлчлэх зарчмаар Худалдааны хууль нь Иргэний хуулиас давуу хүчинтэйгээр үйлчилж, Компанийн хууль, Векселийн хууль, Олон улсын далайн тээврийн хууль зэрэг нь худалдааны эрх зүйн тусгай хууль учир Худалдааны хуулиас давуу хүчинтэйгээр үйлчилдэг. Мөн хуулийн үйлчлэлийн нийтлэг зарчмын дагуу заншлын хэм хэмжээ, бичмэл хуулийн зохицуулалтын хооронд бичмэл хууль нь давуу хүчинтэй байна (Хууль тогтоомжийн үйлчлэлтэй холбоотой нийтлэг

журмын тухай хууль 3 дугаар зүйл). Гэтэл Худалдааны эрх зүйн салбарт Худалдааны хууль нь худалдааны заншлаас давуу хүчинтэй бол худалдааны заншил нь бичмэл хууль болох Иргэний хуулиас давуу хүчинтэйгээр үйлчилдэг (Худалдааны хууль 1.2 зүйл). Энэ нь аж ахуйн харилцааг зохицуулдаг хэм хэмжээ нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдөж байдаг тул хатуу тогтоосон бичмэл хуулийн хэм хэмжээ нь зохицуулалтын хувьд хангалтгүй болж нийгмийн цаг үеэсээ хоцрох явдал цөөнгүй ба ялангуяа өдөр тутмын харилцааг зохицуулах Иргэний хуультай харилцан хамаарлын хувьд энэ нь маш том асуудлыг бий болгодогт оршдог. Түүнчлэн Худалдааны хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт “Худалдааны талаар тус хуульд тусгайлан зохицуулаагүй харилцааны хувьд худалдааны заншлын дагуу, худалдааны заншил байхгүй тохиолдолд иргэний хуулийг дагаж мөрдөнө” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, Худалдааны хуульд ямар нэгэн зохицуулалт байхгүй тохиолдолд, худалдааны заншлыг хэрэглэж, худалдааны заншил байхгүй тохиолдолд иргэний хуулийн хэм хэмжээг тохируулан хэрэглэнэ гэсэн үг.

Худалдааны хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсгийн дагуу, Худалдааны хуульд ямар нэгэн зохицуулалт байхгүй тохиолдолд ч гэсэн Иргэний хуулийн зохицуулалтыг шууд хэрэглэх боломжгүй буюу Иргэний хуульд ямар нэгэн зохицуулалт байхгүй тохиолдлоос гадна Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байлаа ч гэсэн Худалдааны заншлын эрх зүйн хэм хэмжээг тэргүүн ээлжинд хэрэглэх болно.

Түүнчлэн энэ талаар “1. Япон улсын Худалдааны эрх зүйн байр суурь” гэсэн хэсэгт тайлбарласанчлан Худалдааны хуулийн зохицуулалтын объект болох аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь өдөр тутам зогсолтгүй өөрчлөгдөн шинэчлэгдсээр байдаг учир, Худалдааны хуулийн хэм хэмжээг ч гэсэн ойр ойрхон өөрчилж, шинэчлэх хэрэгцээ, шаардлага бий болдог билээ. Энэ динамик шинжийг нь гол болговол Худалдааны заншлын эрх зүйн хэм хэмжээг Иргэний хуулиас тэргүүн ээлжинд хэрэглэхээр хуульчилсан Худалдааны хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсгийн заалтын агуулгыг зохистой гэж дүгнэх боломжтой юм.

Гэвч Худалдааны хуулийн 1-р зүйлийн 2 дахь заалтад Худалдааны заншлын эрх зүйн хэм хэмжээ нь бичмэл хууль болох Иргэний хуулиас тэргүүн ээлжинд хэрэглэгдэхээр зохицуулсан нь Хуулийг хэрэглэх тухай хуулийн 3-р зүйлд заасны дагуу хууль нь заншлаас тэргүүн ээлжинд хэрэглэгдэнэ гэж зохицуулсан хэм хэмжээтэй хоорондоо зөрчилдөж буй мэт харагдана. Гэвч энэ талаар Япон улс дахь нийтлэг тайлбарын хувьд Худалдааны заншлын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх тухай Худалдааны хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт зохицуулсан байх тул Хуулийг хэрэглэх тухай хуулийн 3-р зүйлд заасан “хууль тогтоомжид тухайн заншлыг хэрэглэхийг хүлээн зөвшөөрсөн тухай тусгайлан зохицуулсан” гэх урьдчилсан нөхцлийг хангах бөгөөд “хуулийн нэгэн адил үр дагавартай” байна гэж тайлбарладаг.

Тиймээс ч Худалдааны заншлын эрх зүйн хэм хэмжээ нь Иргэний хуулиас тэргүүнд ээлжинд хэрэглэгдэх тухайд энэ нь тусгай хуулийн зохицуулалт нь ерөнхий хуулийн зохицуулалтаас тэргүүн ээлжинд хэрэглэгдэнэ гэсэн ерөнхий зарчимд нийцэх учраас дээр дурьдсан хоёр хуулийн хооронд ямар нэгэн зөрчил үүсээгүй гэж дүгнэх боломжтой юм.

2.4 БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ХУДАЛДАА (АРИЛЖАА)-НЫ ЭРХ ЗҮЙ³⁵

Удиртгал

Францын эрх зүйн тогтолцоонд худалдааны эрх зүйг худалдаа эрхлэгч болон худалдааны үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулдаг хувийн эрх зүйн нэг салбар гэж тодорхойлсон байдаг.³⁶

Хувийн салбар эрх зүй болох тухайд: Францын худалдааны эрх зүй нь иргэн, хуулийн этгээд буюу хувь этгээдийн хоорондын харилцааг зохицуулахад чиглэдгээрээ хувийн салбар эрх зүй болох нь маргаангүй боловч мөн татварын эрх зүй, худалдааны байгууллагын эрх зүй гэх мэт нийтийн эрх зүйд хамаарах зохицуулалтыг багтаасан байдгаараа онцлогтой.

Холимог тогтолцоо бүхий эрх зүй болох нь: Худалдааны эрх зүйн үйлчлэх хүрээ, хамрах асуудлыг тодорхойлохдоо субъектив (худалдаа эрхлэгч) ба объектив (худалдааны хэлцэл) шалгуурыг хослуулан хэрэглэдэг тул Францын худалдааны эрх зүйг холимог тогтолцоотой гэж үзэх үндэслэлтэй. Худалдааны эрх зүй нь анх үүсэж хөгжихдөө юуны өмнө худалдаачдын харилцааг зохицуулахад чиглэж байсан бөгөөд үүнээс улбаалан өнөөгийн Францын худалдааны эрх зүй нь субъектив шалгуурыг хадгалсан байдаг. Мөн 1789 оны хувьсгалаас хойш худалдааны эрх зүйн үйлчлэх хүрээг тодорхойлохдоо худалдааны хэлцэл, худалдааны үйл ажиллагааны төрөлд үндэслэдэг объектив үзэл баримтлал хөгжиж ирсэн байна.

1. Орчин үеийн Францын эрх зүйн тогтолцооны үүсэл

Францын хувьсгалын дараа Наполеон улсаа шинээр хөгжүүлэх зорилгоор 1804-1811 онд Иргэний хууль, Худалдааны хууль (*Code de commerce*), Иргэний процессын хууль, Эрүүгийн хууль болон Эрүүгийн процессын хууль хэмээх 5 хуулийн төслийг боловсруулуулж, батлуулжээ.

Францын хувьсгалын өмнө тус улсын газар нутаг дээр бүх нийтэд адил тэгш үйлчилдэг нэгдсэн хэм хэмжээ бүхий Францын эрх зүйн тогтолцоо гэж байгаагүй буюу бүх мужууд өөрийн заншлын эрх зүйг хэрэглэдэг байсан бөгөөд зарим салбарт хааны эрх мэдлийн хүрээнд зарлигаар тогтоосон журам үйлчилдэг байв. Мөн Ромын эрх зүй, каноны эрх зүй, болон католик сүмийн эрх зүй чухал нөлөө үзүүлдэг байжээ. Францад хийгдсэн кодификацийн дүнд олон мужийн эрх зүйн уламжлалыг нэгтгэн, улс хоорондын томоохон хоёр эрх зүйн систем болох Ромын эрх зүй болон каноны эрх зүйгээс эрх зүйн шинэ систем болох францын эрх зүйн тогтолцоо бий болжээ.

Францын эрх зүй систем нь эх газрын Европт үндэсний эрх зүйн системийг бий болгосон төдийгүй энэ нь улс төрийн хандлага, үндэсний тусгаар тогтнол, улс бие даасан өөрийн хуультай байх эхлэлийг тавьжээ.³⁷

³⁵ “Харьцуулсан Худалдааны эрх зүй” номын хэсэг болох МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Б.Буянхишиг, магистрант С.Баяржаргал, МУИС-ийн ХЗС-ийн захирлын туслах Д.Булган нарын бичсэн хэсгээс ишлэв.

³⁶ *Michel Pédamon, Hugues Kenfack, Droit commercial, p.1 (2015); Georges Decocq, Aurélie Ballot-Léna, Droit commercial, p.7 (2013).*

³⁷ Springer, *The Scope and Structure of Civil Codes*, 2012, P 181-182

2. Францын худалдааны эрх зүйн үүсэл, түүхэн уламжлал

2.1. Худалдааны эрх зүй дундад зуунд бүрэлдэн хөгжсөн нь

Банкны хэлцэл, вексель, дамбуурлын механизм зэрэг орчин үеийн худалдааны эрх зүйн зарим ойлголт, ухагдахуун нь Европт дундад зуунд үүсч бий болжээ. XII-XIII зуунд Италийн хойд хэсэгт далайн худалдаа цэцэглэн хөгжиж, мөн баруун Европын нутаг дэвсгэр дээр яармаг худалдаа тогтмол зохион байгуулагддаг байсан нь иргэний эрх зүйгээс ялгаатай зохицуулалт бүхий худалдааны эрх зүй бүрэлдэн бий болоход нөлөөлсөн гэж үздэг.

Франц улсад XIII зуунаас худалдааг суурьшмал хэлбэрээр эрхлэх болсон бөгөөд үүнийг даган хот суурин газар хөгжиж эхэлсэн байна. Худалдаачид, гар урлал эрхлэгчид тодорхой дүрэм, журам, зохицуулалт бүхий хаалттай нэгдэл (*'corporation'*) хэлбэрээр зохион байгуулагдан худалдаа эрхэлж байсан нь Францын хувьсгал хүртэл үргэлжилсэн байна.

2.2. Дундад зууны үеэс XVIII зуун хүртэлх үеийн худалдааны эрх зүй

Энэ үед худалдааны эрх зүй шинэ шатанд хөгжихөд шинээр нээсэн тивүүдээс алт, мөнгө зэрэг үнэт металл олборлох болж, хаант засгийн үйлдвэрийн газрууд бий болсон зэрэг эдийн засгийн хүчин зүйлсээс гадна улс төрийн хүчин зүйлс нөлөөлсөн байна. Хаант засаглал бэхжин хөгжиж, орчин үеийн төрт улс үүсэж бий болсноор өөрийн гэсэн хууль тогтоомж батлах болжээ. Энэ хүрээнд худалдаатай холбоотой хэд хэдэн зарлиг гаргаснаас дурдвал Парисийн шүүх байгуулах тухай зарлиг³⁸ (1563), Савари хууль гэгдэх худалдааны тухай зарлиг³⁹ (1673), далайн тээвэр, худалдааны тухай зарлиг⁴⁰ (1681) болно. Тухайлбал Савари хуульд худалдааны мэргэжил, худалдааны компани, дамбуурал, худалдааны шүүхийн талаар зохицуулалт тусгасан байжээ.

2.3. Францын хувьсгалын нөлөө

Хаант засгийн үеийн үндсэн хууль тогтоомж болох дээр дурдсан Савари хууль, Далайн худалдааны тухай зарлигийг Францын хувьсгалын (1789-1799) үед хэвээр хадгалан мөрдөж байжээ. Худалдааны шүүхийн тогтолцоог мөн хэвээр үлдээсэн байна.

Хүний эрх, эрх чөлөөг тунхагласан хувьсгалын жилүүдэд эдийн засгийн эрх чөлөө гэсэн ойлголт бий болж⁴¹ улмаар хаалттай нэгдэл (*'corporation'*) хэлбэрээр худалдаа эрхэлдэг тогтолцоог халж, өнөөгийн Францын худалдааны эрх зүйн үндсэн зарчмуудын нэгд тооцогддог худалдаа, аж үйлдвэрийн чөлөөт байдлын зарчмыг⁴² тунхагласан байна. Физиократ эдийн засагчдын онолын нөлөөгөөр баталсан гэгдэх уг зарчим нь аливаа этгээд эрхлэн явуулах худалдаа, аж ахуйг чөлөөтэй сонгох эрх чөлөө, сонгосон худалдаа, аж ахуйгаа чөлөөтэй удирдан явуулах эрх чөлөө гэсэн хоёр төрлийн эрх чөлөөг ерөнхийдөө илэрхийлдэг.

³⁸ Edit de 1563

³⁹ Ordonnance de 1673 sur le commerce de terre (Code Savary)

⁴⁰ Ordonnance de 1681 sur la marine

⁴¹ Carole Champalaune, Le principe de la liberté du commerce et de l'industrie et de la libre concurrence, Францын Дээд Шүүхийн тайланд нийтлүүлсэн нийтлэл (2001): <https://www.courdecassation.fr>

⁴² 1791 оны 3 сарын 2-17-ны хуулиар тунхагласан

2.4. Анхны Худалдааны хууль баталсан нь⁴³ (1807⁴⁴)

Францын анхны худалдааны хуулийг эзэн хаан Наполеон Бонапартын үед буюу 1807 онд баталсан бөгөөд ингэхдээ өмнөх хаант засгийн үед мөрдөж байсан хууль тогтоомжоос (1) тодорхой хэмжээгээр санаа аван боловсруулсан байдаг (2). Уг хууль нь 2000 он хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдсөн байна (3).

(1) 1807 оны Худалдааны хууль батлагдахаас өмнө үйлчилж байсан хууль тогтоомж

1807 оны Худалдааны хуулийг батлахаас өмнө худалдааны зан заншлаас гадна дээр дурдсан хааны сайд Колбертын санаачилснаар Людовик XIV хааны гаргасан хоёр зарлигийг⁴⁵ үндсэндээ дагаж мөрдөж байжээ. Түүнчлэн 1807 оны Худалдааны хуулийг боловсруулахдаа эдгээр зарлигийн нэг болох 122 зүйл бүхий Газрын худалдааны тухай хааны зарлигт үндэслэж, гол заалтуудыг авч тусгасан байдаг.

(2) 1807 оны Худалдааны хуулийг боловсруулж баталсан нь

Францын эзэн хаан Наполеон Бонапарт XIX зууны эхээр Францын эрх зүйн салбарт томоохон шинэчлэл хийж, хэд хэдэн хуулийг боловсруулан батлуулсны нэг нь 1807 оны Худалдааны хууль юм.

Худалдааны хууль⁴⁶ нь нийт 648 зүйл бүхий дараах 4 дэвтрээс бүрдэж байжээ. Үүнд:

Дэвтэр I : Худалдааны тухай ерөнхий зүйл;

Дэвтэр II : Далайн худалдааны тухай ;

Дэвтэр III : Төлбөрийн чадваргүй болох ба дампуурал;

Дэвтэр IV : Худалдааны хэргийн шүүх.

(3) 1807 оны Худалдааны хуулийн хэрэгжилт

Хэдийгээр 1807 оны Худалдааны хуулийг агуулгын хувьд хязгаарлагдмал, хэлбэрийн хувьд ч дутмаг, хэт яаравчлан баталсан, өмнөх үеийн хууль тогтоомжийг давтсан төдий зэргээр шүүмжилсэн байдаг ч дэлхийн бусад улс орнуудын худалдааны эрх зүйн хөгжилд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үздэг.⁴⁷

Агуулгын хувьд Худалдааны хуулийн ихэнх хэсэг нь өмнөх хаант засаглалын үед мөрдөж байсан хууль тогтоомжоос бүрдэж байсан тул XIX зууны аж үйлдвэрийн хувьсгалын үеэр эдийн засаг, худалдаа эрчимтэй хөгжиж эхэлмэгц уг хууль илт хоцрогдож, шинээр үүссэн эдийн засаг, худалдааны харилцааг зохицуулахад хангалтгүй болсон байна. Иймээс Худалдааны хуулийг нөхөх зорилгоор олон шинэ салангид

⁴³ Худалдааны хууль (Code de commerce)-ийг кодификаци (төрөлжүүлэн эмхэтгэх) хэлбэрээр баталсан байна.

⁴⁴ 1808 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлжээ.

⁴⁵ Газрын худалдаа (1673) болон Далайн худалдааны тухай зарлиг (1681)

⁴⁶ 1807 оны Худалдааны хуулийн эх хувилбартай дараах холбоосоор орж танилцах боломжтой: <http://gallica.bnf.fr/ark:/12148/bpt6k56629t.textelimage>

⁴⁷ Тухайлбал, ХБНГУ, Швейцарь, Нидерланд, Итали, Канадын Кебек муж, Бразил зэрэг улсууд уг хуулийн нөлөөг тодорхой хэмжээгээр авсан гэгддэг.

хуулиудыг тухайлбал Чекийн тухай хууль (1865), Хувьцаат компанийн тухай хууль (1867), Худалдааны эд хөрөнгийн тухай хууль (1909)-ийг тус тус баталж мөрдөж ирсэн байна. Эдгээр хуулийг Худалдааны хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар тусгаж оруулалгүйгээр тусад нь мөрдөж иржээ. XIX зууны аж үйлдвэрийн хувьсгалын дараа XX зуунд нийгэм, улс төр, эдийн засгийн олон хүчин зүйлсийн улмаас худалдааны эрх зүйн салбар ихээхэн хувьсаж өөрчлөгдсөн.

Ингэснээр Худалдааны хууль аажмаар ач холбогдлоо алдаж, анх 648 зүйлтэй байсан бол 2000-аад оны үед зөвхөн 140 орчим зүйл заалт нь хүчин төгөлдөр үйлчилж, түүнээс гагцхүү 30 орчим нь л анхны хувилбараа хадгалан үлдсэн байжээ.⁴⁸ Иймд хуулийг дахин шинэчилж батлах нөхцөл шаардлага бий болсноор 2000 онд Худалдааны хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан байна.

2.5 Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Худалдааны хууль (2000)⁴⁹

Худалдааны хуулийн шинэчилсэн найруулгыг 2000 онд баталсны (1) гол зорилго нь Худалдааны хуулиас тусад нь баталж хэрэгжүүлж ирсэн олон тархай бутархай хуулиудыг нэгтгэн эмхэтгэж нэг хууль болгон батлахад оршиж байжээ. Ингэснээр өмнөх 1807 оны хуультай харьцуулбал агуулгын хувьд илүү өргөн хүрээг хамарсан байна (2).

(1) 2000 оны Худалдааны хуулийг баталсан нь

Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хууль тогтоомжид онцын өөрчлөлт оруулалгүйгээр нэр томьёо, зүйл заалтын дугаарлалтыг өөрчлөн, ангилан зохион байгуулах замаар 2000 оны Худалдааны хуулийг баталсан байна. Ийнхүү баталсан нь ихээхэн шүүмжлэл дагуулсан байдаг.⁵⁰ Тухайлбал:

- Субъектив эсвэл объектив ойлголтын аль нэг дээр тулгуурлан онолын түвшинд бүрэн хэмжээнд авч үзээгүй.
- Зөвхөн худалдаа эрхлэгчдэд үйлчилдэг зохицуулалтыг худалдаа эрхлэгч болон худалдаа эрхлэгч бус этгээдэд нийтлэг үйлчилдэг зохицуулалттай хольсон.
- Иргэний шинж чанартай үйл ажиллагаа эрхэлдэг этгээд (худалдааны зуучлагч (agents commerciaux), шүүхийн администратор зэрэг)-д үйлчлэх зохицуулалт нилээдгүй тусгасан.
- Худалдаа, аж үйлдвэрийн чөлөөт байдлын зарчмыг дурдаагүй.
- Чек зэрэг зарим төлбөрийн хэрэгслийн талаар зохицуулалт оруулаагүй.
- Банкны үйл ажиллагаа нь худалдааны хэлцэлд тооцогддог байтал энэ талаар зохицуулалт оруулаагүй.⁵¹
- Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоос ялгарах заагийг нарийн тогтоогоогүй гэх мэт.

(2) 2000 оны Худалдааны хуулийн бүтэц

⁴⁸ Michel Pédamon, Hugues Kenfack, Droit commercial, p.7 (2015);

⁴⁹ 2000 оны 9 дүгээр сарын 18-ны нО2000-912 тоот ордоннас (хуульчилсан акт)-аар баталсан байдаг. Энэхүү хуулийн Засгийн газрын тогтоолоор баталсан хэсгийг 2007 онд баталсан байна.

⁵⁰ D.Bureau, N.Molfessis, "Le nouveau code de commerce ? Une mystification" (2001)

⁵¹ Банкны үйл ажиллагааг Францын Мөнгө, санхүүгийн тухай хуулиар (Code monétaire et financier) зохицуулсан байдаг.

Эдүгээ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Худалдааны хууль ⁵² нь хуулийн хэсэг, тогтоолын хэсэг гэсэн хоёр хэсэгтэй бөгөөд нийт 9 дэвтрээс бүрддэг. Үүнд:

- Дэвтэр I : Худалдааны тухай ерөнхий зүйл;
- Дэвтэр II: Худалдааны компани болон эдийн засгийн ашиг сонирхол бүхий нэгдлийн тухай;
- Дэвтэр III: Худалдааны зарим хэлбэр болон онцгой эрхийн заалтын тухай;
- Дэвтэр IV: Үнийн чөлөөт байдал болон өрсөлдөөний тухай;
- Дэвтэр V: Худалдааны хэрэгсэл болон баталгааны тухай;
- Дэвтэр VI: Аж ахуйн нэгжид тохиолдох хүндрэл, бэрхшээлийн тухай;
- Дэвтэр VII: Худалдааны хэргийн шүүх (трибунал) болон худалдааны зохион байгуулалтын тухай;
- Дэвтэр VIII: Зохицуулалттай мэргэжлийн тухай;
- Дэвтэр XI: Далайн чанадад үйлчлэх зохицуулалт.

Ерөнхий агуулгын хувьд уг хуулиар дараах зургаан үндсэн асуудлыг зохицуулдаг байна. Үүнд:

- (1) Худалдаа эрхлэгч, түүний эрх зүйн байдал, эд хөрөнгө
- (2) Худалдааны компани
- (3) Вексель зэрэг худалдааны хэрэгсэл
- (4) Санхүүгийн хүндрэлтэй компаниудад авах арга хэмжээ
- (5) Худалдааны шүүх
- (6) Шударга өрсөлдөөн.

Францын Худалдааны хуулийн тогтоолын хэсэг (*partie réglementaire*) нь тус улсын Засгийн газраас хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд баталсан тогтоолоос бүрддэг.

3. Худалдааны эрх зүй болон Иргэний эрх зүйн харилцан хамаарал

Францын Иргэний хуулиар худалдааны эрх зүйн асуудлыг зохицуулахыг зорьж байгаагүй. Учир нь Иргэний хуулийн бүрэлдэхүүн хэсэг нь Худалдааны хууль гэдгийг хүлээн зөвшөөрч байсан. Гэхдээ худалдааны хуулийн тодорхой заалтуудыг Иргэний хуультай холбож унших шаардлагатай байдаг. Энэ нь гэрээний харилцаан дээр тодорхой харагддаг. Гэрээний үндсэн зохицуулалтыг Иргэний хуулиар зохицуулсан байдаг бөгөөд Худалдааны хуульд тусгасан худалдааны гэрээтэй холбоотой зохицуулалт нь нэмэлтээр, эсхүл тодорхой асуудлыг зохицуулсан байдаг.

Өмнө нь Иргэний хууль болон Худалдааны хуулийн хоорондын харилцан холбоо тодорхойгүй, эмх цэгцгүй байсан. Энэ нь Худалдааны хуульд декодификаци явагдсантай холбоотой. Тухайлбал, 1980-аад онд худалдааны эрх зүйн ихэнхи асуудлыг худалдааны хуулиас өөр хуулиар зохицуулж, худалдааны хууль хэлбэрийн шинжтэй болсон байсан. Тухайлбал, компани, дампуурлын харилцааг тусдаа хуулиар зохицуулсан байв. Эцэст нь Худалдааны хуулийн төслийг дахин боловсруулах шийдвэр гарч, 2001 онд шинэ худалдааны хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд тус

⁵²Өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Худалдааны хуультай дараах холбоосоор орж танилцах боломжтой:
<https://www.legifrance.gouv.fr/affichCode.do?cidTexte=LEGITEXT000005634379>

хуулиар компанийн эрх зүй, дампуурлын эрх зүй, зээлийн хэрэгслийн тухай, бизнесийн практик, худалдааны олон төрлийн гэрээ зэрэг асуудлыг зохицуулжээ.

Гэвч худалдааны эрх зүйгээс зарим салбар тусгаарлагдсан. Банк болон санхүүгийн зах зээлийн эрх зүйн асуудал нь нарийвчилсан тусдаа хууль болох Мөнгө, санхүүгийн тухай хууль (*Code monétaire et financier*)-иар зохицуулагдах болсон. Зарим орнуудад худалдааны эрх зүйд хамаарагддаг даатгалын эрх зүй нь Франц улсын хувьд мөн худалдааны хууль болох Даатгалын тухай хууль (*Code des assurances*)-иар зохицуулагддаг.

Өргөжин тэлж буй худалдааны эрх зүйн салбар нь салбар эрх зүйн дахин хуваагдах хандлагын тод жишээ болж байна. Үүний зэрэгцээ, нэг талаас иргэний эрх зүй, нөгөө талаас худалдааны эрх зүйн зарим тодорхой салбарын хоорондын уялдаа холбоог илүү нарийвчлах хандлагатай байна. Гэвч иргэний эрх зүй нь эд юмсын эрх зүй болон үүргийн эрх зүйн ерөнхий суурь хэвээр байна.⁵³

4. Худалдааны эрх зүйн эх сурвалж

Худалдааны эрх зүйн эх сурвалжийн онцлог, төрөл. Францын худалдааны эрх зүйн эх сурвалж нь иргэний эрх зүйн эх сурвалжтай адил буюу хууль тогтоомж (2.1), зан заншлын хэм хэмжээ (*usages et coutumes*) (2.2), шүүхийн практик (*jurisprudence*)⁵⁴ (2.3) гэсэн үндсэн эх сурвалжаас бүрддэг.

Иргэний эрх зүйн эх сурвалжаас хэрэглээний хувьд ялгарах онцлог гэвэл худалдааны эрх зүйд зан заншлын хэм хэмжээ онцгой үүрэг гүйцэтгэдгээс гадна тус эрх зүйн салбарт үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудаас гаргасан дүрэм, журам, эрх зүйн акт буюу институтын гаралтай эх сурвалж чухал ач холбогдолтой байдаг (2.4).

4.1. Хууль тогтоомж

Франц улсын худалдааны эрх зүйн хууль тогтоомж нь үндэсний хууль тогтоомжоос (1) гадна олон улсын гэрээ (2), Европын Холбооны эрх зүйн эх сурвалжаас (3) бүрддэг.

(1) Үндэсний хууль тогтоомж

Тус улсын парламентаас баталсан хуулиас (*loi*) гадна Засгийн газрын тогтоол (*décret*)⁵⁵, ордоннанс (*ordonnance*)⁵⁶ нь худалдааны эрх зүйн эх сурвалжид багтдаг⁵⁷. Мөн сайдын тушаал, орон нутгийн байгууллагын шийдвэр зэрэг захиргааны бусад акт худалдааны эх сурвалжид тооцогдоно.

⁵³ Springer, *The Scope and Structure of Civil Codes*, 2012, P 191-192

⁵⁴ *Jurisprudence* гэсэн нэр томъёо нь англи хэл дээрх адил бичигддэг нэр томъёоноос ондоо утгатай бөгөөд шүүхийн практик, шүүхийн зонхилсон шийдвэр гэсэн утгатай.

⁵⁵ Декретиог Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд баталсан декрет буюу бие даасан декрет (*décret autonome*) ба хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн декрет (*décret d'application*) хэмээн ангилдаг байна.

⁵⁶ Энэ нь Францын Үндсэн хуулийн дагуу Парламентын бүрэн эрхэд хамаарах асуудлаар Парламентийн зөвшөөрлөөр Засгийн газраас баталсан акт юм.

⁵⁷ Хууль болон декретээр батлах асуудлын заагийг Үндсэн хуульд (1958) нарийвчлан заасан байдаг байна.

Хууль тогтоомж дундаас Худалдааны хууль нь Францын худалдааны эрх зүйн гол эх сурвалж болдог. Франц нь иргэний хуулиас тусдаа худалдааны хууль баталсан дуалист системтэй зэрэг улсуудын тоонд ордог.⁵⁸

Худалдааны хууль нь дангаараа худалдаа, аж үйлдвэрийн салбарыг бүхэлд нь зохицуулахад хангалттай эх сурвалж болдоггүй бөгөөд тухайн асуудлыг нарийвчлан зохицуулсан худалдааны эрх зүйн эх сурвалж байхгүй тохиолдолд Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг баримтална.⁵⁹ Үндсэн хууль, Иргэний хууль, Худалдааны хуулиас гадна Хэрэглэгчийн тухай хууль (*'Code de la consommation'*), Мөнгө, санхүүгийн тухай хууль (*'Code monétaire et financier'*), Оюуны өмчийн тухай хууль (*'Code de la propriété intellectuelle'*), Даатгалын тухай хууль (*'Code des assurances'*) зэрэг нь хууль худалдааны эрх зүйн эх сурвалжид хамаарна.

(2) Олон улсын гэрээ

Олон улсын худалдаа XIX зууны сүүлч, XX зууны турш цэцэглэн хөгжсөнтэй уялдан хэд хэдэн олон улсын гэрээ батлагдсан байдгаас Франц улсын хувьд үйлчилдэг гэрээ, хэлэлцээрээс дурдвал:

- Францын дотоодын хууль тогтоомжтой зэрэгцэн оршиж, зөвхөн олон улсын харилцаатай холбоотой асуудлыг зохицуулахад үйлчилдэг “Агаарын тээврийн тухай Варшавын конвенц” (1929), “Бараа худалдах-худалдан авах тухай олон улсын гэрээний тухай Венийн конвенц” (1980) зэрэг олон улсын гэрээ;
- Дотоод болон гадаад харилцааг давхар зохицуулдаг “Аккредитив ба векселийн тухай 1930 оны Женевийн конвенц” зэрэг олон улсын гэрээ багтана.

(3) Европын Холбооны гэрээ, хэлэлцээр, Европын Холбооны эрх зүй

Европын Холбоог үүсгэн байгуулахтай холбоотой гэрээ, хэлэлцээрүүдээс Францын худалдааны эрх зүйн хүрээнд хамгийн чухал ач холбогдолтой гэрээг дурдвал Европын эдийн засгийн нийгэмлэг байгуулах тухай Ромын гэрээ (1957), Европын холбоо үүсгэн байгуулах тухай Маастрихтын гэрээ (1992)⁶⁰, Лисбоны гэрээ (2007) юм.

Дээрх гэрээ хэлэлцээрт заасан үндсэн зорилго, чиг үүргийн биелэлтийн хангах зорилгоор баталсан Европын Холбооны хууль тогтоомж нь Францын худалдааны эрх зүйн эх сурвалж болохоос гадна Европын парламент, Европын Зөвлөл зэрэг Европын Холбооны байгууллагуудаас гаргасан тогтоол, шийдвэр нь (“реglement”, “directive”) нь мөн уг эх сурвалжийг бүрдүүлдэг.

⁵⁸Тухайлбал Бельги, ХБНГУ нь Иргэний хууль, Худалдааны хууль гэсэн хоёр тусдаа хууль баталсан байдаг бол Канадын Кебек муж, Швейцарь, Нидерланд, Итали зэрэг улсууд иргэний эрх зүй, худалдааны эрх зүйг нэгтгэж нэг хууль баталсан байдаг байна.

⁵⁹*Michel Pédamon, Hugues Kenfack, Droit commercial*, p.14, no.11(2015)

⁶⁰Маастрихтын гэрээгээр Европын Эдийн засгийн нийгэмлэгийг өөрчилж, Европын Нэгдэл хэмээх одоогийн нэршлийг өгсөн.

Европын Холбооны хууль тогтоомж нь гишүүн орон бүрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд чухал байр суурь эзлэх болсон бөгөөд Францын хувьд эдгээр нь ерөнхийдөө үндэсний хуулиас давуу хүчин чадалтай байдаг.⁶¹

4.2. Зан заншлын хэм хэмжээ (*“usages et coutumes”*)

Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн салбар ямагт хурдацтай шинэчлэгдэн хөгжиж байдаг тул төрөөс тухай бүр тохирсон, цагийг нь олсон хууль тогтоомжийг тэр бүр баталж амждаггүй. Иймээс худалдааны эрх зүйн салбарт бичмэл бус эх сурвалж буюу зан заншлын хэм хэмжээ чухал үүрэг гүйцэтгэсээр иржээ.

Францын худалдааны эрх зүй дэх зан заншлын хэм хэмжээг (1) худалдааны практик (*usages*), (2) худалдааны заншил (*coutumes*) нь хоёр ангилдаг. Эдгээр нь үйлчлэх зарчим, нотолгоо зэргийн хувьд хоорондоо ихээхэн ялгаатай.

(1) Худалдааны практик (*usages*)

Худалдааны практик гэж тухайн ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг хэлнэ. Худалдааны практикийн үйлчлэх хүрээ төрөл бүр байдаг. Олон улсын эсвэл орон нутгийн шинж чанартай худалдааны практик байхад зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн хувьд үйлчилдэг худалдааны практик байж болно.

Тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй этгээд холбогдох худалдааны практик үйлчилдэг болохыг мэдэж байгаад тооцдог бөгөөд энэ талаар дуугүй байсныг тухайн худалдааны практикийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.⁶² Харин өөр салбарын худалдаа эрхлэгч болон худалдаа эрхлэгч бус этгээдийн хувьд хүчин төгөлдөр үйлчлэх нөхцөл нь тэдгээр этгээд шууд ба шууд бусаар хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай.

Худалдааны практик ба хууль: Диспозитив хэм хэмжээ агуулсан хуулиас өөрөөр заасан худалдааны практик хүчин төгөлдөр үйлчилнэ. Тухайлбал худалдааны эрх зүйн худалдах, худалдан авах гэрээний хувьд Иргэний хуулийн 1184-р зүйл үйлчлэхгүй байх тохиолдол бий⁶³. Харин императив шинжтэй хууль нь худалдааны практикаас давуу хүчин чадалтай байна.

Худалдааны практикийг зөв хэрэглэсэн эсэхийг Францын Дээд Шүүхээс хянадаггүй.

(2) Худалдааны заншил (*coutumes*)

Худалдааны заншил нь нэг төрлийн бүх хэлцлийн хувьд нийтлэг байдлаар үйлчилдэг бөгөөд тухайн заншлыг хэрэглэх талаар талууд урьдчилан харилцан тохирсон байх шаардлагагүй, Дээд Шүүхээс зөв хэрэглэсэн эсэхийг хянадаг, мөн тодорхой санкцтай байдгаараа худалдааны практикаас ялгаатай.

Худалдааны заншил ба хууль: Диспозитив хуулийн адил хүчин чадалтай бөгөөд зарим үед императив хуулийг зөрчсөн бол худалдааны заншлийг баримтлах тохиолдол бий⁶⁴.

⁶¹ Францын Үндсэн хуулийн 55 дугаар зүйл

⁶² Дээд Шүүх (Req.) 1900 оны 5 сарын 23-ны шийдвэр (D.1901)

⁶³ Нийлүүлсэн бараа шаардлагад нийцэхгүй бол Иргэний хуулийн дагуу гэрээ цуцлагдахгүй, харин барааны үнийг бууруулах худалдааны практик үйлчилнэ (дээр дурдсан Дээд Шүүх (Req.) 1900 оны 5 сарын 23-ны шийдвэр)

⁶⁴ Тухайлбал Францын Дээд шүүхийн Худалдааны танхимийн 1991 оны 5 сарын 22-ны шийдвэр

Франц улсад банк болон даатгалын харилцаанд худалдааны заншил чухал үүрэг гүйцэтгэдэг байна.⁶⁵

4.3. Шүүхийн шийдвэр (“jurisprudence”)

Францын эрх зүйн тогтолцоонд “jurisprudence” гэж тус улсын шүүхээс гаргасан шүүхийн цогц шийдвэрийг хэлдэг бөгөөд шүүхийн шийдвэр эрх зүйн эх сурвалж болох эсэх асуудал нь тус улсын хувьд эсрэг, тэсрэг байр суурь бүхий маргаан дагуулсан, бидний судалж буй сэдвээс хальсан, онолын томоохон асуудал учир энд дэлгэрүүлээгүй болно.⁶⁶ Харин шүүхийн шийдвэр эрх зүйн эх сурвалж болдог гэсэн онолыг баримталсан болно.⁶⁷

Худалдааны эрх зүйн салбарт шүүх нь хуулийг бүтээлчээр тайлбарлаж хурдацтай өөрчлөгдөн хөгжиж буй эдийн засагт тохируулан хэрэглэх зэргээр иргэний эрх салбарт гүйцэтгэдэг шиг онцгой үүрэг гүйцэтгэдэг байна. Тухайлбал XIX зууны сүүлч, XX зууны эхээр шударга бус өрсөлдөөний онолыг шүүх уг чиг үүргийнхээ хүрээнд анх боловсруулж хэрэгжүүлсэн байдаг.

4.4. Институцийн гаралтай эх сурвалж

Институцийн гаралтай эх сурвалжид төрийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан төрөл бүрийн дүрэм, журам, эрх зүйн акт багтдаг.

5. Иргэний эрх зүйн суурь зарчим ба Худалдааны эрх зүйн тусгайлсан зарчим, эдгээрийн хуульд туссан байдал

5.1. Иргэний эрх зүйн суурь зарчмууд

1804 оны Иргэний хуульд гэрээний эрх зүйн суурь зарчмуудыг тодорхой зааж оруулаагүй байсан бөгөөд одоогийн мөрдөж буй зарчмууд нь Иргэний хууль тайлбарлан хэрэглэх явцад шүүхийн практикийн үр дүнд бий болсон гэдэг. Харин 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр эдгээр зарчмыг хэсэгчлэн хуульчилжээ.

2016 онд Иргэний хуульд оруулсан гол нэмэлт өөрчлөлтүүдийн нэг нь гэрээний эрх зүйн үндсэн зарчмууд болох гэрээний эрх чөлөө (ФИХ-ийн 1102-р зүйл), гэрээг заавал мөрдөх зарчим⁶⁸ (ФИХ-ийн 1103-р зүйл), шударга байх зарчим⁶⁹ (ФИХ-ийн 1104-р зүйл)-ийг Иргэний хуульд “Удиртгал зүйл” гэсэн шинэ бүлэг болгон нэмж оруулсан явдал юм. Эдгээр нь шинээр тунхагласан зарчмууд биш бөгөөд өмнө Иргэний хуульд тусгагдсан эсвэл практикт хэрэглэж заншсан зарчмууд юм.

5.2. Худалдааны эрх зүйн тусгайлсан зарчмууд

⁶⁵ Коммерческое (торговое) правозарубежных стран, Москва Юрайт издательство, 2014, С.94

⁶⁶ Одоогийн хууль тогтоомжийн хүрээнд, онолын үүднээс (эрх мэдэл хуваарилалтын зарчим, Францын Иргэний хуулийн 5-р зүйл, мөн 1355-р зүйл) авч үзвэл шүүхийн шийдвэр нь эрх зүйн эх сурвалж бус мэт боловч практик дээр эх сурвалж болдог гэж үздэг.

⁶⁷ *François Terré, Droit civil, Les obligations, no.11, p. 15 (2005); Michel Pédamon, Hugues Kenfack, Droit commercial, p.8, p.23 (2015)*

⁶⁸ Force obligatoire du contrat

⁶⁹ Bonne foi

Худалдаа, аж үйлдвэрийн чөлөөт байдлын зарчим⁷⁰ нь худалдаа, аж ахуйг чөлөөтэй сонгох эрх чөлөө, сонгосон худалдаа, аж ахуйгаа чөлөөтэй удирдан явуулах эрх чөлөө гэсэн хоёр төрлийн эрх чөлөөг илэрхийлдэг. Францын Үндсэн хуулийн зөвлөлөөс⁷¹ уг зарчмыг үндсэн хуулийн зарчим гэж үзсэн.⁷² Гэхдээ зарим иргэн, хуулийн этгээдийн (эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээд, татварын гэмт хэрэгт холбогдож байсан этгээд, дампуурал зарлаж байсан этгээд, тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг этгээд зэрэг) худалдаа эрхлэх эрхийг хязгаарласан байдгаас гадна зарим төрлийн үйл ажиллагааг хориглодог зэрэг нь дээрх эдийн засгийн эрх чөлөө нь хязгааргүй эрх чөлөө бус болохыг харуулж байна. Францын Үндсэн хуулийн зөвлөлөөс худалдаа, аж үйлдвэрийн чөлөөт байдлын зарчмыг хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно гэж шийдвэрлэсэн байдаг.⁷³

Нотолгооны хувьд Францын худалдааны эрх зүйд нотлох баримтыг чөлөөтэй бүрдүүлэх зарчмыг баримталдаг.⁷⁴

Түүнчлэн Европын Холбооны эрх зүйн худалдаатай холбоотой зарчмууд худалдааны эрх зүйн зарчимд тооцогддог⁷⁵. Үүнд Европын Холбооны гишүүн аль ч улсад бизнесийн үйл ажиллагаа явуулах эрх чөлөө (Европын Холбооны үйл ажиллагааны гэрээний ('TFUE') 49-55 зүйл), үйлчилгээ үзүүлэх эрх чөлөө (Европын Холбооны үйл ажиллагааны гэрээний 56-62 зүйл) зэрэг багтана.

5.3. Иргэний эрх зүйн зарчимтай хавсарч хэрэглэх тухайд

Худалдааны эрх зүйн зарим үндсэн ухагдахуун, суурь зарчмууд тухайлбал үүрэг, эд хөрөнгийн талаарх зохицуулалт, хуулийн этгээдийн ойлголт зэрэг нь Иргэний хуульд суурилсан байдаг.

Түүнчлэн тухайн асуудлыг Францын Худалдааны хууль болон бусад хууль, заншлын хэм хэмжээгээр зохицуулаагүй байвал Иргэний хуулийн хэм хэмжээ үйлчилнэ.⁷⁶ Өөрөөр хэлбэл эдгээр хуулиуд нь харилцан бие биенээ нөхөж байдаг. Тухайлбал Иргэний хуулийн 1832-р зүйлд бүх аж ахуйн нэгж, компанид үйлчлэх зохицуулалтыг тусгасан байдаг бол Худалдааны хуульд зөвхөн худалдааны компанитай холбоотой зохицуулалтыг тусгасан байдаг.

⁷⁰ Худалдаа, аж үйлдвэрийн чөлөөт байдлын зарчмыг Францын хувьсгалын үед буюу 1791 оны 3 дугаар сарын 2-17-ны өдрийн хуулиар тунхаглаж байжээ.

⁷¹ 'Conseil Constitutionnel'

⁷² Францын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр (1982 оны 1 дүгээр сарын 16) (DC 82-141)

⁷³ Францын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр (1986 оны 1 дүгээр сарын 16) (DC 86-200)

⁷⁴ Худалдааны хуулийн L110-3-р зүйл

⁷⁵ *Georges Decocq, Aurélie Ballot-Léna, Droit commercial*, p.133 (2013).

⁷⁶ *Michel Pédamon, Hugues Kenfack, Droit commercial*, p.14 (2015)

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Арилжааны хуулийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны хүрээнд Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалт нь Арилжааны эрх зүйн талаарх зохицуулалтыг агуулсан эсэх, арилжааны эрх зүйн зарчмыг бүрэн дүүрэн тусгасан эсэх талаар судаллаа. Энэхүү судалгааны үр дүнд манай улсын Иргэний хууль нь монист систем буюу тодорхой төрлийн гэрээний зохицуулалт болон үүргийн эрх зүйн ерөнхий зохицуулалтад арилжааны эрх зүйн шинж бүхий зохицуулалтыг агуулж байна гэж үзлээ.

Гэсэн хэдий ч аж ахуй үйл ажиллагааны талаарх нэгдсэн зохицуулалт байхгүй, дийлэнх зохицуулалт нь иргэн, аж ахуй эрхлэгчийн харилцааны ялгамжтай шинжийг агуулгаагүй буюу нийтлэг зохицуулалттай болох нь тодорхой байна. Тухайлбал, итгэмжлэлээр төлөөлөх болон аж ахуйн үйл ажиллагаанд төлөөлөх зохицуулалт байхгүй ба аж ахуй эрхлэгчийн бүртгэлийг зөвхөн хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэгчээр хязгаарлаж байна.

Ийнхүү ялгамжтай зохицуулаагүйгээс арилжааны суурь зарчим болох хэлцэл түргэн, шуурхай, баталгаатай байх, аж ахуй эрхлэгчийн хооронд маргаан үүсч, улмаар аж ахуйн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлнэ. Түүнчлэн аж ахуй эрхлэгчийг төлөөлөх эрхтэй этгээд мөн эсэхээс хамааран хийсэн гэрээ, хэлцлийн баталгаат байдал алдагдах, тодорхой хугацааны дараа хэлцэл хүчин төгөлдөр бус болсноор шударга гуравдагч этгээдийн хувьд эдийн засгийн хохирол хүлээх, хэлцлийн баталгаат байдлыг хангахын тулд мэдээлэл цуглуулах, шалгах зэргээр мөнгөн болон мөнгөн бус зардлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг талтай.

Иймд манай улстай адил эх газрын эрх зүйн системтэй улсуудын иргэний болон арилжааны талаарх эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд дийлэнх улсуудын хувьд бие даасан Арилжаа /Худалдаа/-ны хуулийг батлах замаар иргэн болон аж ахуй эрхлэгчийн харилцааны онцлогоос хамааран ялгамжтай зохицуулж байгаа тул манай улсын хувьд ч одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд иргэн болон аж ахуй эрхлэгчийн харилцааг ялгамжтайгаар зохицуулах шаардлага үүссэн гэж дүгнэлээ.

Ийнхүү ялгамжтай зохицуулахад субъектив, объектив, холимог гэх гурван онол байх ба улс орнууд аль аль онолыг баримталдаг жишиг байна. Харин манай улсын хувьд иргэн, аж ахуй эрхлэгчийн харилцааг ялгамжтайгаар зохицуулах шаардлага байгаа хэдий ч аль болох ойлгомжтой бөгөөд хэрэглэгдэх боломжтойгоор хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй байна. Үүний тулд судалгааны багийн зүгээс субъектив онолыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байгааг тэмдэглэн хуулийн төсөл боловсруулахад дараах зүйлсийг тусгах шаардлагатай.

Хуулийн төсөлд тусгагдах зүйлс

- Аж ахуй эрхлэгчийн ойлголт, хамрах хүрээ;
- Аж ахуй эрхлэгчийн бүртгэл;
- Аж ахуй эрхлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үндэс;
- Аж ахуй эрхлэгчийн ангилал /тодорхой үнийн дүнгээс хамааран зарим зохицуулалт үйлчлэхгүй байх/;
- Аж ахуй эрхлэгчийн нэр, түүнийг шилжүүлэх, түрээслүүлэх, бүртгүүлэх асуудал ба хариуцлага;

- Аж ахуй эрхлэгчийн хүлээх нийтлэг үүрэг;
- Аж ахуйн харилцаанд төлөөлөх;
- Аж ахуй эрхлэгчийн хийх хэлцлийн ерөнхий ба тусгай зохицуулалт /үүнд: хөөн хэлэлцэх хугацаа, гэрээ байгуулах арга хэлбэр, гэрээний зүйлийг хадгалах үүрэг, гэрээ байгуулсанд тооцох, шалгах үүрэг, гэрээ байгуулах зардал, гэрээний баталгаат байдлыг хангах, аж ахуй эрхлэгчийн анхаарал болгоомжтой байх үүрэг, өрсөлдөхгүй байх үүрэг г.м/;
- Гэрээний тусгай төрлүүд ба онцлог;

Хавсралт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхалтыг хориглож буй зохицуулалт агуулаагүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Зөвхөн аж ахуй эрхлэгчид хамаарах зохицуулалт бий болгох боловч энэ нь ялгаварлаж буй зохицуулалт биш болно. Учир нь иргэд хоорондын хэлцлийн зохицуулалт Иргэний хуулиар зохицуулагдана.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажуулсан иргэн болон хуулийн этгээдийн аж ахуй эрхлэх эрх зүйн орчин сайжирч, зорилтод бүлэгт хүрэх хүртээмж нэмэгдэнэ.

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн. Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	- Аж ахуй эрхлэгч - Ашгийн төлөө хуулийн этгээд - Хувиараа аж ахуй эрхлэгч
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Аж ахуй эрхлэгчийн хүлээх үүргийг нэмэгдүүлнэ.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	

хуульд нийцүүлсэн эсэх	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Аж ахуй эрхлэгч иргэн, хуулийн этгээд бүгдэд хамаарна.
---------------------------	---	------	------	---

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Аж ахуй эрхлэгчдийн хүлээх үүргийг нэмэгдүүлснээр бизнесийн өрсөлдөөн нэмэгдэж, хэлцэл түргэн, шуурхай явагдана.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Энэ чиглэлээр зохицуулалт агуулаагүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж	Тийм	Үгүй	Аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэхгүй.

болон захиргааны зардал	ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх			
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал үүсэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны нэр, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Арилжааны нэрийн зохицуулалтыг бий болгосноор оюуны өмчийн эрхийн хамгаалалтад хамааруулж арилжааны нэрийг шилжүүлэх, түрээслэх, дамжуулах замаар эдийн засгийн эргэлтэд оруулна.
6.Инноваци болон	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

судалгаа шинжилгээ	шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх			
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Жижиг, дунд хэмжээний үйлдвэр, бизнес эрхлэгчийн хүлээх үүргийг хөнгөвчлөх замаар тэдэнд үүсэх зардлын ачааллыг бууруулна.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Арилжаа эрхлэгчийн бүртгэлийн тогтолцоог бий болгож, татвар төлдөггүй аж ахуй эрхлэгчид татвар төлөх нөхцөл бүрдснээр улсын төсвийн орлого нэмэгдэнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх	Тийм	Үгүй	

	шаардлага тавигдах эсэх			
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Арилжаа эрхлэгчийн бүртгэлийн системийг бий болгоно. Одоогийн хуулийн этгээдийн улсын бүртгэл дээр хувиараа аж ахуй эрхлэгчийн бүртгэлийн тогтолцоог нэмж бий болгоно.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Аж ахуйн харилцааг түргэн, шуурхай, баталгаатай явагдах нөхцөлийг бий болгосноор эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөг үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхийг дагалдаад ажлын байр нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэх, арилжааны нэр ашиглах боломжийг бий болгоно.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Арилжаа эрхлэгчийн төлөөлөгчийн зохицуулалтыг бий болгосноор аж ахуй эрхлэгчтэй гэрээ байгуулж буй этгээдийн эрх ашгийг хамгаална.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Бүртгэлийн байгууллагын чиг үүргийг өргөжүүлнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг багасгаснаар аж ахуй эрхлэгчийн хүлээх үүрэг нэмэгдэж, илүү хариуцлагатай байх ёстой.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй..
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй..

	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..

	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөөлөө байхгүй..